


ЖИЛИЙН
ТАЙЛАН **2015**

 **ГОЛОМТ БАНК**
Сайн сайхныг санхүүжүүлнэ



Агуулга

Эрхэм зорилго, алсын хараа	3
ТУЗ-ийн даргын мэндчилгээ	4
Удирдлагын багийн мэндчилгээ	6
Монгол Улсын 2015 оны эдийн засгийн тойм	10
Эдийн засгийн өсөлт	
Инфляци	
Гадаад худалдаа	
Мөнгө санхүүгийн үзүүлэлтүүд	
Улсын төсөв	
Банкны системийн 2015 оны төлөв байдал	14
Голомт банкны 2015 оны санхүүгийн үзүүлэлт	18
Голомт банкны засаглалын тайлан	22
Засаглалын тогтолцоо	
Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн	
ТУЗ-ийн бүрэлдэхүүн	
Байгууллагын бүтэц, зохион байгуулалт	
Удирдлагын баг	
Голомт банкны амжилтын товчоон	30
Иргэдийн зах зээл	
Байгууллагын зах зээл	
Хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа	
Хүний нөөцийн хүрээнд хийгдсэн гол ажлууд	
Технологийн хүрээнд хийгдсэн гол ажлууд	
Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн гол ажлууд	
Харилцагч банкууд	48
Худалдааны санхүүжилтээр хамтран ажиллагч банк санхүүгийн байгууллагууд	
Эрсдэлийн удирдлага	52
Эрсдэлийн удирдлагын тогтолцоо	
Эрсдэлийн засаглал	
Зээлийн эрсдэлийн удирдлага	
Зах зээлийн эрсдэлийн удирдлага	
Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага	
Актив, пассивын хосолсон удирдлага	62
Аудитын тайлан	63
Салбарын хаягууд	152



Эрхэм зорилго

Хөгжлийн-Голомт

*Бид нийгмийн хөгжлийн тулгуур нь байж
сайн сайхныг түгээж ажилладаг.*

Алсын хараа

*Дэлхийд өрсөлдөх
Монголын банк болно.*

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргын мэндчилгээ



Эх орныхоо хөгжлийн голомт нь байх эрхэм үүргээ нэр төртэйгээр биелүүлж ирсэн Голомт банкны хамт олны амжилт бүтээлээр жигүүрлэсэн түүхт 20 жилийн ой 2015 онд тохиосон юм.

Голомт банк нь 1995 онд үүсгэн байгуулагдахдаа 4 ажилтан, 436 сая төгрөгийн дүрмийн сантайгаар үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 2015 онд банкны нийт актив 3,6 их наяд төгрөгт хүрч, 1867 ажилтан албан хаагчтай болж өргөжин тэлжээ. Энэхүү өсөлтийн түүхээ бид ирэх жилүүдэд улам бататгаж, дэлхийн энтэй банк байх эрхэм зорилтыг өмнөө тавин ажиллах болно.

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түнш байгууллагууд, ажиллагсдаа

2015 онд Монгол Улсын арилжааны ууган банкуудын нэг болох Голомт банк үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ой тохиосон бөгөөд энэхүү түүхэн тэмдэглэлт жилд бидний бүтээсэн амжилт ололт, үйл ажиллагааныхаа дээжээс та бүхэнд тайлагнахаар мэндчилж байгаадаа баяртай байна.

Голомт банкны урт удаан, үр ашигтай ажиллах үндэс нь байгууллагын зөв соёл байдаг тул бид зохистой засаглалын шилдэг туршлагыг нэвтрүүлж хэрэгжүүлэхэд өндөр ач холбогдол өгч, тогтмол сайжруулан ажилласаар ирсэн. 2015 онд бид энэхүү зорилтынхоо хүрээнд хяналтын тогтолцоогоо илүү боловсронгуй болгож ажиллалаа.

Хэдийгээр 2015 онд Монгол Улсад төдийгүй дэлхий дахинд нийгэм эдийн засгийн нөхцөл байдал тогтворгүй, уналт ихтэй байсан ч Голомт банкны хувьд стратеги бодлогоо зөв тодорхойлж ажилласны үр дүнд 2015 оныг амжилттай үдлээ.

Банк хэмээх санхүүгийн онцлог байгууллагын оршин тогтнох үндэс нь эрхэм харилцагчдынхаа хамгийн үнэт чанар болох итгэл байдаг тул найдвартай аюулгүй байх нь хамгийн чухал үзүүлэлтүүдийн нэг юм. Өнгөрсөн онд Голомт банк нь хамгийн найдвартай үйл ажиллагаатай банк гэдгээ бататгаж өөрийн хөрөнгийн хүрэлцээг Монголбанкны шалгуур босгоос 2 пунктээр өндөр байлгаж ажиллалаа. Мөн Монголбанкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 25 хувь байдаг бол бид энэхүү үзүүлэлтийг бүтэн жилийн турш 35 хувиас доошгүй барьж, 2015 оны эцсийн байдлаар 38.1 хувь гэсэн үзүүлэлттэй гарсан нь хамгийн найдвартай банк гэсэн байр сууриа дахин нотолсон явдал байсан юм. Бид дотоод харилцагч нарынхаа итгэл хүндэтгэлийг хүлээгээд зогсохгүй гадны түнш байгууллагуудын хүрээгээ ч тэлж чадлаа. Тодруулбал 2015 онд бид дэлхийд үйл ажиллагаагаараа танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн нийт 70 гаруй банк санхүүгийн байгууллагуудтай өргөн хүрээнд нягт хамтран ажиллалаа.

Зохистой компанийн засаглалыг хөгжүүлсэн алхам

Байгууллагын зохистой засаглалыг боловсронгуй болгон хөгжүүлж, олон улсын шилдэг туршлагыг албан ёсоор нэвтрүүлэхийн тулд бид Олон улсын санхүүгийн байгууллагын Компанийн засаглалын зөвлөх үйлчилгээг авах бүтэн жилийн төслийг амжилттай эхлүүлээд байна. Энэхүү төслийн үр дүнд бид зохистой засаглалын соёлоо

дараагийн түвшинд гаргаж, салбартаа манлайлагч болж үйл ажиллагаа маань улам бүр батжин хөгжих болно гэдэгт итгэлтэй байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс санаачлан Гүйцэтгэх удирдлагын багийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг шинэчлэн баталж, гүйцэтгэлтэй шууд холбоотой урамшууллын системийг бодит болгож ажиллалаа. Мөн анх удаа Төлөөлөн Удирдах Зөвлөл нь өөрийн үйл ажиллагааны үнэлгээг хийх аргачлалыг баталж, өөрсдийн ажлыг бодитой дүгнэх, Хөрөнгө оруулагчиддаа тайлагнах цогц тогтолцоотой боллоо.

Зохистой засаглалын цөмд орших дотоод хяналтын тогтолцоогоо сайжруулахаар бид Дотоод аудитын газрын үйл ажиллагаанд ихээхэн анхаарч, олон улсын шилдэг жишгээр тус газрыг жинхэнэ утгаар нь хараат бус болгон төлөвшүүлж, эрсдэлд суурилсан процессын хяналт, шалгалтыг хийдэг болгон хөгжүүлсэн.

Эрсдэлгүй найдвартай банк

Монгол Улсын эдийн засгийн орчин, гадаад дотоод хүчин зүйлсийн нөлөөгөөр мөнгөний эргэлт багасч, санхүүгийн байгууллагуудад эрсдэл үүсэх аюул ихэссээр байгаа энэ үед Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зүгээс банкний хамгийн найдвартай шуурхай үйл ажиллагаатай байлгах нь бидний гол зорилтуудын нэг юм. Иймд санхүүгийн үзүүлэлтүүдээс гадна үйл ажиллагааны эрсдэл зэрэг бүх төрлийн эрсдэлийг бууруулахын тулд бид дотоод хяналтаа сайжруулахад ихээхэн анхаарч ажиллалаа.

Үүний үр дүнд Голомт банкны үйл ажиллагаандаа мөрддөг бодлого, баримтуудыг шинэчлэв. Үүнээс онцлон дурьдвал Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Голомт банкны Комплаенсийн бодлого, Зээлийн эрсдэлийн үнэлгээний бодлого болон Эрсдэлийн удирдлагын бодлогоо шинэчлэн баталсан явдал юм.

Тодруулбал, банкир бүр эрсдэлийн менежер болсноор банкны үйл ажиллагаа улам сайжирч, эрсдэлийг багасгаж, ашигт ажиллагааг дэмжих томоохон ахиц дэвшил гарах учиртай.

Ирээдүйн зорилт

Мэдээллийн технологийн хурдацтай хөгжил нь хувь хүний амьдралд төдийгүй үйлчилгээний байгууллагуудад ч асар их өөрчлөлт авч ирж, түүний хажуугаар боломжийг нээн өгч байна.

Голомт банкны хувьд дэлхийн жишгээр мэдээлэл технологийн хөгжилд тулгуурласан бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэлтээрээ Монголын банк санхүүгийн зах зээлд ямагт анхдагч байж, орчин үеийн хөгжил дэвшил бүртэй мөр зэрэгцэн алхаж ирснээрээ бахархдаг.

Энэхүү зөв хэмнэлээ бид алдалгүйгээр технологийн дэвшилтэй хамтран алхаж харилцагч төвтэй бизнес моделийг хэрэгжүүлэхээр томоохон төслүүдийг санаачлан хэрэгжүүлж эхлээд байна. Эдгээр төслүүд нь Голомт банкны үйл ажиллагааг улам сайжруулж, Монголын шилдэг банк гэсэн амжилтаа улам бататгана гэдэгт итгэлтэй байна.

Дэлхийд өрсөлдөх Монголын банк байх эрхэм зорилтын төлөө сэтгэл зүрх, эрдэм мэдлэг, авъяас чадвараа зориулсан нийт Голомтчууддаа болон бидэнд итгэл хүлээлгэсэн хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түншүүд, хамтран ажилласан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүддээ гүн талархал илэрхийлэхийн ялдамд ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе!

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга

Ч.МӨНХЦЭЦЭГ

Монголбанкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 25 хувь байдаг бол бид энэхүү үзүүлэлтийг бүтэн жилийн турш 35 хувиас доошгүй барьж, 2015 оны эцсийн байдлаар 38.1 хувь гэсэн үзүүлэлттэй гарсан нь хамгийн найдвартай банк гэсэн байр сууриа дахин нотолсон явдал байсан юм.

Удирдлагын багийн мэндчилгээ

2015 онд Голомт банк найдвартай, ил тод үндэсний банкны нэр хүндээ бататгаж амжилттай ажиллалаа. Харилцах, хадгаламжийн хэмжээ өнгөрсөн оны түвшинд буюу 2 их наяд гаруй төгрөгт хадгалагдаж, нийт банкны системийн 25 орчим хувийг эзэлж, тэргүүлэгч байр сууриа хадгалсан ба 2015 онд өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг 17 орчим хувьд хүргэснээр сүүлийн 3 жил дараалан өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хоёроос дээш нэгж хувиар давуулан биелүүлээд байна.



Гүйцэтгэх захирал
Л. ОЮУН-ЭРДЭНЭ



Ерөнхийлөгч
Ө. ГАНЗОРИГ

Эрхэм Харилцагч, Түнш байгууллага таны энэ өдрийн амгаланг айлтгая

Бидний түүхт 20 жилийн амжилтыг бүтээлцсэн, бүтээлцэж буй эрхэм харилцагч, түнш байгууллага та бүхэндээ 2015 оны ололт амжилт, ажлын үр дүнгээ хуваалцахын хамт санхүүгийн тайлангаа хүргэж байгаадаа баяртай байна.

Монгол Улсын эдийн засгийн дунд болон урт хугацааны төлөв өөдрөг хэвээр байгаа хэдий ч 2015 он гарсаар эдийн засгийн өсөлт хурдтайгаар саарлаа. Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн эрэлт буурч, үнийн таагүй хандлага үргэлжилж, худалдааны түнш орнуудад эдийн засгийн өсөлт саарч, гадаадын шууд хөрөнгө оруулалт татарсан нь Монголын эдийн засагт сайнгүйгээр нөлөөлж байна.

Ийм эдийн засгийн орчинд Голомт банк найдвартай, ил тод үндэсний банкны нэр хүндээ бататгаж амжилттай ажиллалаа. Харилцах, хадгаламжийн хэмжээ өнгөрсөн оны түвшинд буюу 2 их наяд гаруй төгрөгт хадгалагдаж, нийт банкны системийн 25 орчим хувийг эзэлж, тэргүүлэгч байр сууриа хадгалсан ба 2015 онд өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг 17 орчим хувьд хүргэснээр сүүлийн 3 жил дараалан өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хоёроос дээш нэгж хувиар давуулан биелүүлээд байна.

Голомт банк нь урт хугацааны тогтвортой хөгжлийг эрхэмлэн ажилладаг бөгөөд өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдалд эрсдэл болон өгөөжийн харьцааг хамгийн оновчтой байлгахад чиглүүлэн, Эрсдэлийн санг НББОУСЗ9 дагуу хангалттай түвшинд байгуулсан нь эрсдэл даах чадвараа улам бэхжүүлсний илэрхийлэл юм.

Өнгөрсөн онд Олон улсын санхүүгийн корпорацийн хамтран Компанийн зохистой засаглалыг сайжруулах төслийг амжилттай хэрэгжүүлж эхлээд байна. Төслийн үр дүнд Голомт банк нь олон улсын стандартад нийцсэн зохистой засаглалын тогтолцоогоо улам боловсронгуй болгох юм. Мөн олон улсын тэргүүн туршлагыг тусгасан Комплаенсийн бодлого, Зээлийн эрсдэлийн үнэлгээний бодлогуудыг ТУЗ-өөр батлуулан үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Банкныхаа 20 жилийн ойгоор бид олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа өргөжүүлсний үр дүнд 100 сая ам.долларын санхүүжилтийг авсан нь банкны хувьд томоохон амжилт төдийгүй Монгол Улсын эдийн засагт чухал нөлөө үзүүлсэн юм. Голомт банк нь олон улсын нэр хүнд бүхий 70 гаруй банк санхүүгийн байгууллагатай нягт хамтран ажилладаг бөгөөд 2015 онд зах зээлийн өртгөөс доогуур, өрсөлдөхүйц үнэтэй 55 сая ам.доллар орчим зээлийг дотоодын компаниудад дамжуулан зээлдүүлж харилцагчиддаа бодит дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Мөн андеррайтерийн үйл ажиллагааныхаа хүрээнд Монгол Улсад анх удаа хувийн компанийн 100 хувь даатгагдсан Эрчим бондыг Монголын хөрөнгийн зах зээл дээр гаргаж хагас тэрбум төгрөгийн хөрөнгө босгоод байна.

Санхүүгийн зах зээлд оролцогч болж, хувьцаа, бонд, валют арилжаалан тодорхой өгөөж хүртэх хүсэлтэй харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад тохируулан түүхий эдийн үнийн өөрчлөлтөөр хүү нь хувьсах хадгаламжийн цоо шинэ бүтээгдэхүүн болох Гибрид хадгаламжийг бид зах зээлд санал болголоо.

Тайлант хугацаанд санхүүгийн байгууллагын програм хангамжаар дэлхийд тэргүүлэгч Nomura Research Institute-тэй хамтран Кастодиан банкны систем нэвтрүүлээ. Ингэснээр Голомт банк харилцагчийн үнэт цаас, санхүүгийн бусад хөрөнгийг найдвартай хадгалж, өмчлөх эрхийг баталгаажуулах, үнэт цаасны төлбөр тооцоо, компанийн үйл ажиллагаа, орлого цуглуулалт, татварын тооцоолол зэрэг хөрөнгийн зах зээлийн арилжааны мэргэшсэн цогц үйлчилгээг бүрэн хэмжээгээр үзүүлж ажиллаж эхлээд байна.

2015 онд Голомт банк нь Цамбагарав бизнес төвийн үйл ажиллагаагаа эхлүүлснээр Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгино-Хайрхан дүүргүүд дэх бизнес төвүүдээрээ дамжуулан жижиг, дунд бизнес эрхлэгчдэд нэг цэгийн үйлчилгээг үзүүлж байна.

Түүнчлэн жижиг, дунд бизнес эрхлэгчдийгээ хөгжүүлэх, дэмжин ажиллах цогц бодлогыг тодорхойлох зорилтын хүрээнд 2015 онд 1,500 гаруй жижиг дунд бизнес эрхлэгчдийг хамруулсан зах зээлийн судалгааг хийсэн бөгөөд үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор www.sme.golomtbank.com сайтыг нээсэн билээ. Үүний зэрэгцээ нийт иргэд, харилцагчдынхаа санхүүгийн боловсролыг дэмжих зорилгоор www.edu.golomtbank.com цахим хуудас ажиллуулж эхлээд байна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудаас Голомт банк нь анх удаа Өөртөө үйлчлэх нэгж болон төхөөрөмжид суурилсан орчин үеийн дэвшилтэт шинэлэг үйлчилгээг нэвтрүүлж байсан бөгөөд 2015 онд шинээр Өөртөө үйлчлэх 5-н нэгж нээж, АТМ, СДМ-ын тоог 44-өөр нэмэгдүүлж ажиллалаа.

Харилцагчдын цахим төлбөр тооцооны хэрэглээг өргөжүүлэх зорилготой Цаасгүй банк аяныг амжилттай зохион байгуулснаар интернэт банк хэрэглэгчдийн тоо 20 хувиар, интернэт банкаар хийгдсэн гүйлгээний тоо 110 хувиар тус тус өссөн байна.

Мөн картаар үйлчлэгч байгууллагын (КҮБ) тоо 30 хувийн өсөлттэй байсан бол И-КҮБ-ын тоо 15 хувиар нэмэгдсэн. Кредит картын ач холбогдлын талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, хэрэглээг хэвшүүлэх чиглэлээр дорвитой ажлууд хийгдсэний үр дүнд кредит карт эзэмшигчдийн тоо 55 гаруй хувиар, кредит картаар хийгдсэн гүйлгээний тоо 40 хувиар тус тус өссөн байна.

Бид иргэдийн хадгаламжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд дэмжих зорилготой Үндэсний хуримтлалын хөтөлбөрийг улс даяар хэрэгжүүлэн нийт 23,500 иргэдийг хуримтлалтай болгож ажиллалаа.

Програм хангамжаар дэлхийд тэргүүлэгч Nomura Research Institute-тэй хамтран Кастодиан банкны систем нэвтрүүлээ. Ингэснээр Голомт банк харилцагчийн үнэт цаас, санхүүгийн бусад хөрөнгийг найдвартай хадгалж, өмчлөх эрхийг баталгаажуулах, үнэт цаасны төлбөр тооцоо, компанийн үйл ажиллагаа, орлого цуглуулалт, татварын тооцоолол зэрэг хөрөнгийн зах зээлийн арилжааны мэргэшсэн цогц үйлчилгээг бүрэн хэмжээгээр үзүүлж ажиллаж эхлээд байна.

Монгол Улсын Засгийн газар болон Монголбанкнаас хэрэгжүүлж буй 8+/-1% орон сууцны зээлийн хөтөлбөрт Голомт банк идэвхтэй оролцож, нийт 17,954 өрхийн 849 тэрбум төгрөгийн зээлийг олгосон бөгөөд зөвхөн 2015 оны хувьд 2,355 өрхөд 159 тэрбум төгрөгийн зээлийг олгожээ.

Голомт банк нь үйл ажиллагааныхаа бүхий л түвшинд байгаль орчин, нийгэмд ээлтэй, ил тод бизнесийг дэмжин ажиллах Тогтвортой санхүүжилтийн суурь зарчмуудыг Монголын банкуудын холбоотой хамтран амжилттай баримтлан ажилласан бөгөөд улмаар Тогтвортой санхүүжилтийн бодлогоор манлайлагч банкаар тодорч, 2016 онд бусад банкуудаа манлайлж ажиллах юм.

Цаашид ч даяарчлагдаж буй дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхаж, шинэлэг, шилдэг туршлага бүрийг хамгийн түрүүнд харилцагчиддаа хүргэж, сайн сайхныг санхүүжүүлэн ажиллахаа итгэл төгс илэрхийлье! Ингээд Голомт банкны хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан нийт харилцагч, түнш байгууллагууд болон мөр зэрэгцэн ажиллаж байгаа Голомтчууддаа баярлалаа!

Монгол Улсын 2015 оны эдийн засгийн тойм

2015 онд Монгол Улсын
эдийн засгийн өсөлтийн
хурд саарсан хэдий ч
ДНБ-ий бодит өсөлт
2.3 хувьд хүрч, нэрлэсэн
ДНБ өнгөрсөн оноос 4.2
хувиар өсч 23.1 их наяд
төгрөгт хүрэв.


Эдийн засгийн өсөлт

2015 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хурд саарсан хэдий ч бодит ДНБ-ий өсөлт 2.3 хувьд хүрч, нэрлэсэн ДНБ өнгөрсөн оноос 4.2 хувиар өсч 23,1 их наяд төгрөгт хүрэв.

Дээрх бодит эдийн засгийн өсөлтийн 13 хувь нь уул уурхайн салбарын өсөлтөөр, 10.7 хувь нь хөдөө аж ахуйн салбарын өсөлтөөр, 5.7 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны өсөлтөөр, 2.9 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаагаар тус тус тайлбарлагдаж байна.

Харин бөөний болон жижиглэн худалдаа 3.6 хувь, барилга 1.4 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 21.1 хувиар буурсан нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн.

Бодит ДНБ-ий өсөлт (%)



2015 онд хөрөнгө оруулалт үргэлжлэн хумигдаж, экспортын орлого буурсан нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн бол өрхийн хэрэглээний өсөлт хадгалагдаж, импорт хумигдан цэвэр экспорт нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэв.


Инфляци

Улсын ХҮИ-ээр тооцсон инфляци 2014 онд 11 хувь байсан бол 2015 онд буурч 1.9 хувьд хүрчээ.

Улсын хэмжээнд 2015 оны инфляцийг бүтцээр нь задлан авч үзвэл -2.2 нэгж хувийг хүнсний бүтээгдэхүүн, тэр дундаа мах махан бүтээгдэхүүн, 1.3 нэгж хувийг боловсролын үйлчилгээ, 1.1 нэгж хувийг хувцас, 0.5 нэгж хувийг орон сууц, ус, түлш, цахилгааны үнийн өсөлт бүрдүүлсэн бол үлдсэн 1.2 нэгж хувийг бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлт бий болгосон байна.

Инфляцийн түвшин ийнхүү огцом буурч нам түвшинд хүрсэн нь дотоод эрэлт хумигдаж, эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт буурсан, зуд болно гэсэн хүлээлт бий болсноор махны нийлүүлэлт өсч, үнэ буурсан зэрэг нь мөн нөлөөлөв.

ХҮИ-ийн инфляцийн бүтэц (%)



Гадаад худалдаа

Гадаад худалдааны нийт эргэлт 2015 онд 8,5 тэрбум ам.долларт хүрч өмнөх оноос 23.1 хувиар буурчээ.

Нийт экспорт 19.1 хувиар буурч 4,7 тэрбум ам.долларт, нийт импорт 27.5 хувиар буурч 3,8 тэрбум ам.долларт тус тус хүрчээ. Ингэснээр худалдааны тэнцэл 872,3 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оныхоос 334,6 сая ам.доллар буюу 62.2 хувиар өслөө.


Нийт экспортын бүтцэд эрдэс бүтээгдэхүүн 87 хувийг, ноос ноолуур 5 хувийг тус тус эзэлж байна. Эрдэс бүтээгдэхүүн дотроо мөнгөжөөгүй алтны экспорт 4 хувиар өссөн бол, чулуун нүүрс 35 хувиар, зэсийн баяжмал 11 хувиар, төмрийн хүдэр 49 хувиар, боловсруулаагүй нефть 39 хувиар тус тус буурчээ. Ашигт малтмалын экспортын хувьд зэсийн баяжмал болон боловсруулаагүй нефтийн экспортын тоо хэмжээ өссөн боловч үнийн уналтаас шалтгаалан нийт экспортын орлогод сөргөөр нөлөөлөв.

Нийт импортын хувьд 29 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 38 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 19 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлж байна. Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 12 хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 5 хувийг нефтийн бүтээгдэхүүний бууралт 9 хувийг тус тус эзэлж байна. Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт буурахад машин механизм, тоног төхөөрөмж болон барилгын материалын импорт буурсан нь голлон нөлөөлсөн. Нефтийн импортын тоо хэмжээний хувьд өнгөрсөн оны түвшинд хадгалагдсан ч хилийн үнийн бууралтаас шалтгаалан нийт дүнгээр буурсан.

Нийт экспорт 19.1 хувиар буурч 4.7 тэрбум ам.долларт, нийт импорт 27.5 хувиар буурч 3.8 тэрбум ам.долларт тус тус хүрчээ. Ингэснээр худалдааны тэнцэл 872.3 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оныхоос 334.6 сая ам.доллар буюу 62.2 хувиар өслөө.

Бизнесийн идэвхжил саарч мөнгөний эрэлт хумигдаж байгааг хамгийн өндөр хөрвөх чадвартай М1 (банкнаас гадуурх мөнгө + төгрөгийн харилцах) мөнгөний бууралтаас харж болно.


Нийт экспортын өсөлтийн бүтэц



Мөнгө, санхүүгийн үзүүлэлтүүд

Эдийн засаг дахь нийт мөнгөний нийлүүлэлт буюу М2 мөнгө 2015 онд 10 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 0.6 их наяд төгрөгөөр буюу 5.5 хувиар буурчээ.

Санхүүгийн зах зээлийн мөчлөг



Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн хурд нь 2013 онд 24.2 хувь, 2014 онд 12.5 хувь байсан бол 2015 онд -5.5 хувьд хүрч саараад байна. М2 мөнгөний өөрчлөлтийн 0.2 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, -0.2 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, -4.3 нэгж хувийг гадаад валютын харилцах, -1.2 нэгж хувийг М1 мөнгөний бууралт тус тус тайлбарлаж байна.

Бизнесийн идэвхжил саарч мөнгөний эрэлт хумигдаж байгааг хамгийн өндөр хөрвөх чадвартай М1 (банкнаас гадуурх мөнгө + төгрөгийн харилцах) мөнгөний бууралтаас харж болно.


Банкуудын нийт зээлийн өрийн үлдэгдэл 2014 онд 12,5 их наяд төгрөг байсан бол 2015 онд 11,7 их наяд төгрөгт хүрч 807 тэрбум төгрөгөөр буурчээ. Энэхүү өөрчлөлтийн -1.7 нэгж хувийг аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл, -5.5

нэгж хувийг иргэдийн зээл, үлдсэн 0.7 нэгж хувийг бусад салбарын зээл тайлбарлаж байна. Зээлийн багцын жилийн өсөлт 2014 онд 12.5 хувь байсан бол 2015 онд -6.5 хувьд хүрч саараад байна.

Улсын төсөв

2015 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 5 их наяд 974 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 2.8 хувиар буурсан бол төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 7 их наяд 137 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 1.5 хувиар өсчээ. Ингэснээр төсвийн нийт алдагдал 1 их наяд 163 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 5 хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн байна.

Улсын нэгдсэн төсөв (тэрбум төгрөг)



Нэгдсэн төсвийн орлогын тасралтад импортын барааны татварын орлого, дизелийн түлшний орлогын албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, өмч хувьчлалын орлого тус тус төлөвлөгөөнөөс дутсан нь голлон нөлөөлсөн.

Нэгдсэн төсвийн зарлага 7,253 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 7,136 тэрбум төгрөгийн буюу 98.4 хувийн гүйцэтгэлтэй байв. Төсвийн зарлагыг эдийн засгийн салбараар төрөлжүүлвэл боловсрол, эрчим хүч, хөдөө аж ахуй, тээвэр холбооны салбарын зарлага төлөвлөснөөс бага байсан бол нийтийн ерөнхий үйлчилгээний зардал төлөвлөснөөс хэтэрсэн.

Төсвийн алдагдлын 58 хувийг урт болон богино хугацаат Засгийн газрын бондоор, 32 хувийг гадаад зээл, үлдсэн хувийг дотоод зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн.


2015 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 5 их наяд 974 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 2.8 хувиар буурч, төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 7 их наяд 137 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 1.5 хувиар өсчээ. Ингэснээр төсвийн нийт алдагдал 1 их наяд 163 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 5 хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн байна.

Банкны системийн 2015 оны төлөв байдал


Арилжааны банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээ өмнөх оны мөн үзүүлэлтээс 0,94 тэрбум төгрөгөөр буурч 2,06 их наяд төгрөгийн дүнтэй байна.

2015 оны эцэст арилжааны банкуудын нийт хөрөнгө (татан буугдсан банкуудыг оролцуулснаар) 21,56 их наяд төгрөгийн дүнтэй байна. Энэ нь өмнөх оноос 1,03 их наяд төгрөгөөр буурсан үзүүлэлт юм.

Актив (их наяд төгрөг)




Банкны нөөц (их наяд төгрөг)



Арилжааны банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээ өмнөх оны мөн үзүүлэлтээс 0,94 тэрбум төгрөгөөр буурч 2,06 их наяд төгрөгийн дүнтэй байна.


Харилцах, хадгаламж (их наяд төгрөг)



Иргэд, байгууллагуудын арилжааны банкинд байршуулсан харилцах, хадгаламжийн нийт дүн 2015 онд 9,55 их наяд төгрөгийн дүнтэй байгаа нь өмнөх оноос 0,54 их наяд төгрөгөөр буурсан үзүүлэлт юм. Хадгаламжийн дансны нийт дүн өмнөх оны дүнтэй тэнцүү хэмжээтэй байгаа боловч харилцах дансны нийт дүн 0,55 их наяд төгрөгөөр буурсан нь нийт харилцах хадгаламжийн дүн ийнхүү буурахад нөлөөлж байна.


2015 онд банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оноос 0,8 их наяд төгрөгөөр буурч 11,63 их наяд төгрөгийн үлдэгдэл дүнтэй байна. Банкны системийн зээлийн үлдэгдлийг эдийн засгийн салбараар ангилан авч үзвэл уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилга, худалдаа, үл хөдлөх хөрөнгийн нийт таван салбарт олгосон зээлийн үлдэгдэл нийт үлдэгдлийн 65.2 хувийг эзэлж байна.

Зээлийн бүтэц (их наяд төгрөг)




Банкны системийн чанаргүй зээлийн хэмжээ 2015 онд 196,5 тэрбум төгрөгөөр өсөж 822,4 тэрбум төгрөгт, хугацаа хэтэрсэн зээл 590 тэрбум төгрөгөөр өсөж 857,9 тэрбум төгрөгт хүрээд байна. Энэ нь эдийн засгийн өсөлт саарч иргэдийн худалдан авах чадвар суларсан, валютын ханш өссөн зэрэг шалтгааны улмаас бизнесийн орчин муудаж иргэд, байгууллагуудын зээлээ эргэн төлөх чадвар муудсантай холбоотой юм.

Чанаргүй зээл (тэрбум төгрөг)




Хугацаа хэтэрсэн зээл (их наяд төгрөг)




Хугацаа хэтэрсэн зээлийн хувьд авч үзвэл 2015 онд өмнөх оноос 590 тэрбум төгрөгөөр өссөнөөс хамгийн их хэсгийг буюу 48 хувийг уул уурхайн салбар, 15 хувийг барилгын салбар, 9 хувийг санхүүгийн болон даатгалын салбарын хугацаа хэтэрсэн зээлийн өсөлтийн дүн эзэлж байна.

Банкны системийн чанаргүй зээлийн хэмжээ 2015 онд 196,5 тэрбум төгрөгөөр өссөнөөс энэхүү өсөлтийн 43 хувийг уул уурхайн салбар, 24 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар, 14 хувийг худалдааны салбаруудын өсөлтийн дүн бүрдүүлж байна.

Цэвэр ашиг (тэрбум төгрөг)



Өөрийн хөрөнгө (их наяд төгрөг)



Зээлийн хугацаа хэтрэлт, чанаргүй зээлийн өсөлт зэргээс хамааран арилжааны банкуудын тайлант хугацааны цэвэр ашиг 2015 онд өмнөх оноос буурсан дүнтэй гарсан. Зээл чанаргүйтсэнээс банкууд Зээлийн эрсдэлийн санг байгуулж, цэвэр ашгаас хасаж тооцдог нь цэвэр ашиг буурахад нөлөөлж байна.

Хэдийгээр банкны системийн цэвэр ашиг буурсан дүнтэй гарч байгаа ч банкуудын өөрийн хөрөнгийн хэмжээ 330 тэрбум төгрөгөөр өсөж, 2,46 их наяд төгрөгт хүрээд байна. Банкууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх нь эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн үүсч болох эрсдэлээс хамгаалан авч хэрэгжүүлж буй арга хэрэгсэл юм.

Хэдийгээр банкны системийн цэвэр ашиг буурсан дүнтэй гарч байгаа ч банкуудын өөрийн хөрөнгийн хэмжээ 330 тэрбум төгрөгөөр өсөж, 2,46 их наяд төгрөгт хүрээд байна.

2015 онд уул уурхайн бүтээгдэхүүний эрэлт буурч, үнэ унаснаас уул уурхайн салбар доройтож, үүнтэй холбоотойгоор банкны системд эзлэх уул уурхайн салбарын зээлийн чанар нилээдгүй хувиар буурахад хүрээд байна. Цаашлаад эдийн засаг гадаад валютын дутагдалд орж төгрөгийн ханш сулрах, улмаар эдийн засгийн өсөлт буурах зэрэг гадаад орчны сөрөг нөлөө нь аж ахуйн нэгжүүдийн бизнесийн орчин муудах, иргэдийн худалдан авах чадвар сулрах суурь шалтгаан болж байна. Үүнээс шалтгаалан банкны системийн зээлийн чанар муудаж цэвэр ашиг буурахад хүргэж байна.

Арилжааны банкууд энэхүү хямралын шинжтэй эдийн засгийн нөхцөл байдалд үүсч буй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хамгаалах зорилгоор арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байгаа нь банкны системийн хувьд өөрийн хөрөнгийн дүн өссөнөөр илэрч байна.

Голомт банкны 2015 оны санхүүгийн үзүүлэлт


Нийт өөрийн хөрөнгө 2014 онтой харьцуулахад 34 тэрбум төгрөгөөр буюу 9 хувиар өсч 428 тэрбум төгрөгт хүрсэн.

Санхүүгийн үр дүн-2015

2015 онд эдийн засгийн гадаад, дотоод орчинд үүсч буй сөрөг байдлаас шалтгаалан харилцагчдын мөнгөн урсгал буурах, гадны хөрөнгө оруулалт татрах, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалт муудаж байгаа нь банкинд зээлийн чанар болон эргэн төлөлт муудсан нь эх үүсвэр өсөлтгүй болох, төлбөрийн чадварын эрсдэлийг дагуулж байсан. Гэсэн ч Голомт банкны хувьд үр бүтээлтэй жил байж, Монголбанкны шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол хангахын зэрэгцээ санхүүгийн болон эрсдэлийн бүхий л үзүүлэлтүүдийг зохистой түвшинд барьж ажиллалаа.


НИЙТ АКТИВ

Голомт банкны нийт актив 3,8 их наяд төгрөг, банкны системийн 17.7 хувийг эзэлж байна.




ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Нийт өөрийн хөрөнгө өнгөрсөн онтой харьцуулахад 34 тэрбум төгрөгөөр буюу 9 хувиар өсөж 428 тэрбум төгрөгт хүрсэн.




ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

Харилцах, хадгаламж өнгөрсөн оны түвшинд буюу 2,1 их наяд төгрөг, банкны системийн 23.3 хувийг эзэлж, харилцах, хадгаламжийн хэмжээгээр тэргүүлэгч байр сууриа хадгалж чадлаа.



ЦЭВЭР ЗЭЭЛ

Зээлийн багц 2015 онд 2,014 тэрбум төгрөгт хүрсэн.




2015 онд 159 тэрбум төгрөгийн орон сууцны зээл олгож, 486 тэрбум төгрөгийн 8+/-1% орон сууцны зээлийг МИК ОССК ХХК-д худалдсан.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг 16.6 хувьд хүргэсэн үзүүлэлттэйгээр 2015 оныг өндөрлүүлснээр сүүлийн 3 жил дараалан өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хоёроос дээш нэгж хувиар давуулан биелүүлж байна.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ


Монголбанк болон бусад зохицуулах байгууллагуудын шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан.

Төлбөрийн чадварын харьцаа >25%



2015 онд өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг 16.6 хувьд хүргэснээр сүүлийн 3 жил дараалан өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хоёроос дээш нэгж хувиар давуулан биелүүлж байна.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ >14% (МБ-ны шаардлага 2013 онд 13%-с 14% болж нэмэгдсэн)



Үзүүлэлтүүд (сая.төг)	2011	2012	2013	2014	2015
Балансын үзүүлэлтүүд (сая төгрөг)					
Нийт актив	2,134,683	2,526,945	3,749,806	4,053,153	3,804,842
Нийт харилцагчийн харилцах, хадгаламж	1,839,324	2,056,728	2,161,779	2,232,270	2,079,801
Зээлээр авсан эх үүсвэр	63,429	112,840	1,032,319	1,011,499	1,014,935
Цэвэр зээл	1,249,341	1,427,852	2,199,228	2,461,920	2,013,611
Нийт өөрийн хөрөнгө	187,959	221,501	329,740	393,736	428,181
Орлогын тайлангийн үзүүлэлтүүд (сая төгрөг)					
Хүүгийн орлого	165,165	200,245	290,945	338,366	314,830
Хүүгийн зардал	(116,240)	(143,127)	(184,701)	(209,312)	(213,295)
Цэвэр хүүгийн орлого	48,925	57,118	106,245	129,054	101,534
Цэвэр хүүгийн бус орлого	27,163	31,932	59,774	36,197	56,258
Үйл ажиллагааны орлого	76,088	89,050	166,019	165,251	157,792
Үйл ажиллагааны зардал	(32,515)	(45,419)	(67,116)	(73,068)	(75,362)
Эрсдэлийн сангийн зардал	(6,324)	(10,790)	(27,940)	(27,900)	(49,703)
Татварын өмнөх ашиг	37,249	32,841	70,963	64,283	32,726
Татварын зардал	(9,022)	(6,694)	(14,106)	(14,455)	(6,742)
Татварын дараах ашиг	28,226	26,146	56,857	49,828	25,985
Санхүүгийн бүтцийн харьцаанууд					
Нийт харилцах, хадгаламж / Нийт актив (%)	86.2%	81.4%	57.7%	55.1%	54.7%
Өөрийн хөрөнгө (1-р зэрэглэл) / Нийт актив (%)	6.5%	7.4%	6.6%	7.3%	9.4%
Цэвэр зээл / Нийт актив (%)	58.5%	56.5%	58.6%	60.7%	52.9%
Хөшүүргийн харьцаа (Нийт пассив / Нийт Капитал) (дахин)	10.4	10.4	10.4	9.3	7.9
Ашигт ажиллагааны харьцаанууд					
Дундаж активын өгөөж (%)	1.6%	1.2%	1.9%	1.4%	0.7%
Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (%)	24.6%	15.1%	26.8%	19.1%	8.7%
Цэвэр хүүгийн ахиуц (%)	3.6%	3.5%	4.6%	4.5%	4.2%
Зардал, орлогын харьцаа (%)	41.3%	50.3%	40.7%	46.1%	47.8%
Шалгуур үзүүлэлтүүд					
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ > 14% (МБ-ны шаардлага 2013 онд 13%-с 14% болж нэмэгдсэн)	12.9%	13.3%	16.7%	17.1%	16.6%
Нэг зээлдэгчид олгосон зээлийн харьцаа <20%	19.8%	19.0%	15.9%	15.8%	18.2%
Холбогдох этгээдэд олгосон зээлийн харьцаа <5%	3.4%	3.5%	3.0%	4.6%	3.9%
Холбогдох этгээдэд олгосон нийт зээлийн харьцаа <20%	12.7%	9.5%	8.2%	15.8%	17.0%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар >25%	38.9%	41.1%	43.3%	38.2%	38.1%
Үндсэн хөрөнгийн харьцаа <8%	1.5%	1.5%	1.6%	2.6%	4.7%

Энэхүү хураангуй санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэсэн болно.

Голомт банкны засаглалын тайлан

Голомт банкны засаглалын соёл нь банкны урт хугацааны тогтвортой өсөлтийн үндэс гэдэгт бид итгэдэг. Тиймээс ч Голомт банкны ТУЗ-ийн зүгээс засаглалын соёлд нэн чухал ач холбогдол өгч, засаглалд оролцогч тал бүрийг хариуцлагатай удирдлага, хяналтын тогтолцоонд зохистой хэлбэрээр оролцох боломжийг олгохоор ажилладаг.

Засаглалын тогтолцоо



Анх 1995 онд 100 хувь үндэсний хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан Голомт банк нь хөгжин төлөвшсөөр өнгөрсөн 20 жилийн хугацаанд олон улсын нэр хүнд бүхий хөрөнгө оруулагчдын анхаарлыг зүй ёсоор татаж чадсан томоохон байгууллага болжээ.

Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн

- Голомт фاینэншил групп ХХК - 83.76%
- Swiss-MO Investment AG - 9.98%
- Trafigura Beheer B.V. - 4.93%
- АХЭХ-ийн хүрээнд хувьцаа эзэмшигчид - 1.33%

Голомт банкны толгой компани болох Голомт фاینэншил групп ХХК нь хөрөнгө оруулалт, банк, даатгал, брокер зэрэг зөвхөн санхүүгийн чиглэлээр дагнасан компаниудыг эгнээндээ нэгтгэсэн, 1,900 гаруй ажилтантай санхүүгийн томоохон компани юм. 2015 онд Голомт фاینэншил групп ХХК нь Дэлхийн эдийн засгийн чуулганы Дэлхийн хурдацтай хөгжиж буй компаниудын нэгээр тодорсон нь бахархалтай амжилт юм.

Голомт банкны гадаад хөрөнгө оруулагч компаниудын нэг болох Swiss-MO Investment AG нь дэлхий даяар хөрөнгө оруулалт, түүний удирдлага болон худалдааны үйл ажиллагаа явуулдаг Швейцарийн Гризонсд үүсгэн байгуулагдсан хөрөнгө оруулалтын сан юм.

Trafigura Beheer B.V. нь 1993 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд дэлхийн газрын тосны гурав дахь том төмөр агуулаагүй баяжмалын арилжаалагч болж чадсан олон улсын корпораци юм.

2015 онд Голомт банк нь Дотоод
аудиторуудын институт /TheIIA/,
Мэдээллийн системийн аудит
болон хяналтын холбооны
/ISACA/ гишүүнээр элссэн болно.

ЗОХИСТОЙ ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХААР ХИЙГДСЭН АЖЛУУД

Зохистой засаглалын олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэх нь засаглалын соёлыг төлөвшүүлэх хамгийн чухал зүйлсийн нэг учир Голомт банкны зүгээс засаглалын тогтолцоогоо сайжруулж, шинэчлэх ажлыг тогтмол хийж ирлээ. Тухайлбал 2015 онд Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран компанийн Зохистой засаглалыг сайжруулах бүтэн жилийн төслийг амжилттай хэрэгжүүлж эхлээд байна. Төслийн үр дүнд Голомт банк нь олон улсын стандартад нийцсэн зохистой засаглалын тогтолцоогоо улам боловсронгуй болгож, бэхжүүлэхээр зорьж байгаа юм.

ТУЗ нь дотоод хяналтын тогтолцоогоо сайжруулах үүднээс Комплаенсийн бодлогыг баталсан. Тухайн ажилтан өөрийн хариуцлагатайгаар гүйцэтгэж буй ажлынхаа явцад давхар хяналт тавих үүрэгтэй гэдгийг бүрэн ойлгуулснаар мэргэжлийн комплаенсийн зөв соёлыг хэвшүүлэх юм. Ингэснээр учирч болзошгүй эрсдэл, үйл ажиллагааны доголдлоос бүрэн сэргийлэх боломжтой бөгөөд зөвхөн хууль дүрмийн хэрэгжилтээс гадна банкны засаглалын кодекст багтсан бүх журам, ёс зүйн код зэрэгт нийцсэн үйл ажиллагааны хамгийн эрүүл тогтолцоог бүрдүүлж чадна.

Үйл ажиллагааны хараат бус, бодит баталгаажуулалт нь засаглалын тогтолцооны салшгүй нэг хэсэг юм. Голомт банкны Дотоод аудитын газар нь банкны үйл ажиллагааг сайжруулж, үнэ цэнийг нэмэх зорилготойгоор ТУЗ-д шууд ажлаа тайлагнадаг.

Тайлант хугацаанд Голомт банкны Дотоод аудитын газар нь эрсдэлд суурилсан аудитын аргачлалыг олон улсын стандартын дагуу нэвтрүүлж, газар нэгжээс гадна бүтээгдэхүүн, процессын шалгалтыг хийж эхэлсэн. Мөн хагас жил тутамд 6+6 зарчмаар эрсдэлийн үнэлгээг хийж, аудитын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлдэг.

2015 онд Голомт банк нь Дотоод аудиторуудын институт /TheIIA/, Мэдээллийн системийн аудит болон Хяналтын холбооны /ISACA/ гишүүнээр элссэн болно.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Аудитын хороо нь Дотоод аудитын газраас хийж буй хараат бус шалгалтын тайланг хянаж, зохих шийдвэр зөвлөмжөөр ханган ажилладаг бөгөөд дотоод үйл ажиллагааны хяналтын хүрээнд хөндлөнгийн аудитын компани банк хоорондын хамтын ажиллагааг удирддаг.

Аудитын хороо нь 2 хараат бус гишүүн, нийт 5 гишүүнтэйгээр 2015 онд ээлжит болон ээлжит бусаар нийт 13 удаа хуралдаж, 84 асуудлыг хэлэлцэж, холбогдох зөвлөмж, шийдвэрийг гаргасан.

Эрсдэлийн удирдлагын хороо нь банкны үйл ажиллагаанд дааж болох эрсдэлийн хэмжээний дээд хязгаарыг тогтоож ТУЗ-өөр батлуулж ажилладаг. Энэхүү батлагдсан эрсдэлийн хязгаарлалтын түвшинд Гүйцэтгэх удирдлагаас эрсдэл өгөөжийн харьцааг зөв удирдаж байгаа эсэхийг тогтмол хянадаг байна. Мөн гадаад болон дотоод хүчин зүйлсээс шалтгаалах эрсдэлийн төлөв байдлыг харгалзан үзэж, эрсдэлийн лимитийг улирал бүр эргэцүүлэн шинэчилж, стратеги бодлогоор хангадаг.


2015 онд Эрсдэлийн удирдлагын хороо нь улирал бүр эрсдэлийн лимитүүдийг эргэцүүлж, ТУЗ-өөр батлуулахаас гадна, банкны Комплаенсийн бодлого, Зээлийн эрсдэлийн үнэлгээний бодлогуудыг ТУЗ-өөр батлуулж ажилласан. 2015 онд тус хороо нь нийт 7 удаа хуралдаж, 34 асуудал хэлэлцэж дүгнэлт, зөвлөмж гаргасан байна.


Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хороо нь банкны Хүний нөөцийн бодлого, урамшууллын системийг боловсруулахаас гадна ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлагын гол гишүүд зэрэг банкны удирдлагад чухал албан тушаалтнуудын томилгоонд оролцдог. Тайлант хугацаанд тус хороо нь Голомт банкны Хүний нөөцийн бодлогыг шинэчилж, бодит гүйцэтгэлд суурилсан урамшууллын системийг сайжруулах үүднээс Гүйцэтгэх удирдлагын багийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний загварыг мөн ТУЗ-ийн өөрийн үнэлгээний загварыг батлуулан ажиллалаа. 2015 онд тус хороо нь нийт 6 удаа хуралдаж, нийт 11 асуудал хэлэлцэж дүгнэлт, зөвлөмж гаргасан байна.

Голомт банк 2014 онд бүтэц, зохион байгуулалтаа өөрчлөн баталж нэвтрүүлсэн. 2015 онд шинэ бүтцийн дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулж, сайжруулан ажилласан жил байлаа.

Байгууллагын бүтэц зохион байгуулалт

ГОЛОМТ БАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ





Удирдлагын баг



Ерөнхийлөгч
Ө.Ганзориг



Тэргүүн дэд захирал
Ө.Эрдэмбилэг



Санхүүгийн удирдлага хариуцсан дэд захирал
М.Чимэгмөнх



Зээл хариуцсан дэд захирал
Т.Нямсүрэн



Нөөцийн удирдлага хариуцсан дэд захирал
Б.Мөнхбаатар



Мэдээллийн технологи хариуцсан дэд захирал
Н.Цэрэндаваа



Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал
Б.Энхтуяа



Дэд захирал, Бизнес хөгжлийн газрын захирал
Д.Сугар



Аудит хариуцсан захирал
Р.Батсүрэн



Байгууллагын банкны газрын захирал
Д.Бадрал



Сувгийн удирдлагын газрын захирал
У.Хосжаргал



Хөрөнгө оруулалтын банкны газрын захирал
Ж.Хишигжаргал



Мэдээллийн технологийн газрын захирал
Б.Эрдэнэбаяр



Бүртгэл тооцооны газрын захирал
Ё.Пүрэвбат



Кастодиан банкны газрын захирал
Г.Зориг

Голомт банкны амжилтын товчоон

Голомт банк жижиг дунд бизнес эрхлэгчдэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдэд тэргүүлэгч байр сууриа хадгалж, Монгол Улсын Засгийн газар болон олон улсын байгууллагуудын хөтөлбөрүүдэд амжилттай хамтран ажиллалаа.

Иргэдийн зах зээл

ЖИЖИГ ДУНД БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Голомт банк 2012 оноос жижиг дунд бизнес эрхлэгчиддээ зориулсан банк санхүүгийн бүх төрлийн үйлчилгээ тэр дундаа бизнесийн зөвлөх үйлчилгээг нэг цэгээс хүргэх зорилгоор бизнес төвүүдээ бүсчлэн байгуулж ирсэн бөгөөд жижиг дунд бизнес эрхлэгчдэд тусгайлан зориулсан үйлчилгээг хүргэх мэргэжилтнүүдийнхээ орон тоог нэмэгдүүлэн, мэргэшүүлэн ажиллаж байна.

2015 онд Сонгино-Хайрхан бизнес төвийн үйл ажиллагааг эхлүүлснээр Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгино-Хайрхан дүүргүүд дэх бизнес төвөөрөө дамжуулан жижиг дунд бизнес эрхлэгчиддээ нэг цэгийн үйлчилгээг үзүүлж байна.

Жижиг дунд бизнесийн хэлтэс



ТӨВ
БИЗНЕС ТӨВ



ЗЭЭЛИЙН ТӨВ
БИЗНЕС ТӨВ



САНСАР
БИЗНЕС ТӨВ



ХАН-УУЛ
БИЗНЕС ТӨВ



СОНГИНОХАЙРХАН
БИЗНЕС ТӨВ

97 салбар тооцооны төвүүд

БИЗНЕСИЙН ЗЭЭЛ ОЛГОЛТ



156
тэрбум
төгрөг



1,300 зээлдэгчид

ТӨСЛИЙН ЗЭЭЛ ОЛГОЛТ



99,3
тэрбум
төгрөг



280 зээлдэгчид

БАТЛАН ДААЛТЫН САНД



8,6
тэрбум
төгрөг



102 зээлдэгчид

Жижиг дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх, дэмжин ажиллах цогц бодлогыг тодорхойлох зорилгоор 2015 онд 1500 гаруй жижиг дунд бизнес эрхлэгчдийг хамруулсан зах зээлийн судалгааг хийн дараах гол ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

ЖДБ эрхлэгчдэд зориулсан WWW.SME.GOLOMTBANK.COM вэб сайтыг нэвтрүүлэв



САНХҮҮ



БИЗНЕС
ТӨЛӨВЛӨЛТ



ЭРСДЭЛ



ХҮНИЙ
НӨӨЦ



МАРКЕТИНГ



БОРЛУУЛАЛТ



ХУУЛЬ

Дээрх 7 үндсэн сэдвийн хүрээнд бизнес эрхлэгчид шууд ашиглах боломж бүхий 93 загвар хэрэгсэл, 130 контент, зөвлөгөө мэдээллийг бэлтгэв

ТОП бизнес эрхлэгчдэд зориулсан Менежментийн форумыг анх удаа зохион байгуулж 600 гаруй бизнес эрхлэгчдэд зөвлөгөө өгч, сургалт, хэлэлцүүлэг хийв



ДАРХАН аймгийн
БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ФОРУМ



ОРХОН аймгийн
БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ФОРУМ



ХОВД аймгийн
БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ФОРУМ

Жижиг дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн хэрэгцээнд зориулсан БАГЦ брошур гаргав
Жижиг дунд бизнес эрхлэгчдийн богино хугацаат санхүүгийн хэрэгцээг хангах шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэв




ШУУРХАЙ
ЗЭЭЛ



ОВЕРДРАФТ

Голомт банк жижиг дунд бизнес эрхлэгчдэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдэд тэргүүлэгч байр сууриа хадгалж, Монгол Улсын Засгийн газар болон олон улсын байгууллагуудын хөтөлбөрүүдэд амжилттай хамтран ажиллалаа.



БСАД ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

- ХБНГУ-ын KFW банкны санхүүжилттэй Хувийн хэвшлийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих төслийн зээл
- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн том, жижиг 70 тэрбум төгрөгийн төслийн зээл
- Ноолуурын эргэлтийн хөрөнгийн хөтөлбөр төслийн зээл
- АСЕМ уулзалтын зочдыг хүлээн авах зочид буудлын төслийн зээл

2015 оны байдлаар нийт 25,739
өрхөд орон сууцтай болоход нь
дэмжлэг үзүүлсэн байна.

ГИБРИД ХАДГАЛАМЖ

Монгол Улсад анх удаа хөрөнгө оруулалтын болон хадгаламжийн хосолмол бүтээгдэхүүнийг банк санхүүгийн зах зээлд нэвтрүүлсэн.

Банк харилцагчийн өмнөөс газрын тос, алт, зэсний үнийн бууралт, өсөлтөөс шалтгаалсан санхүүгийн зах зээлийн option хэлцэл хийж, ханшийн зөрүүнээс үүсэх өгөөжийг харилцагчдад 100 хувь хүртээх боломжийг олгож байна. Түүнчлэн хөрөнгийн зах зээлд шууд оролцоход гарах зардал, үүсч болох эрсдэлүүдээс харилцагчаа хамгаалах боломжийг Гибрид хадгаламж олгоно. Хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн ажилтнуудаас бүрдсэн баг харилцагчдад эдийн засаг, зах зээлийн шаардлагатай зөвлөгөөг өгөн ажиллаж байна.

ҮНДЭСНИЙ ХУРИМТЛАЛ ХӨТӨЛБӨР - ХУРИМТЛАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН

Голомт банк нь иргэдийн хуримтлалыг нэмэгдүүлэх замаар улс орны эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд дэмжих зорилтын хүрээнд "Хуримтлалыг зуршил болгоё!" уриан дор Хуримтлалын бүтээгдэхүүнийг зах зээлд цоо шинээр нэвтрүүллээ.

Бүтээгдэхүүний гол онцлог нь харилцагчийн хуримтлуулах зуршлыг дэмжих бөгөөд сар бүр тогтмол орлого хийх шалгууртай юм. Энэ нөхцөл хангагдсан тохиолдолд хүүн дээр нь нэмж өндөр урамшуулал олгох юм. Иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх компанит ажил өрнүүлэн нийт 1,081 аж ахуйн нэгж байгууллагын 53,000 ажилтанд хувь хүний болон өрхийн санхүүгийн зөв зохистой удирдлага, хуримтлалын ач холбогдлын тухай сургалт хийсэн. Хуримтлалын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлснээс хойшхи 2 сарын хугацаанд 23,500 харилцагч хадгаламж нээлгэсэн байна. Хэрэв 3 өрх тутмын 1 нь сар бүр тогтмол 50 мянган төгрөгийг хуримтлуулж зуршвал 10 жилийн дараа айл өрх бүр 13 сая төгрөг, улс орон 3,3 их наяд төгрөгийн хуримтлалтай болох юм.

ИРГЭДИЙН ГАЛ ГОЛОМТОО БАДРААХ ҮЙЛСЭД...

"Сайн сайхныг санхүүжүүлнэ" уриатай Голомт банк нь 2002 оноос орон сууцны урт хугацаатай зээлийг иргэд харилцагчиддаа олгож эхэлсэн туршлагатай банкуудын нэг бөгөөд энэ хугацаанд нийт 25,739 гаруй өрхийг орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлсэн.

2015 оны байдлаар нийт 25,739 өрхөд орон сууцтай болоход дэмжлэг үзүүлсэн байна

2013 ОН		6,085 өрх шинээр орон сууцтай болсон		НИЙТ 331,8 тэрбум төгрөгийн зээлийг шинээр олгосон
2014 ОН		6,344 өрх шинээр орон сууцтай болсон		НИЙТ 325,7 тэрбум төгрөгийн зээлийг шинээр олгосон
2015 ОН		2,355 өрх шинээр орон сууцтай болсон		НИЙТ 159,1 тэрбум төгрөгийн зээлийг шинээр олгосон

2015 онд шинээр 2,355 өрхөд 159 тэрбум төгрөгийн орон сууцны зээлийг олгосон бөгөөд зээлийн багцын хэмжээ өмнөх оноос 11 хувиар өсөж 849 тэрбум төгрөгт, орон сууцны зээлд хамрагдсан өрхийн тоо 17,954-т тус тус хүрлээ.

8+/-1 ХУВИЙН ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД

Голомт банк орон сууцны санхүүжилтийн 28 хувийг дангаар бүрдүүлэн ажиллаж байна. Нийт 4 удаагийн хэлцлээр 486 тэрбум төгрөгийн орон сууцны зээлийн багцыг МИК ОССК ХХК-д амжилттай худалдаж, үнэт цаасжуулсан.

Хувийн банкны харилцагчдад зориулан Үл хөдлөх хөрөнгийн зөвлөх үйлчилгээг анх удаа нэвтрүүлсэн бөгөөд доорх үндсэн чиглэлийн хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран зөвлөгөө өгч байна.

Өнгөрсөн хугацаанд Улаанбаатар хотын орон сууцны зах зээл, Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт, Барилгын хөгжлийн шинэ тренд, Түрээсийн зах зээл, Бүсчлэл зэрэг харилцагчдын ихээхэн сонирхдог сэдвүүдээр мэдээлэл, зөвлөгөө өгсөн нь үр дүнгээ өгч байна.

- Үл хөдлөх хөрөнгийн зах зээлтэй холбоотой судалгаа
- Үл хөдлөх хөрөнгө худалдан авах зөвлөгөө
- Хөрөнгө оруулалтын зөвлөгөө
- Хууль эрх зүйн зөвлөгөө
- Банкны санхүүжилттэй холбоотой үйлчилгээ

КАРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Голомт банк 2015 онд Монгол Улсын төлбөрийн картын зах зээл дэх манлайлагч байр сууриа баттай хадгалан ажиллалаа.


Дэлхийд танигдсан, өндөр нэр хүнд бүхий Американ Экспресс дебит картыг зах зээлд шинээр гаргалаа. Энэхүү карт нь олон улсын Selects болон Taste сүлжээний байгууллагуудаас хөнгөлөлт эдлэх зэрэг олон давуу талтайгаас гадна хийсэн гүйлгээ бүртээ оноо тооцуулан, сонгогдсон газруудад купон хэлбэрээр худалдан авалт хийх боломжтой юм.

Кредит картын ач холбогдлын талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, хэрэглээг хэвшүүлэх чиглэлээр дорвитой ажлууд хийгдсэний үр дүнд кредит карт эзэмшигчдийн тоо 56 хувиар, кредит картаар хийгдсэн гүйлгээний тоо 40 хувиар тус тус өссөн байна.

ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Харилцагчийн санхүүгийн бүх төрлийн хэрэгцээг түргэн шуурхай хангах нь бидний эрхэм зорилгын нэг билээ. Энэ ч үүднээс 2015 онд Голомт банк даатгалын зуучлалын үйлчилгээг бүтээгдэхүүн үйлчилгээгээ өргөжүүлж, даатгалын бие даасан нэгжийг байгуулсан.

Голомт банк нь иргэдийн хуримтлалыг нэмэгдүүлэх замаар улс орны эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд дэмжих зорилтын хүрээнд “Хуримтлалыг зуршил болгоё!” уриан дор Хуримтлалын бүтээгдэхүүнийг зах зээлд цоо шинээр нэвтрүүллээ.



2015 онд Голомт банк нь харилцагчийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан банкны борлуулалт, үйлчилгээний сувгийг төрөлжүүлэн удирдахаар Сувгийн удирдлагын газрыг шинээр байгуулсан.

2015 онд 150 орчим ажилтнаа даатгалын бүрэн хэмжээний сургалтад хамруулж, 40 гаруй салбар нэгжээрээ дамжуулан харилцагчиддаа болзошгүй эрсдэлээс хэрхэн сэргийлэх, түүнд тохирсон даатгалын бүтээгдэхүүнээ хэрхэн сонгоход нь зөвлөгөө өгч ажиллалаа.

Банкны харилцагчдын хувьд даатгалын компаниудын бүтээгдэхүүнийг илүү таатай нөхцөлөөр худалдан авдаг давуу талтай. Тэгвэл энэхүү боломжийг аж ахуйн нэгж байгууллагуудад тэгш олгох үүднээс даатгалын ач холбогдлын талаарх мэдлэгийг олгох, болзошгүй эрсдэлээс сэргийлэх талаарх мэдээлэл өгч, хамтран ажиллахаар зорьж байна.

СУВГИЙН УДИРДЛАГА

2015 онд Голомт банк нь харилцагчийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан банкны борлуулалт, үйлчилгээний сувгийг төрөлжүүлэн удирдахаар Сувгийн удирдлагын газрыг шинээр байгуулсан.

Ингэснээр харилцагчдын сэтгэл ханамжтай байдлыг хангах, урт хугацаанд үнэнч тууштай харилцааг бий болгох, оновчтой сувгаар тохирсон борлуулалтыг хийж, харилцан үр ашигтай хамтран ажиллах боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн томоохон ажлуудыг гүйцэтгэж, харилцагч төвтэй банк гэдгээ бататгаж чадлаа.

Голомт банкны харилцагч нь цаг хугацаа, орон зайнаас үл хамааран өөрт хамгийн ойр, хямд, хурдан сувгуудаар банктэйгаа холбогдон мэргэжлийн өндөр түвшинд бүтээгдэхүүн үйлчилгээ, туслалцаа дэмжлэг авах боломжийг бүрдүүлэх нь Сувгийн удирдлагын газрын 2015 онд дэвшүүлсэн зорилтын нэг байлаа.

Банкны олон сувгийг (multi-channel) хөгжүүлж, улмаар харилцагчийн CRM системтэй уялдуулан системийн сайжруулалт хийснээр omni-channel болгох эхний томоохон алхамыг гүйцэтгэсэн байна. Өөрөөр хэлбэл Өөртөө үйлчлэх нэгж /ATM, интернэт банк, утсан харилцааны 1800-1646 шугамаас гадна сошиал харилцаа, онлайн зөвлөх (live chat), и-мэйл үйлчилгээ, факс, мессэж, видео дуудлага, киоск төхөөрөмж зэрэг олон сувгуудаар харилцагчийн үйлчилгээг үзүүлэх боломж бүрдсэн байна.

2015 онд Голомт банк харилцагчийн үйлчилгээний чанараа сайжруулах, ажилтнуудаа чадавхижуулах чиглэлд авч хэрэгжүүлсэн өдөр тутмын үйл ажиллагаа, томоохон төсөл, үйл ажиллагааны үр дүнд тодорхой ахицууд гарчээ. Тухайлбал, ажилтнуудын үйлчилгээний үр чадварыг хэмжих Mystery shopping судалгааг хийснээр салбарын үйлчилгээний мониторингийн үр дүн тогтмол өсөлттэй гарч, харилцагчийг сонсох, ойлгох чадвар нэмэгджээ.

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- 2015 онд Харилцагчийн үйлчилгээний төв нь гадаадад ажиллаж, амьдардаг харилцагчиддаа Интернэт банкны эрх нээх, Хэрэглэгчийн дугаарыг нь дахин илгээх, Онлайн хадгаламжийг борлуулах зэрэг үйлчилгээг албан ёсоор үзүүлж байна.

- Лавлах төвийн бүртгэлийн програмыг хөгжүүлж, CRM системийг нэвтрүүлж, дуудлагын яриа бичигчийн системийг суурилуулж, VIP шугамыг өргөжүүлэх зэргээр дэд бүтцийн сайжруулалт хийж, дуудлагын менежмент хийх боломжийг бүрдүүлжээ.
- Голомт банкинд 2014 онд нэвтрүүлсэн Finacle банкны үндсэн системийн хүрээнд CRM incident модулийг хөгжүүлснээр харилцагчаас ирсэн нийт гомдлын тоо 2014 онтой харьцуулахад 70.6 хувиар буураад байна.

VIP ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХИЙГДСЭН САЙЖРУУЛАЛТ

2015 онд Голомт банк Хувийн банкны үйлчилгээг шинэ түвшинд гаргаж, үйлчилгээний орчин, бүтээгдэхүүн үйлчилгээндээ шинэчлэл хийсэн.

Хувийн банкны харилцагчдад үйлчилгээ үзүүлэх өндөр ёс суртахуун, ур чадвар бүхий Банкир ажилтныг шинээр бэлтгэж, харилцагчдынхаа тав тухтай, сэтгэл ханамжтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлсэн шинэчлэлүүдийг хийж гүйцэтгэлээ.

Өөрчлөлтийг өнөөдрөөс аян өрнүүлж ажилтны хандлагад суурилсан бүтээмж нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилтнуудад Харилцагчийн үйлчилгээний стандартуудыг мөрдөж, хэвшүүлэх, харилцагчдад сайн үйлчилгээ үзүүлэх дадал чадварыг суулгаж ажиллалаа. Тус аянтай зэрэгцэн бүтээмж нэмэгдүүлэх хөтөлбөрийг мэргэжлийн сэтгэл зүйн компанийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн. Банкны ажилтнуудын үйлчилгээний сэтгэл зүйг бүрдүүлэх, харилцагчаа хүндлэх, чин сэтгэлээсээ харилцаа үүсгэх, туслах эрмэлзлийг хүчтэй болгох, ажлын бүтээмжийг сайжруулахад тус хөтөлбөр нь онцгой хувь нэмрээ оруулсан юм.

САЛБАР ТООЦООНЫ ТӨВ

Голомт банкны Ховд салбар дэлхийн жижигт нийцсэн, банк санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зориулалтын байраа ашиглалтад оруулж, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.

2015 оны 12 сар

Улаанбаатар хотын хүн амын төвлөрөл ихтэй, Сонгинохайрхан дүүрэгт шинээр Цамбагарав бизнес төв нээгдэж, үйл ажиллагаагаа эхлүүлэв.

2015 оны 7 сар

Хархорин зах худалдааны төвд байрлах бизнес эрхлэгч, түрээслэгч, харилцагчдад ойртож ажиллах зорилгоор шинээр нэгж/касс нээж ажиллуулсан.

2015 оны 8 сар


Голомт банкны Ховд салбар дэлхийн жижигт нийцсэн, банк санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зориулалтын байраа ашиглалтад оруулж, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудаас Голомт банк анх удаа Өөртөө үйлчлэх булан буюу төхөөрөмжид суурилсан орчин үеийн дэвшилтэт шинэлэг үйлчилгээг нэвтрүүлээд байна.


ЦАХИМ АЯН

Монгол Улсын банкны системийн хэрэглэгчдийн цахим төлбөр тооцооны хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Цаасгүй банк аяныг Голомт банк амжилттай зохион байгууллаа. Аяны үр дүнд:

Хэрэглэгчийн тоо (өсөлтийн хувь)



Интернэт банкаар хийгдсэн гүйлгээ (өсөлтийн хувь)




Цахим сувгаар хэрэглэгч өөрийн төлбөр тооцоогоо гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл, зөвлөгөө, эрсдэлээс сэргийлэх аюулгүй байдлын зөвлөмж зэргийг банкны цахим сувгууд болон социал сувгуудаас хүссэн үедээ авах боломжтой болсон.


ИНТЕРНЭТ ХУДАЛДААНЫ АНХДУГААР КОНФЕРЕНЦИ

Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, банк, цахим төлбөр тооцоо, ложистик даатгал, интернэтийн сүлжээ, програм хангамжийн 200 гаруй оролцогч, 12 илтгэгч, 27 эксперт оролцсон Интернэт худалдааны анхдугаар конференцийг Голомт банк хамтран зохион байгуулав.

Төхөөрөмжөөр хүрэх сувгийн өргөжилт (өсөлтийн хувь)



Харилцагчийн тоо



ЦАХИМ СУВГИЙН ӨРГӨЖИЛТ

Карт хүлээн авагч байгууллагын сүлжээг өргөжүүлэх, бизнес эрхлэгч байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор олон чухал ажлууд хэрэгжүүлсний нэг нь Картаар үйлчлэгч байгууллагуудыг хамруулсан Төлбөр тооцооны эрсдэлээс сэргийлэх форумыг амжилттай зохион байгууллаа.

ӨӨРТӨӨ ҮЙЛЧЛЭХ БУЛАН

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудаас Голомт банк анх удаа Өөртөө үйлчлэх булан буюу төхөөрөмжид суурилсан орчин үеийн дэвшилтэт шинэлэг үйлчилгээг нэвтрүүлээд байна. Энэ нь харилцагч банкны ажилтанд заавал ханддаг байсан 15 нэр төрлийн 40 орчим үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлсэн үйлчилгээ юм.

Энэ нь ирээдүйн банкны бизнес, үйлчилгээний процесс, салбарын үйлчилгээний модельд шинэлэг байдлын эхлэлийг бий болгосон.

Мөн тус үйлчилгээг харилцагч өөрийн ухаалаг гар утас, таблет төхөөрөмжөө ашиглан Голомт банкны салбарын орчинд Wi-Fi утасгүй интернет сүлжээгээр дамжуулан авах боломжтой юм.

2015 онд Монгол Улсын эдийн засагт царцанги нөхцөл байдал үргэлжилсэн ч Голомт банк нь олон улсын тэргүүлэгч банкуудтай хамтран 54 сая ам.долларын зээлийг дотоодын компаниудад дамжуулан зээлдүүлж, эдийн засгийн эргэлтэд бодит дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Байгууллагын зах зээл

Голомт банк нь байгууллагын түвшинд



Төр хувийн хэвшлийн томоохон аж ахуй нэгжүүд



Концесссын гэрээгээр төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд



Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд



Элчин сайдын яамд



Их дээд сургуулиуд

Харилцагчдынхаа санхүүгийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх зорилтын хүрээнд 2015 онд байгууллагын дебит карт, овернайт хадгаламж, багцаар цалин тавих үйлчилгээ, мөнгөн урсгалын менежмент, и-тикет зэрэг үйлчилгээг шинээр нэвтрүүлээ.

2015 онд Монгол Улсын эдийн засагт царцанги нөхцөл байдал үргэлжилсэн ч Голомт банк нь олон улсын тэргүүлэгч банкуудтай хамтран 54 сая ам.долларын зээлийг дотоодын компаниудад дамжуулан зээлдүүлж, эдийн засгийн эргэлтэд бодит дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Голомт банк нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийн гарцыг салбарын төрөлжилт хэмээн харж, хөгжих нөөц бололцоотой салбаруудыг дэмжин ажиллаж байна. Үүний хүрээнд хөдөө аж ахуйн салбарт сүү сүүн болон ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хүлэмжийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж буй харилцагч байгууллагуудад үйлдвэрийн өргөтгөл, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд нь дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Мах, шатахууны "ҮНЭ ТОГТВОРЖУУЛАХ" хөтөлбөр



нийт **47** төгрөгийн санхүүжилт олгов **тэрбум**



Монгол Улсын шатахууны жилийн хэрэгцээний **28%**



Махны хэрэгцээний **43%**

хангах нөхцөлийг бүрдүүлсэн

Голомт банк өөрийн эх үүсвэрээс үндэсний хэмжээний төсөл хөтөлбөрүүдэд хамтран оролцож:

- Олон улсын стандартад нийцсэн 4,000 кв талбай бүхий тохилог дулаан орчин бүхий худалдаа, үйлчилгээний төвийг ашиглалтад оруулж, нийт 570 гаруй ажлын байрыг шинээр бий болголоо.
- Нийт 5,900 айлын орон сууцны барилга ашиглалтад орууллаа.
- Нийт 39 км урттай цэвэр, бохир усны шугам сүлжээний инженерийн барилга байгууламжийг бүтээн байгууллаа.
- Хийн түлшний аж ахуйг хөгжүүлэх зорилгоор нийт 21 аймагт авто машин болон ахуйн хэрэглээний хий цэнэглэх станц барих төслийг хэрэгжүүлж эхлээд байна.

УУЛ УУРХАЙ, ДЭД БҮТЦИЙН САЛБАР

2015 онд дэлхийн эдийн засгийн өсөлт саарч, БНХАУ-д аж үйлдвэржилт удааширсан жил байлаа. Монгол Улсын хувьд экспортын голлох эрдэс бүтээгдэхүүний тоо хэмжээ өссөн ч зах зээлийн үнийн хувьд буурсан үзүүлэлттэй байв. Голомт банк нь хариуцлагатай, бүтээлч уул уурхай, дэд бүтцийн салбарыг дэмжигчийн хувьд, гадаадын өндөр нэр хүнд бүхий банк санхүүгийн байгууллагуудтай хамтран, харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцсэн гадаад худалдааны санхүүжилт болон бусад төлбөр тооцооны оновчтой арга хэрэгслүүдийг ашиглан амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа.

Үүний үр дүнд Голомт банкны уул уурхай, дэд бүтцийн салбарт олгосон зээл, түүнтэй адилтгах активын өсөлтийг зорилтот түвшинд хадгалж, банкны нийт активд эзлэх уул уурхай, дэд бүтцийн салбарын төвлөрлийг 20 хувиас хэтрүүлэхгүйгээр, эрсдэлийн түвшинг зохист хэмжээнд удирдан ажиллав.

2015 онд Монгол Улсын Засгийн газар, Монголбанкнаас хамтран хэрэгжүүлж буй Алт худалдан авах, урьдчилгаа санхүүжилт олгох хөтөлбөрт Голомт банк нэгдэж, Монгол Улсын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, алт үйлдвэрлэгчдийг дэмжих чиглэлээр санхүүжилт олгож эхлээд байна.



ВАЛЮТ, АЛТНЫ АРИЛЖАА

Гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад худалдааны уналт, мөнгөний нийлүүлэлтийн бууралтаас шалтгаалан валют арилжааны эргэлт хумигдсан ч Голомт банк зах зээлд тэргүүлэгчийн байр сууриа хэвээр хадгалж харилцагчдынхаа захиалгыг биелүүлж ажилласны зэрэгцээ санхүүгийн үүсмэл хэрэгслийг үр дүнтэй ашиглаж, харилцагчиддаа санал болгон ханшийн эрсдэлээс хамгаалж ажиллалаа.

Голомт банк нь байгууллага, иргэдээс биет алтыг зах зээлийн ханшаар түргэн шуурхай худалдан авах, алт барьцаалан урьдчилгаа санхүүжилт олгох, найдвартай хадгалах үйлчилгээг ая тухтай тохилог орчинд үзүүлж, идэвхитэй ажилласны үр дүнд арилжаалсан биет алтны хэмжээг өмнөх оны хэмжээнд хадгалж чадсан ба Монголбанкинд тушаасан нийт алтны 12 хувийг Голомт банк дангаар гүйцэтгэсэн байна.

Түүнчлэн, харилцагчдынхаа санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, цаг үеийн мэдээллээр шуурхай хангах үүднээс:

- Гадаад, дотоодын зах зээлийн мэдээлэл бүхий өглөөний мэдээ
- VIP харилцагчдад зориулсан валютын зах зээлийн мэдээ
- Алт олборлогч байгууллагуудад зориулсан алтны зах зээлийн тойм мэдээ
- Гибрид хадгаламж сонирхож буй харилцагчдад зориулсан, газрын тос, алт, зэсийн зах зээлийн мэдээллийг тус тус тогтмол бэлтгэн хүргэж байна.

Голомт банк нь 2015 онд олон улсын зээлдүүлэгч, хөрөнгө оруулагч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлсний үр дүнд нийт 100 сая ам.долларын санхүүжилтийг авснаар Монгол Улсын эдийн засагт чухал нөлөө үзүүлж чадсан юм.

Хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа

Голомт банк нь 2015 онд хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаагаа эрчимжүүлж, хөрөнгийн зах зээлийн салбарт шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэн, харилцагчиддаа хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг илүү ойртуулан, санхүүгийн өргөн хүрээний шийдлийг санал болгож ажиллалаа.

Мөн гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэн компани, аж ахуйн нэгж, төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтер, зуучлалын үйлчилгээ, төслийн санхүүжилтийн үйлчилгээг үзүүлэхээс гадна Кастодиан банкныхаа үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэллээ.

2015 онд Голомт банк нь олон улсын нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, харилцагчдын экспорт, импортод суурилсан бизнесийн санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, гадаад төлбөр тооцоог хамгийн түргэн шуурхай, өргөн сонголттой хийх боломжийг бүрдүүлэхэд чиглэн ажиллалаа.

МОНГОЛ УЛСАД АНХ УДАА 100% ДААТГАГДСАН КОМПАНИЙН БОНДЫГ ЗАХ ЗЭЭЛД ГАРГАЛАА

Голомт банк нь андеррайтерийн үйл ажиллагааныхаа хүрээнд, Монгол Улсад анх удаа 100 хувь даатгагдсан компанийн бонд болох Эрчим бондыг Монголын хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжааллаа.

Тус бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 50,000 ширхэг арилжаалагдсан тус бондыг худалдан авах арилжааны захиалга, нийлүүлэлтээс 4.7 дахин их буюу 2,4 тэрбум төгрөгт хүрсэн нь уг бонд ихээхэн эрэлттэй бүтээгдэхүүн болж чадсаны илэрхийлэл юм. Тус бондын арилжаа нь Монголын хөрөнгийн бирж болон хөрөнгийн зах зээлийн түүхэнд шинэ бүтээгдэхүүн, онцгой үйл явдал болон тэмдэглэгдлээ.

ГОЛОМТ БАНК 100 САЯ АМ.ДОЛЛАРЫН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ АВЛАА

Голомт банк нь 2015 онд олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа бэхжүүлсний үр дүнд 100 сая ам.долларын санхүүжилтийг авсан. Энэ нь банкны хувьд томоохон амжилт төдийгүй Монгол Улсын эдийн засагт чухал нөлөө үзүүлсэн юм. Энэхүү санхүүжилт нь Голомт банкны түүхэнд хийгдсэн хамгийн том хэлцэл бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт буурсан энэ цаг үед улс орны хэмжээнд томоохон ач холбогдолтой юм.

ГОЛОМТ БАНК МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД ГАРГАСАН 500 САЯ АМ.ДОЛЛАРЫН БОНДЫН ХАМТАРСАН МЕНЕЖЕРЭЭР АЖИЛЛАЛАА

Голомт банк нь андеррайтерийн үйл ажиллагааныхаа хүрээнд Монгол Улсын Засгийн газраас гаргаж буй олон улсын бэнчмарк 500 сая ам.долларын бондын хамтарсан менежер /Joint Lead Manager/-ээр ажиллалаа. Тус бонд нь 5 жилийн хугацаатай бөгөөд Сингапурын хөрөнгийн биржид бүртгэгдсэн юм. Олон улсын зах зээл дээр тус бондыг гаргах үйл ажиллагаанд Голомт банк нь олон улсын 4 том банк, дотоодын нэг үнэт цаасны компани, гадаад дотоодын хуулийн өндөр нэр хүнд бүхий фирмүүдтэй нягт хамтран ажиллаж, хэлцлийг амжилттай хэрэгжүүллээ.

ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖИХ ЗЭЭЛИЙН ШУГАМУУДАА ӨРГӨТГӨЛӨӨ

Хөрөнгө оруулалтын банк нь 2015 онд олон улсын нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, харилцагчдын экспорт импортод суурилсан бизнесийн санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Канадын Экспорт хөгжлийн агентлаг (Export Development Canada)-тай ЭСА зээлийн дунд болон урт хугацааны санхүүжилтийн шугамын гэрээ, Чехийн экспортын банкттай (СЕВ) хамтын ажиллагааны гэрээг байгууллаа. Ингэснээр харилцагчдад эдгээр улсаас газар тариалан, уул уурхай, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, үйлчилгээ импортлоход хамгийн таатай хөнгөлөлттэй нөхцөлөөр дунд болон урт хугацааны зээлийн санхүүжилт авах боломж нээгдсэн юм.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ ЗӨВЛӨГӨӨНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Голомт банк нь 2015 оны 3-р сарын 19-ний өдөр Хөдөө аж ахуйн төслийн санхүүжилт зөвлөгөөнийг Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Олон улсын санхүүжилтийн корпорацитай хамтран амжилттай зохион байгууллаа.

Зөвлөгөөний үеэр тус салбарын онцлог болон цаашдын хөгжилд нэн шаардлагатай санхүүгийн шийдлийг хэлэлцэхээр олон улсын санхүүгийн байгууллагууд, хөдөө аж ахуйн салбарын 250 гаруй төлөөлөгчид оролцсон нь өндөр өгөөжөө өгсөн арга хэмжээ болсон юм.

INVEST IN MONGOLIA КОНФЕРЕНЦИЙГ НЬЮ-ЙОРК ХОТНОО ГУРАВ ДАХЬ ЖИЛДЭЭ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Голомт банк, Голомт Секюритиз ХХК, Нью-Йоркын Үнэт цаасны шинжээчдийн холбоо (NYSSA)-той хамтран Монголын томоохон аж ахуйн нэгжүүдийг гадаад зах зээлд таниулах зорилгоор, дэлхийн санхүүгийн төв болох АНУ-ын Нью-Йорк хотноо Invest in Mongolia сэдэвт хөрөнгө оруулалтын чуулганыг гурав дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Тус чуулга уулзалт нь олон улсын хөрөнгө оруулагчдын анхаарлыг Монголын зүг татаж чадсан, бизнес эрхлэгчдэд шинэ хамтын ажиллагааны үндэс суурийг тавьсан онцгой ач холбогдолтой арга хэмжээ юм.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Тайлант хугацаанд олон улсын нэр хүнд бүхий санхүүгийн байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, харилцагчдын экспорт импортод суурилсан бизнесийн санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, гадаад төлбөр тооцоог хамгийн түргэн шуурхай, өргөн сонголттой хийх боломжийг бүрдүүлэхэд чиглэн ажиллалаа.



Голомт банк нь өнгөрөгч онд банкны үйл ажиллагаа, бизнесийн цар хүрээг нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, шийдлүүдийг нэвтрүүлэх зорилгоор олон улсын нэр хүнд бүхий Deutsche банкинд кастодианы дансыг, дериватив арилжаа хийх зорилгоор Commerzbank банкинд юанийн оффшор дансуудыг тус тус нээгээд байна.

Голомт банк нь Монгол Хятад улс хоорондын бизнесийн харилцааг дэмжихэд тэргүүлэгч үүрэг гүйцэтгэдэг бөгөөд энэ байр сууриа улам бататган, Монгол Улсын арилжааны банкуудаас анх удаа үндэсний мөнгөн тэмдэгт Төгрөгийн арилжааг олон улсын хэмжээнд дэмжих, цаашид идэвхижүүлэх зорилгоор Хятадын Bank of China-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

БНХАУ-ын Баошань банктai хамтран Монгол Хятад хоёр улсын арилжааны банк хоорондын анхны төслийн санхүүжилтийн хэлцлийг амжилттай хийж, хамтран ажиллах гэрээг үзэглэлээ. Уг төслийн санхүүжилт нь хоёр улсын банк санхүү, эдийн засгийн хамтын ажиллагааг дахин нэг шат дээшлүүлэхэд ихээхэн хувь нэмэр үзүүлэх юм.

Голомт банк нь Ази болон БНХАУ-ын тэргүүлэгч 38 санхүүгийн байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн Азийн санхүүгийн хамтын ажиллагааны холбоо (AFCA)-нд 2014 онд Монгол Улсаас анх удаа гишүүнээр элссэн бөгөөд энэхүү хамтын ажиллагаа нь дэлхийн банк санхүүгийн үйлчилгээг Монгол Улсад улам ойртуулах, Монгол Улсын бизнес эрхлэгчдийг олон улсын зах зээлд дэмжих боломжийг бүрдүүлж байна.

ГАДААД ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ШУГАМ, АШИГЛАЛТАА НЭМЭГДҮҮЛЭЭ

Голомт банк нь харилцагчиддаа илүү өргөн сонголт бүхий гадаад худалдааны санхүүжилтийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор өнгөрөгч онд шинээр Денмаркийн Nordea банк, Оросын Rosexim, IIB, Польшийн BGK, Туркийн Küveyt Katılım Bankası, Чехийн CSOB зэрэг банкуудтай шинээр хамтын ажиллагааг эхлүүллээ. Эдгээр хамтын ажиллагаа нь тухайн улс, бүс нутгаас бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж импортолж байгаа болон тухайн улсын бизнес эрхлэгчидтэй хамтарсан бизнес хийж буй аж ахуйн нэгжүүдэд зах зээлийн нөхцөлөөс хямд өртөг бүхий санхүүжилтийн боломжуудыг нээж өгч буйгаараа өндөр ач холбогдолтой билээ.

Гадаад худалдааны санхүүжилтийн бүтээгдэхүүн үйлчилгээ



Импорт & Экспортын аккредитив



Стандбай аккредитив, Гадаад баталгаа, Давхар баталгаа



Аккредитивийн баталгаажуулалт



Аккредитивийн дараах санхүүжилт



Баримтат төлбөр тоцоо



Импортын зээл



ECA

Харилцагчдынхаа санхүүгийн боловсрол, худалдааны санхүүжилтийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх нь бидний чухал зорилтын нэг хэсэг бөгөөд бид өнгөрөгч онд МҮХАҮТ-тай хамтран Гадаад худалдааны санхүүжилтийн боломжууд семинарыг байгууллагын харилцагч нартаа зориулан амжилттай зохион байгууллаа. Тус семинарийн үеэр хамтын ажиллагаатай гадны гадаад худалдааг дэмжих холбоодыг урьж оролцуулсан нь харилцагчдын хувьд худалдааны санхүүжилтийн талаарх мэдлэгээ дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

КАСТОДИАН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Голомт банкнаас санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлд бусад оролцогч тал, зохицуулагч байгууллага, гадаадын түншүүдтэйгээ хамтран 2015 онд амжилттай гүйцэтгэсэн ажлын нэг нь Кастодиан банкны үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүлсэн явдал байлаа.

2014 оны 8 сар	СЗХ-оос кастодианы үйлчилгээ эрхлэх анхны эрхийг авсан
2015 оны 2 сар	Кастодианы анхны харилцагчаар олон улсын IBEC (International Bank of Economic Co-operation) банкиг татаж, данс нээсэн
2015 оны 4 сар	NRIFT (Nomura Research Institute Financial Technologies) компанитай хамтран ажиллах санамж бичиг байгуулснаар кастодианы бүртгэлийн ICS системийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн
2015 оны 8 сар	ICS системийг үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн
2015 оны 9 сар	Кастодиан банкны нээлтийн ёслолд гадаад дотоодын 100 гаруй өндөр хэмжээний зочид уригдаж оролцсон

2015 оны 10 сар	ICS системийн 2 дахь хувилбарыг нэвтрүүлснээр банкны үндсэн систем болон харилцагч банкуудтай SWIFT сүлжээгээр холбогдох боломжтой болсон
2015 оны 11 сар	ICS системийн 3 дахь хувилбарыг нэвтрүүлснээр бүх төрлийн хөрөнгө оруулалтын сангуудад бүрэн үйлчилгээ үзүүлэх боломжтой болсон

ОЛОН УЛСЫН ҮНЭЛГЭЭ

S&P: /B-/ Outlook Stable

2015 оны 11 сард Олон улсын үнэлгээний байгууллага болох Standard and Poor's агентлаг нь Монголын эдийн засагт тулгарч буй удаашрал ойрын хугацаанд үргэлжлэх хандлагатай хэмээн үзэж Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг нэг шатаар буюу B+ байсныг B болгож бууруулсан билээ.


Энэхүү шалтгаанаар Монголын арилжааны банкуудын үнэлгээ даган буурсан нь Голомт банкны урт хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээ B- болж буурахад нөлөөлсөн ба банкны хэтийн төлөвийг Сөргөөс Тогтвортой болгож үнэлсэн.

Moody's: /B2-Local currency deposit/, Outlook- Negative

Олон улсын үнэлгээний байгууллага болох Moody's нь 2015 оны 5 сард Голомт банкны урт болон богино хугацааны эрсдэлийн үнэлгээнд B2, дотоод валютын эх үүсвэрт B2, гадаад валютын эх үүсвэрт B3 гэсэн үнэлгээнүүдийг тус тус өгөөд байна. Тус үнэлгээний байгууллага нь Монголын эдийн засгийн хэтийн төлөвийг Сөрөг гэж үнэлсэнтэй уялдаж, арилжааны банкуудын хэтийн төлөвийг мөн Сөрөг гэж үнэлсэн болно.

Хүний нөөц

ТООН ҮЗҮҮЛЭЛТ



2015 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ ХӨТӨЛБӨРҮҮД

- Хүний нөөцийн сонгон шалгаруулалт, сургалт хөгжлийн урт хугацааны хөтөлбөр
- Харилцагчийн үйлчилгээний ажилтнуудад сегментчилсэн сургалт хөгжлийн хөтөлбөр
- Нийт 6,880 хүн/цагийн хувийн хөгжлийн хөтөлбөрийг амжилттай зохион байгууллаа.

Кайзен, бүтээмжийн хөтөлбөр



Ажилтнуудаас нийт 2,038 санал ирснээс 22 саналыг байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн бодит үр дүн болгож ажиллалаа

Тэтгэврийн ууган сан



Тэтгэврийн ууган сан 2015 онд 1,300 гаруй гишүүнтэй болж, нийт хуримтлалын сангийн хэмжээ 35 хувиар өсч 5.9 тэрбум төгрөгт хүрлээ


Спортын үйл ажиллагаа



150 гаруй ажилтнууд 80 километр замыг явган аялж, далайн түвшнээс дээш 2,799 метр өндөрт орших Хэнтийн нурууны ноён оргил Асралт хайрханд Монгол Улсын төрийн сүлдийг заллаа

Технологийн хүрээнд хийгдсэн гол ажлууд

Удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлснээр үйл ажиллагааны чанар бүтээмжийг нэмэгдүүлэн ажиллав.



Голомт банкнаас санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлд бусад оролцогч тал, зохицуулагч байгууллага, гадаадын түншүүдтэйгээ хамтран 2015 онд амжилттай гүйцэтгэсэн ажлын нэг нь Кастодиан банкны үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүлсэн явдал байлаа.

2015 онд Голомт банк нь
Тогтвортой санхүүжилтийн
бодлогыг амжилттай баримтлан
ажилласан тул Тогтвортой
санхүүжилтийн бодлогоор
манлайлагч банкаар тодорч,
2016 онд бусад банкуудаа
манлайлж ажиллах юм.

Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлууд

Боловсролыг дэмжигч Голомт банк

Голомт банк бизнесийн байгууллагуудаас анхлан санаачилж оюутанд зориулсан багц хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн бөгөөд 2015 онд Оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг 13 дахь жилдээ зохион байгууллаа

НИЙТ
1,300
оюутанд

1 ТЭРБУМ
төгрөгийн
тэтгэлэг
олгожээ

GOLOMT BANK
20 Years
1995-2015

Голомт банк 20 жилийн ойгоо тохиолдуулан Монгол Улсын
Засгийн газраас зарласан хамгийн эрэлт, хэрэгцээтэй
20 мэргэжлээр суралцаж
буй оюутнуудыг хамруулснаараа онцлогтой юм

Голомт банк иргэд харилцагчдынхаа санхүүгийн боловсролыг дэмжих зорилгоор банк, санхүү,
эдийн засгийн цогц ойлголтыг хамгийн энгийн, ойлгомжтой тайлбарласан WWW.EDU.GOLOMTBANK.COM сайтыг нээлээ

www.edu.golomtbank.com
ТАНЫ САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛД

6,000
орчим

Банк санхүүгийн
англи үгний ухагдахуун, ойлголтыг багтаасан
тайлбар толь бичгийг Монгол Улсад анх удаа нэвтрүүлээ



Харвардын их сургуулийн
Азийн манлайлал төвийн санаачилгаар
Монгол Улсад анх удаа
зохион байгуулагдсан

AsiaLeadership
Conference-2015

чуулга уулзалтын ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллалаа

Монгол Улсын Морин хуурын чуулгын Албан ёсны түншээр сонгогдож үндэсний соёл урлагийг хөгжүүлэх,
өв соёлыг хайрлан хамгаалах их үйлсэд хувь нэмрээ оруулан 4 дэх жилдээ ажиллаж байна



Голомт банкны нэрэмжит
Оюутны эрдэм
шинжилгээний бага хурал



14 дэх
жилдээ
амжилттай зохион байгуулагдлаа



Монголын хүүхдүүдийн
сайн сайхны төлөөх
Алтан түлхүүр санд



475 сая
төгрөг
хуримтлуулаад байна



Эх үрсийн баяраар
бяцхан харилцагчдаа болон
Зөв амьдрах ухаан ТББ-ын

30 гаруй
хүүхдийг
баярлууллаа

Монгол Улсын 3 сая дахь иргэн Х.Монголжин охины ирээдүйн сайн сайханд зориулж 3 сая төгрөг бүхий
Алтантүлхүүр хүүхдийн хадгаламж нээж бэлэг барилаа

ГОЛОМТ БАНК ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ

- ЭХЭМҮТ-ийн Нярайн судлалын танхимыг бүрэн тохижуулснаар улсын хэмжээний бүх дутуу төрөлт, зүрхний эмгэгтэй болон хүндрэлтэй төрөлтийг хүлээн авч яаралтай тусламж үзүүлэх боломж бүрдлээ.



- Голомт банкны 1,800 гаруй ажилтан албан хаагчид Цусны төвтэй хамтран Донорын өдөрлөгийг зохион байгууллаа.

- Голомт банк Мөнхчулуун сантай хамтран АНУ-ын MedWish байгууллагаас Монгол Улсын эмнэлгүүдэд нэн шаардлагатай байгаа эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нийлүүлэх ажлыг зохион байгууллаа.
- Голомт банкны ажилтнууд MN-25-р суваг телевизээс санаачилсан 1,000 төгрөг аянд чин сэтгэлийн хандив өргөж, ГССҮТ-д нэн шаардлагатай байсан тоног төхөөрөмжийг авахад хувь нэмрээ оруулсан юм.

Голомт банк ногоон ирээдүйн төлөө



Голомт банк нь Монгол Улсаас анх удаа НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөрийн Санхүүгийн Санаачилга буюу UNEP FI-д нэгдэж, гишүүнээр элслээ



Эх дэлхийгээ хайрлах, байгаль орчноо хамгаалах зорилтын хүрээнд

Цаасгүй банк
аяныг өрнүүлээ



Харилцагч хүссэн үедээ дансан дахь мөнгөө хянах, төлбөр төлөх, шилжүүлэх зэрэг банкны бүх төрлийн үйлчилгээг авах боломжтой болов

Голомт банк нь ТоС-ийн бодлогын хүрээнд жирэмсэн болон 0-2 насны хүүхдэдэй эхчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дараалалгүй үйлчилж эхэллээ

Голомт банк нь үйл ажиллагааныхаа бүхий л түвшинд байгаль орчин, нийгэмд ээлтэй, ил тод бизнесийг дэмжин ажиллаж ирсэн бөгөөд энэхүү зарчмуудыг суурь болгосон Тогтвортой санхүүжилтийн бодлогыг / ТоС / Монголын банкуудын холбоотой хамтран батлаад байна.



2015 онд Голомт банк нь Тогтвортой санхүүжилтийн бодлогыг амжилттай баримтлан ажилласан тул Тогтвортой санхүүжилтийн бодлогоор манлайлагч банкаар тодорч, 2016 онд бусад банкуудаа манлайлж ажиллах юм.

Голомт банк эх орны хөгжлийн төлөө



Монголын эдийн засгийн чуулган-2015-ын
алтан ивээн тэтгэгчээр ажиллалаа.

Уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчдын



DISCOVER MONGOLIA

чуулганыг уламжлал ёсоор **ИВЭЭН ТЭТГЭВ**

Голомт банк, Мандал женерал даатгал, Монголын бизнесийн зөвлөл хамтран Монгол Улсын Эрсдэлийн удирдлагын форум 2015-ыг амжилттай зохион байгууллаа



Хөнгөн үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй харилцагчиддаа зориулан **Өрсөлдөх чадварыг хөгжүүлэх нь** сэдэвт анхдугаар зөвлөгөөнийг амжилттай зохион байгууллаа



Монгол Улсад анх удаа **Монголд үйлдвэрлэв аж үйлдвэрийн чуулган-2015** зохион байгуулагдаж, ивээн тэтгэв

Харилцагч банкууд

№	УЛС	ХАРИЛЦАГЧ БАНКУУД	СВИФТ БОЛОН ТЕЛЕКС ДУГААР	МӨНГӨНИЙ НЭГЖ	НОСТРО ДАНС
1.	Australia	AUSTRALIA AND NEW ZEALAND BANKING GROUP ANZ CENTRE MELBOURNE, LEVEL 9, 833 COLLINS STREET DOCKLANDS, VICTORIA, AUSTRALIA, 3008	ANZBAU3M	AUD	920660AUD00001
2.	Austria	RAIFFEISEN BANK INTERNATIONAL AG VIENNA 1030 VIENNA AUSTRIA	RZBAATWW	EUR	1-55 076 335
3.	Canada	CANADIAN IMPERIAL BANK OF COMMERCE TORONTO MSG 2M8, CANADA	CIBCCATT	CAD	1818910
4.	China	AGRICULTURAL BANK OF CHINA (Beijing) INT.L DEPT. 5/F, JIN YU PLAZA ROAD, BEIJING100036, P.R.CHINA	ABOCCNBJ	USD	8211000908
5.		AGRICULTURAL BANK OF CHINA (Huhhot) (NEIMENGGU BRANCH) HUHEHAOTE, INNER MONGOLIA, P.R.CHINA	ABOCCNBJ050	USD CNY	05999914040000049 05999901040000053
6.		BANK OF CHINA INNER MONGOLIA BRANCH ERLIAN SUB-BRANCH, P.R.CHINA	BKCHCNBJ880	USD CNY	155605293946 154005293944
7.		BAOSHANG BANK INNER MONGOLIA BRANCH BAOTOU, P.R.CHINA	BTCBCNBJ	CNY USD	002105599800010 002105599800020
8.		CHINA CONSTRUCTION BANK NEIMENGGU BRANCH, P.R.CHINA	PCBCCNBJNME	USD CNY	NRA15014150500220100181 15001658408052502177
9.		INDUSTRIAL AND COMMERCIAL BANK INNER MONGOLIA BRANCH NO.105, XILIN NORTH ROAD HOHHOT, INNER MONGOLIA, P.R.CHINA	ICBKCNCNBJNMA	USD CNY	0610040629200061234 0610040609200054391
10.		BANK OF INNER MONGOLIA 33 TENG FEI ROAD, HUHHOT, INNER MONGOLIA, P.R.CHINA 010020	HSSYCNCBH	USD CNY	115914236000000184 115901236000000122
11.		BANK OF COMMUNICATIONS INNER MONGOLIA BRANCH, NO.18, HOHHOT, INNER MONGOLIA, P.R.CHINA 010010	COMMNCNSH	CNY	151899991010003021570
12.		CHINA CITIC BANK HUHEHAOTE BRANCH HUHEHAOTE, P.R.CHINA	CIBKCNBJ010 Bank Code: 302191027101	USD CNY	72711114860000000181 72711110186000000155

13.		COMMERZ BANK AG, FF/AM MAIN 60261 FRANKFURT AM MAIN FRANKFURT AM MAIN	COBADEFF	USD EUR CHF GBP JPY CNH	400 878 506 500 400 878 506 501 400 878 506 500 400 878 506 500 400 878 506 500 400 878 506 508
14.	Germany	DEUTSCHE BANK AG 60262, FRANKFURT AM MAIN, GERMANY	DEUTDEFF	EUR	100-9517673-0000
15.		BERLINER SPARKASSE- LANDESBANK BERLIN AG ALEXANDERPLATZ 2, 10178 BERLIN, GERMANY	BELADEBE	USD EUR	10050000/3270000250 10050000/6630008373
16.	Hong Kong	BANK OF CHINA (HONG KONG) LIMITED BANK OF CHINA TOWER, 1 GARDEN HONG KONG	BKCHHKHH	HKD CNY USD	012-875-60115674 01287560118495 01287560121220
17.	Japan	MIZUHO BANK LTD MARUNOUCHI, CHIYODA-KU, TOKYO 100-8210 JAPAN	MHCBJPJT	JPY	6740010
18.		SUMITOMO MITSUI BANKING CORPORATION 1-2 YURAKUCHO 1-COME, CHIYODA- KU, TOKYO, JAPAN	SMBCJPJT	USD JPY	3623 4374
19.		BANK OF TOKYO MITSUBISHI JP TOWER, 2-7-2 MARUNOUCHI, CHIYODA-KU, TOKYO 100-0005, JAPAN	BOTKJPJT	USD JPY	653-0455601 653-0432881
20.	Kazakhstan	KAZKOMMERTSBANK JOINT-STOCK COMPANY 135G, GAGARIN ST., ALMATY, 050060, REPUBLIC OF KAZAKHSTAN	KZKOKZKX	USD	KZ769260001000694001
21.	Korea	KEB HANA BANK 181, 2-KA, 181, EULJIRO 2-GA, JUNG- GU, C.P.O. BOX 2924, SEOUL 100-793, KOREA	KOEXKRSE	USD KRW	963-THR-313-01-2 0963FRW001000054
22.		SHINHAN BANK, SEOUL P.O.BOX 2997 SEOUL 100-629, KOREA	SHBKKRSE	USD KRW	0102245USD01 0102245KRW01
23.		KOOKMIN BANK, SEOUL 10, YEQUIDO-DONG, YOUNGDEUNGPO- GU, SEOUL, KOREA 150-868	CZNBKRSE	USD KRW	819-8-USD-0-15 819-8-KRW-0-17
24.	Taiwan	LAND BANK OF TAIWAN HEAD OFFICE 46, KUAN CHIEN ROAD, TAIPEI, TAIWAN, REPUBLIC OF CHINA	LBOTTWTP	USD	088-185-00002
25.	Turkey	YAPI ve KREDİ BANKASI A.Ş YAPI KREDİ PLAZA D BLOK, LEVENT 34330 ISTANBUL, TURKEY	YAPITRIS	USD	95711515

26.	Poland	mBANK 18 SENATORKA STREET, 00-950 WARSAW, POLAND	BREXPLPW	PLN	IBAN: PL 52 114 000 000 000 114 851 001 001
27.	Russia	SBER BANK, 31 DEPUTATSKAYA ST, 664047, IRKUTSK RUSSIA	SABRRU66 231231	USD RUB	30111840518000000003 30111810618000000001
28.		SBER BANK, MOSCOW 19 VAVILOVA STREET, 117997 MOSCOW, RUSSIA	SABR RUM 012	USD RUB	30111840100000000840 30111810800000000840
29.		JSC BANK FOR FOREIGN TRADE BIK: 044525187, RUSSIA K/S: 30101810700000000187	VTBRRUMM	RUB USD	30111810655550000126 30111840155550000104
30.		RUSSIAN AGRICULTURAL BANK 119034 MOSCOW, RUSSIA BIK: 044525111 K/S: 30101810200000000111	RUAGRUMM	USD RUB	30111840300000000006 30111810200000000013
31.	Singapore	UNITED OVERSEAS BANK LIMITED 80 RAFFLES PLACE, #05-00 UOB PLAZA 1 SINGAPORE 048624	UOVBSGSG	SGD	301-399-069-5
32.		DBS BANK MARINA BAY FINANCIAL CENTRE, TOWER 3, SINGAPORE, 018982	DBSSSGSG	USD	0710-000182-01-5
33.	United Kingdom	BARCLAYS BANK PLC 1 CHURCHILL PLACE, LONDON E14 5HP, UK	BARCGB22 Sort Code: 20-32-53	GBP	43379779 IBAN: GB33BARC20325343379779
34.	USA	STANDARD CHARTERED BANK NEW YORK, NY 10036, USA	SCBLUS33	USD	3582-026934-001
35.		DEUTSCHE BANK TRUST COMPANY AMERICA NEW YORK, NY 10004, USA	BKTRUS33	USD	04453138
36.		MASHREQ BANK PSC 255 AVENUE, NY10016, USA	MSHQUS33	USD	70010461

Худалдааны санхүүжилтээр хамтран ажиллагч банк санхүүгийн байгууллагууд

Commerzbank AG, Frankfurt am Main, Germany	COMMERZBANK 
Deutsche Bank AG, Frankfurt am Main, Germany	Deutsche Bank 
Atlantic Forfaitierungs AG, Zurich Switzerland	atlantic forfaitierungs ag
Asian Development Bank, Manila, Philippines	ADB
Industrial & Commercial Bank of China	ICBC  中国工商银行
Baoshang Bank, China	 包商银行 BAOSHANG BANK
The Export-Import Bank of the ROC, Taiwan	 The Export-Import Bank of the ROC
BHF-Bank AG, Frankfurt am Main, Germany	BHF  BANK PRIVAT SEIT 1854
The Export-Import Bank of Korea, Seoul	 한국수출입은행 THE EXPORT-IMPORT BANK OF KOREA
Nordea Bank Denmark	Nordea 
Unicredit Bank	 UniCredit Bank
Hungarian EXIM Bank	 EXIM EXPORT-IMPORT BANK
BGK, Bank Gospodarstwa Krajowego, Poland	 BANK GOSPODARSTWA KRAJOWEGO
Vnesheconombank, Russia	 VNESHECONOMBANK
International Investment Bank, Russia	 INTERNATIONAL INVESTMENT BANK
SACE, Italy	 SACE
CSOB, Czech Republic	 CSOB
Kuveyt Türk Katılım Bankası, Turkey	 KUVEYTÜRK
RosExim, Russia	 РОСЭКСИМБАНК

Эрсдэлийн удирдлага

Үр ашигтай буюу зохистой эрсдэлийн удирдлага нь банкны амжилтын гол үндэс төдийгүй банкны стратеги зорилтуудыг биелүүлэх гол хөшүүрэг нь болдог. Энэхүү ойлголтыг банкны шат шатны удирдлагууд бүрэн ойлгож, хүчтэй эрсдэлийн удирдлага, зөв эрсдэлийн соёлыг бүрдүүлэх замаар банкны ажилтан бүрийг өөрийн хариуцсан чиглэлийн дагуу эрсдэлийн удирдлагын зохих мэдлэгтэй болгож, удирдлагаас өгөгдсөн эрх хэмжээний дагуу өөрийн гаргасан шийдвэрт хариуцлага хүлээх, эрсдэлийн удирдлагыг банкны хэмжээнд бүрэн хэрэгжүүлэхэд амжилттай ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Голомт банкны эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь эрсдэлийн хязгаарлалтын түвшинд эрсдэл болон өгөөжийн харьцааг хамгийн оновчтой байлгахад чиглэгдэж байна. Өнөөдрийн тасралтгүй хөгжин дэвшиж, хувьсан өөрчлөгдөж буй улс төр, эдийн засгийн нөхцөл байдалд банк эрсдэлийн чиг хандлагад үнэлэлт дүгнэлт өгч, шаардлагатай тохиолдолд бизнес болон бусад үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн хөгжүүлдэг. Үүний томоохон жишээ нь банкны Хямралын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон Засаглалын кодекс шинэчлэгдэн батлагдсан бөгөөд олон улсын түвшинд нэр хүнд бүхий Инфосис корпорацийн Финакл бүртгэлийн үндсэн системийг иж бүрнээр нь амжилттай нэвтрүүлсэн явдал юм.



Голомт банк нь гурван давхар хамгаалалтын шугам бүхий эрсдэлийн удирдлага бүхий банкны бүтцийг шинэчлэн баталж, нэгжүүдийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог улам сайжруулан ажилласаар байна. Үүнд:

- Бизнесийн нэгжүүд нь өөрийн нэгжийн үйл ажиллагаанд тулгарч болох эрсдэлийг удирдаж, гаргасан шийдвэрүүддээ бүрэн хариуцлага хүлээн ажилладаг.
- Эрсдэлийн удирдлагын газар нь Эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлж, бизнесийн нэгжүүдийн эрсдэлийг удирдах үйл ажиллагаанд хяналт тавин холбогдох зохицуулалт, дүрэм, журам, стандарт, зөвлөмжийг банкны эрсдэлийн хязгаарлалтууд, үйл ажиллагааны цар хүрээнд зохистой байлгах бодлого барин боловсруулж, хяналт тавин ажиллаж байна.
- Дотоод аудитын газар нь нэг ба хоёрдугаар шугамын хүрээнд хяналтын шаардлагууд биелж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт шалгалт хийж дүгнэлт гарган цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж, үүрэг өгөн ажиллаж байна.

Голомт банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь эрсдэлийн засаглал, соёл, хязгаарлалтууд, арга хэрэгслүүд гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсгээс тогтдог.

1. Бизнесийн нэгжүүд	2. Эрсдэлийн удирдлагын газар	3. Дотоод аудитын газар
- Нэгж бүр өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой үүсэх эрсдэлийг хариуцах - Аливаа шийдвэр гаргалтандаа эрсдэл, өгөөжийг тооцох - Нэгжийн үйл ажиллагаа нь банкны эрсдэлийн бодлого, аппетит, журамтай нийцэж байгаа эсхийг тогтмол хянаж, баталгаажуулах - Нэгжийн KPI-д бизнес болон санхүүгийн үзүүлэлтүүдээс гадна эрсдэлийн аппетитыг хангах үзүүлэлтүүдийг тусгах	- Эрсдэлийн удирдлагын үр ашигтай хэрэгжилтэд банкны бусад нэгжүүдээс хараат бусаар хяналт тавих - Эрсдэлийн удирдлагын бодлого, хяналт болон эрсдэлийн хязгаарыг тодорхойлж, тайлагнах - Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд бизнесийн нэгжүүдэд шаардлага тавих - Банкны бодлого журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулах	- Банкны үйл ажиллагаанд хараат бус, бие даасан хяналтыг хэрэгжүүлэх - Эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон хяналтын системийн зөв зохистой байдалд үнэлэлт дүгнэлт өгөх - Аудитын хороо болон удирдлагуудад банкны үйл ажиллагааг үнэн зөв, бодитой тайлагнах

Эрсдэлийн засаглал

Үр ашигтай эрсдэлийн удирдлага нь байгууллагад зохицсон эрсдэлийн удирдлагын хүчтэй засаглалд суурилдаг тул Голомт банкны ТУЗ нь өөрийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд шууд тайлагнах үүрэг бүхий Эрсдэлийн удирдлагын газрын дэмжлэгтэйгээр эрсдэлийг удирдахад идэвхитэй оролцдог.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ нь Эрсдэлийн удирдлагын бодлого, хязгаарлалтуудыг баталж хэрэгжилтийг улирал бүр Эрсдэлийн хороогоор дамжуулан хянан баталгаажуулдаг.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА


Гүйцэтгэх удирдлагууд нь ТУЗ-өөс баталсан эрсдэлийн бодлого, хязгаарлалтуудын хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Дотоод аудит, Эрсдэлийн удирдлагын газар нь банкны нэгж, ажилтнууд Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж, Гүйцэтгэх захирал түүний дэргэдэх Удирдлагын хорооноос гадна ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд шууд тайлагнадаг.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР

Эрсдэлийн удирдлагын газар нь банкны эрсдэлийн удирдлага, түүний тогтолцоо, хэрэгжүүлэх арга хэрэгслүүдийг бизнесийн нэгжүүдээс хараат бусаар хэрэгжүүлдэг.

УДИРДЛАГЫН ХОРОО

ТУЗ-өөс батлах банкны стратеги, бодлого, бизнес төлөвлөгөө, бусад баримт бичгүүдийн төсөлд эрсдэлийн удирдлагатай холбоотой шийдвэрлэх асуудлыг тусган, эрсдэлийн хязгаарлалтын хэрэгжилт, хяналт, санхүүгийн гүйцэтгэлийг үнэлэн, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны талаар хэлэлцэн зохистой шийдвэрийг гарган ажилладаг.



Голомт банк нь үр ашигтай эрсдэлийн удирдлагын гол үзүүлэлт болох эрсдэлийн хязгаарлалтуудыг банкны хэмжээнд, холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээг тооцоолон зохистой хэмжээнд боловсруулан баталж, хэрэгжүүлж ажилладаг.

ЗЭЭЛИЙН ХОРООД

Зээлийн хороод нь зээлийн хэмжээнээс шалтгаалан Зээлийн хороо болон Зээлийн дэд хороо гэсэн бүтцээр ажилладаг. Эдгээр хороод нь ТУЗ-өөс баталсан Эрсдэлийн удирдлагын бодлого, Зээлийн хязгаарлалтын хүрээнд шийдвэр гарган, Зээлийн үйл ажиллагааны журам заавар стандартыг батлан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилладаг.

АКТИВ, ПАССИВЫН ХОРОО

Банкны актив, пассивыг оновчтой удирдах замаар банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлэхийн хамт холбогдох эрсдэлийн хязгаарлалтуудыг хангах чиглэлээр шат дараалсан арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд дэмжлэг болон ажилладаг.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН СОЁЛ

Голомт банкны бизнесийн нэгжүүд нь өөрсдийн бизнес төлөвлөгөөг банкны эрсдэлийн удирдлагын бүтцэд нийцүүлэх, нэгжийн үнэлгээнд эрсдэлийн үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг зохистой хэмжээнд байлгах, үүнтэй холбоотой хариуцлагыг тухайн нэгж, түүний удирдлага бүрэн хүлээх чиглэлээр холбогдох журам, заавар бизнес төлөвлөгөө, үнэлгээний аргачлалд тогтмол өөрчлөлт, шинэчлэлт хийдэг. Үүний зэрэгцээ эрсдэлийн удирдлагатай холбоотой гадаад дотоод сургалт хөтөлбөрүүдэд Эрсдэлийн удирдлагын газраас гадна бусад нэгжийн удирдлага, ажилтнуудыг тогтмол хамруулдаг болно.

ЭРСДЭЛИЙН АППЕТИТ

Голомт банк нь үр ашигтай эрсдэлийн удирдлагын гол үзүүлэлт болох эрсдэлийн хязгаарлалтуудыг банкны хэмжээнд, холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээг тооцоолон зохистой хэмжээнд боловсруулан баталж, хэрэгжүүлж ажилладаг. Банкны эрсдэлийн хязгаарлалтуудын гол эрсдэлүүдийг тодорхойлох судалгаа, эрсдэл даах чадварын үнэлгээ, гол эрсдэлийн хязгаарлалтуудыг тооцох аргачлалуудыг тодорхойлох замаар стратегийн болон санхүүгийн зорилтуудтай уялдуулан тоон болон чанарын үзүүлэлтүүдээр тодорхойлж өгдөг.

Зээлийн эрсдэлийн удирдлага

Банкны зээлийн Эрсдэлийн удирдлагын хэлтэс нь зээлийн багцын чанарт дүгнэлт өгөх, үүссэн зээлийн эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах мөн үүсч болзошгүй зээлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого боловсруулан ТУЗ-өөр батлуулж, салбар нэгжүүдээр хэрэгжилтийг хангуулж ажилладаг.

2015 онд хэрэгжүүлсэн банкны бүтцийн өөрчлөлтийн үр дүнд, Зээлийн эрсдэлийн удирдлагын хэлтсийн бүтцийг өргөжүүлэн шинэчилсэн. Ингэснээр Зээлийн эрсдэлийн удирдлагын хэлтэс нь судалгаан дээр илүү суурилсан арга аргачлал болон бодлого, зөвлөмж боловсруулдаг болсон.

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллахын зэрэгцээ олон улсын тайлагналын стандарт, НББОУС-д гарсан шинэчлэлийг тухай бүрт нь банкны үнэ цэнийн бууралт тооцох журамд тусгаж мөрдөн ажиллаж байна.

Банкны үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр зээлийг тухайн өдөрт нь бус цаг, минутын дотор шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлага нэмэгдсээр байна. Иймд банкны түүхэн өгөгдөл дээр үндэслэсэн кредит скорингийн загварыг боловсруулж цалин, кредит карт, орон сууц зэрэг зээлийн бүтээгдэхүүн дээр нэвтрүүлэх боломжтой болсон. Түүнчлэн кредит рейтинг тогтоох аргачлалыг боловсруулж банкны корпорейт болон SME харилцагчдын рейтингийг тогтоож байна.

2016 онд Зээлийн эрсдэлийн удирдлагын хэлтэс нь зээлийн мэдээллийн үнэн зөв байдлыг хангуулж, нэгдмэл арга аргачлал бүхий мэдээллийн нэгдсэн баазтай болох, дотоод болон гадаад үнэн зөв, стандартчлагдсан тайлан мэдээгээр хэрэглэгчдийг хангах, зээлийн кредит рейтинг дээр суурилсан watch list-ийг хөгжүүлснээр зээлийн учирч болзошгүй эрсдэлийг бууруулах боломжийг бүрдүүлсэн юм.

Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Зах зээлийн эрсдэлд валютын ханш, хүү, үнэт цаасны багцын болон төлбөрийн чадварын эрсдэл хамаарна. Зах зээлийн эрсдэлийн аппетитыг Эрсдэлийн удирдлагын хороогоор хэлэлцэж, ТУЗ-өөс баталдаг бөгөөд хэрэгжилтийг Актив пассивын хороо хянадаг.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО



Нөөцийн удирдлагын газар нь бодлогын хэрэгжилтийг хангуулах, тогтоогдсон эрсдэлийн хязгаарлалтуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох замаар зах зээлийн эрсдэлийн өдөр тутмын удирдлагыг хэрэгжүүлж ирсэн.

Эрсдэлийн удирдлагын газар нь зах зээлийн эрсдэлийн сөрөг нөлөөллийн түвшин, хүлээгдэж буй хандлагыг урьдчилан илрүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний санал боловсруулж Эрсдэлийн удирдлагын хороонд тайлагнадаг.

ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛ

Арилжааны багцын гол эрсдэл нь гадаад валют болон санхүүгийн хэрэгслүүдийн хүү, зах зээл дэх хөрвөх чадвар, үнийн өөрчлөлтөөс үүсдэг. Бид ханшийн тэгшитгэлээс үүсэх алдагдал болон нээлттэй позицын эрсдэлээр жигнэсэн активд үзүүлэх нөлөөг дотооддоо гурван төрлийн Хамгийн их эрсдэл (ХИЭ) буюу Value at Risk (VaR) аргаар тооцож ирсэн бөгөөд 2015 оноос эхлэн Монголбанкны тусгай зөвшөөрлийн эрхийг албан ёсоор авсан.



VaR нь тодорхой хугацааны хязгаарт багцын зах зээлийн үнэлгээнд гарч болох боломжит сөрөг өөрчлөлтийг өгөгдсөн итгэлцлийн түвшинд тооцоолдог техник юм.

Бид нэг болон арван өдрийн хугацаатайгаар VaR-ыг тооцож байгаа бөгөөд үүнийг өнгөрсөн үеийн бодит ашиг алдагдлын утгатай нь харьцуулах загвараар тест хийн шалгадаг. Түүнчлэн VaR-аар олж авсан боломжит алдагдлын хэмжээгээр банкны стресс тест хийж гүйцэтгэдэг.

ХҮҮГИЙН ЭРСДЭЛ

Банкны арилжааны бус багцад бий болдог зах зээлийн гол эрсдэл буюу хүүгийн түвшний өөрчлөлт нь банкны ашиг, улмаар өөрийн хөрөнгөд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах зорилгоор хүүгээс хамаарсан хөрөнгүүдэд хяналт тавих, хязгаарлалт тогтоох аргачлалыг ашиглаж байна.


Эдгээр арга хэрэгслүүд нь хүүгийн зөрүүний шинжилгээ, хугацааны зөрүүний шинжилгээ, хүүгийн орлогын төсөөлөл зэргийг тооцоход ашиглагддаг. Хүүгийн хязгаарлалтын систем нь дараах хэсгүүдээс бүрддэг.

Үүнд:

- хамгийн их алдагдлын хязгаар
- хүүгийн зөрүүний хязгаар
- нөөцийн хуваарилалтад хүүг хамгийн бага байлгах зэрэг болно.

ХӨРВӨХ ЧАДВАРЫН ЭРСДЭЛ

Голомт банк нь хөрөнгийн хөрвөх чадварыг зохистой түвшинд хангах ажлын хүрээнд Монголбанкнаас тогтоосон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа болон хөрвөх чадварын бусад үзүүлэлтүүдийг тогтмол ханган ажиллаж байна.



Голомт банкны хөрвөх чадварын удирдлагын тогтолцоо нь зах зээлийн хэвийн болон хэвийн бус нөхцөлд дурдсан санхүүгийн үүргүүдээ бүрэн гүйцэтгэж чадахуйц хөрвөх чадварын баталгаат түвшнүүдийг тогтоох, хянах, удирдахад чиглэдэг.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын удирдлагыг хэрэгжүүлэгч нэгж нь Нөөцийн удирдлагын газар бөгөөд Эрсдэлийн удирдлагын газар болон холбогдох бүх нэгжтэй уялдаа холбоотой ажилладаг ба зохистой түвшин, ирээдүйн таамаглал, стресс тестийн үр дүнд үндэслэн хөрвөх чадварын эрсдэлийг удирдан ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороогоор банкны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, олон улсын практик туршлага болон хуулийн шаардлагуудад нийцүүлэн хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын зөвлөмжүүдийг тухай бүр гарган, шаардлагатай хязгаарлалтуудыг тогтоон мөрдүүлэх чиглэл өгч ажиллаж байна.

Актив пассивын хорооны хурлын мониторингийн процесс нь дотоод болон гадаад хяналтын системээр дамжин хэрэгждэг. Хөрвөх чадварын эрсдэлийг дараах арга хэрэгслүүдээр үнэлж хяналтыг хэрэгжүүлдэг.

Үүнд:

- Сарын давтамж дээр үндэслэсэн хүү, хугацаа, гадаад валютын зөрүүний шинжилгээ
- Орох гарах мөнгөн урсгалын таамаглал, тайлан балансын урт хугацааны таамаглал
- Санхүүгийн удирдлагын газраас сар бүрээр гаргасан актив пассивын оновчтой бүтцэд хяналт тавих
- Өдрийн давтамжтай төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаанууд, хамгийн бага нөөцийн шаардлагууд,
- Хөрөнгийн удирдлага, Байгууллагын банк, бусад дотоод газар хэлтсээс гаргасан аналитик тайлан, хөрөнгийн зах зээлийн таамаглал, хөрвөх чадварын тайлан зэрэг дээр үндэслэсэн хүлээгдэж буй хөрвөх чадвартай холбоотой төсөөлөл, тооцооллууд багтана.

ТӨВЛӨРӨЛ БАГАТАЙ БАГЦ БУЮУ ХӨРӨНГИЙН ТАРААН БАЙРШУУЛАЛТ

Банкны хөрөнгө, эх үүсвэрийг эдийн засгийн секторууд болон том, групп харилцагчдаас хэт хамааралтай болохоос урьдчилан сэргийлэх, төвлөрлийг сааруулах зорилгоор төвлөрлийн эрсдэлийн хязгаарлалтуудыг тогтоодог.


Эх үүсвэрийн дийлэнхийг урт хугацаат харилцах, хадгаламж болон харилцагчдын оновчтой түүврээс (том, жижиг харилцагчдын хувьд) бүрдүүлэх замаар төвлөрлийн эрсдэлийг бууруулдаг.

СТРЕСС ТЕСТ

Эрсдэлийн удирдлагын газар нь гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас банкны эрсдэлийн үзүүлэлтүүдэд үүсэж болзошгүй нөлөөллийг үнэлэх зорилгоор, тусгайлсан болон системчилсэн стресс сценариудыг гарган, тэдгээрт нийцсэн мөнгөн урсгалын төсөөллүүдийг тогтмол хийдэг. Сценариуд нь түүхэн эсвэл төсөөлсөн үйл явдлын аль алинд суурилдаг.

Эдийн засгийн өсөлт удаашрах, санхүүгийн салбарын тогтвортой байдал алдагдах урьдач нөхцөл байдал үүсэх тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний нөөц төлөвлөгөөг боловсруулж ажилладаг. Ингэснээр эдийн засаг, санхүүгийн салбарт хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхой болж, хүндрэлийг зардал багатай даван туулах бололцоо бүрдэх юм.

Банкны хөрөнгө, эх үүсвэрийг эдийн засгийн секторууд болон том, групп харилцагчдаас хэт хамааралтай болохоос урьдчилан сэргийлэх, төвлөрлийг сааруулах зорилгоор төвлөрлийн эрсдэлийн хязгаарлалтуудыг тогтоодог.



Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь бизнесийн өргөн цар хүрээг хамардаг. Голомт банк нь энэхүү үйл ажиллагааны эрсдэлд тооцогддог дотоод үйл ажиллагаа, системийн сул хангалтгүй байдал, хүний санамсаргүй алдаа, санаатай үйлдлүүд, гадаад хүчин зүйлээс шалтгаалан үүсэх шууд болон шууд бус аливаа алдагдлыг зохистой хэмжээнд буюу эрсдэл өгөөжийн оновчтой түвшинд амжилттай удирдсаар ирсэн.

Банк нь гадаад хүчин зүйлээс шалтгаалсан, нэг удаагийн давагдашгүй хүчин зүйлээс бий болох, менежментээс үл хамаарах эрсдэлийг даатгалын цогц бодлогоор удирдан ажилладаг.

Үйл ажиллагааны эрсдэл нь банкний санхүүгийн алдагдалд оруулаад зогсохгүй зохицуулагч байгууллагын хориг арга хэмжээнд өртөх, банкны нэр хүндэд нөлөөлөх сөрөг үр дагавартай тул банк нь үйл ажиллагааны эрсдэлийг сайн засаглал, хүчтэй эрсдэлийн соёл бүхий банкны удирдлага, үйл ажиллагааны шат бүрт нэвтрүүлэх замаар удирдаж, харилцагч, хадгаламж эзэмшигчид, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг тогтмол өндөрт байлгах чиглэл барин ажилладаг.

2015 онд үйл ажиллагааны эрсдэлээс үүдэлтэй алдагдал нь ТУЗ-өөс баталсан банкны эрсдэлийн хязгаарын түвшинд буюу хүлээн зөвшөөрөх хэм хэмжээнээс харьцангуй бага хэмжээнд байж чадсан.

ЗАСАГЛАЛ

Банк нь үйл ажиллагааны эрсдэлийг оновчтой тодорхойлж, үр дүнтэй хяналтын тогтолцоог нэвтрүүлж, шаардлагатай бодлого, журмууд, үнэлгээний аргачлалуудыг тогтмол хөгжүүлж ирсэн.

Голомт банкны үйл ажиллагааны эрсдэлийн тогтолцоо нь дараах үндсэн зарчмын дагуу ажилладаг. Үүнд:

- Банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, тогтолцоо нь бүрэн тасралтгүй хэрэгжиж байгааг баталгаажуулах зорилго бүхий эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалтыг хараат бусаар бие даан хэрэгжүүлдэг.
- Эрсдэлийн удирдлагын газраас гадна банкны бизнесийн нэгжүүд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын гол үүрэг функцуудыг хэрэгжүүлж, Дотоод аудитын газар нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагад хөндлөнгийн дүгнэлт өгч ТУЗ-д шууд тайлагнадаг.

Голомт банк эрсдэлийг ТУЗ-өөс тогтоосон хязгаарлалтын хүрээнд удирдах эрсдэлийн зохистой удирдлага, үр ашигтай хяналтын тогтолцоо бүхий засаглал болон байгууллагын бүтцийг бий болгох чиглэлээр идэвхи чармайлт гарган ажилласаар ирсэн. Үүнд:

- Банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг банкны эрсдэлийн апетитийн хүрээнд банкны зорилтот ашгийн түвшинд эрсдэлийг хамгийн бага байлгах үр ашигтай түвшинд хүргэж ажилладаг.
- ТУЗ нь компанийн сайн засаглалыг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд жил бүр банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын бодлого, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоонд хяналт тавьдаг.

- ТУЗ нь үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын бодлого болон эрсдэлийн хязгаарлалтуудыг тодорхойлох, батлах болон банкинд учирсан томоохон хэмжээний үйл ажиллагааны эрсдэлийн мэдээлэл болон тайлантай танилцаж, холбогдох шийдвэрийг тухай бүрт гаргадаг.
- ТУЗ нь эрсдэлийн соёлыг эрсдэлийн удирдлагын суурь болгон түүнийг хэмжиж тодорхойлох нь эрсдэлийг илрүүлэх, удирдахад чухал ач холбогдолтой гэж тодорхойлсон. Бид эрсдэлийн соёлыг тодорхойлж түүнд тулгуурласан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг ба банкны эрсдэлийн соёлын судалгааг PwC, McKinsey, IRM (Institute of Risk Management) зэрэг олон улсын судалгааны байгууллагын загваруудад тулгуурлан хийсэн болно.
- Удирдлагын хороог Гүйцэтгэх захирал даргалдаг бөгөөд энэхүү хороо нь банкны хэмжээний үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хяналтыг тогтмол хэрэгжүүлдэг.
- Хараат бус Дотоод аудитын газар нь томоохон хэмжээний эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, нийт эрсдэл хүлээн зөвшөөрөх түвшинд байгаа эсэхийг баталгаажуулахад чухал үүрэгтэй оролцдог. Мөн тус нэгж нь банкны үйл ажиллагааны эрсдэлийн тогтолцоо, түүний үр дүнд хяналт тавьдаг.

ТУЗ үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын бодлогод дараах асуудлуудыг хамруулан баталж байна. Үүнд:

- Үйл ажиллагааны эрсдэлийн тодорхойлолт, эрсдэлийн хязгаарлалт болон засаглалын бүтэц, банкны хэмжээнд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын зорилтууд
- Үйл ажиллагааны эрсдэлийн тогтолцоо буюу банкны одоогийн болон боломжит эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах, удирдах, арга аргачлал
- Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд банк нь мөн аюулгүй байдал болон эрсдэлийг гуравдагч этгээдэд шилжүүлэх даатгалын бодлоготой болно. Голомт банк нь дотоодын даатгалын компаниудтай хамтарч ажиллахын хамт Moody's, Fitch агентлагуудын AA-, A үнэлгээ бүхий Англи улсын Lloyds-ийн гишүүн даатгагч нартай амжилттай хамтарч ажилласаар байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь банкны хэмжээнд эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах, бууруулах, тайлагнах цогц, нэгдмэл аргачлалд суурилагдсан. Голомт банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь дараах үндсэн хэсгүүдээс бүрддэг. Үүнд:

- Эрсдэлийн удирдлагын газар нь эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, хяналт хийх аргачлалыг хөгжүүлэх, гарсан эрсдэлийг тайлагнах, бизнесийн нэгжүүдийн хийх үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ, удирдлагад чухал үүрэгтэй оролцдог.
- Үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх процесс нь эрсдэл өндөртэй үйл ажиллагааны эрсдэлүүдийг илрүүлэх, эрсдэлийн асуулгын хариултуудад үнэлгээ хийхээс эхлэнэ. Эрсдэлийг илрүүлснээр, эрсдэл бүрийн хяналтын тогтолцоонд үнэлгээ өгч тогтмол хяналт хийх, эрсдэлийн үндсэн үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулах эсэх шийдвэрийг гаргадаг.
- Банк эрсдэлийн үнэлгээг ач холбогдол бүхий нэгж, бүтээгдэхүүн болон тэдгээртэй холбоотой үйл ажиллагаанд хийдэг. Ингэснээр банкны удирдлага нь томоохон эрсдэлүүдийг илрүүлж, түүнд үр ашигтай хяналтын тогтолцоог нэвтрүүлж чадсаныг баталгаажуулах суурь хүчин зүйл болдог.

Голомт банк нь олон улсын хэмжээний банкны стандарт шаардлагад нийцсэн комплаенсийн бодлогыг боловсруулж, банкны бүх түвшинд бэхжүүлж бий болгох зорилгоор гүйцэтгэх захирлын шууд удирдлагын хүрээнд Комплаенс хэлтсийг байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлсэн.

- Голомт банк үйл ажиллагааны эрсдэлийн тохиолдлуудыг тусгай програмд Базел II зөвлөмжийн дагуу ангилан бүртгэж, үйл ажиллагааны эрсдэлийн мэдээллийн сан үүсгэдэг.
- Эрсдэлийн удирдлагын газар нь Check-list буюу үйл ажиллагааны хяналтын үзүүлэлт бүхий систем ашиглан салбар нэгжүүдэд зайны хяналтыг хэрэгжүүлдэг бөгөөд мэргэжлийн газар нэгж, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрт эрсдэлийн үнэлгээг хийж байна.
- Банкны үйл ажиллагааны эрсдэлийн мэдээллийн сан нь Эрсдэлийн удирдлагын газрын хяналтад байх бөгөөд энэхүү сангийн мэдээлэлд эрсдэлийн менежерүүд судалгаа шинжилгээ хийн, дүгнэлт гаргаж банкны хэмжээнд гарсан эрсдэл, түүнийг хязгаарлалтын түвшинтэй харьцуулах болон цаашдын хандлагыг тодорхойлон Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-д тайлагнадаг.

БИЗНЕСИЙН ТАСРАЛТГҮЙ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА

Голомт банк нь бизнесийн тасралтгүй ажиллагааг хангах зорилгоор Монголбанк болон зохицуулалтын байгууллагын шаардлага зөвлөмж, стандартуудыг мөрдөж ажилладаг. Бид нөөц төвтэй бөгөөд тогтмол тест хийж, шаардлагатай өөрчлөлтүүдийг бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, осол, саатлын үед системийг хэвийн байдалд эргүүлэн оруулах хугацааг хамгийн боломжит богино түвшинд байлгахыг чухалчилж, үүнтэй холбоотой банкны чадавхийг улам бэхжүүлэхийг түлхүү анхааран ажиллаж байна.

КОМПЛАЕНС БОДЛОГО

Голомт банк нь эрх бүхий байгууллагуудаас гаргасан банкинд хамаарагдах дотоодын болон олон улсын хууль тогтоомж, дүрэм журам болон банкны ил тод байдал, нэр хүндэд нөлөөлөх бизнесийн тогтсон стандартын хэрэгжилтийг хангуулах, банкны хэмжээнд баримтлах ёс зүйн код, засаглалын кодекс тодорхойлогдсон бүхий л хэм хэмжээг дэмжиж, хэрэгжилт хяналтыг сайжруулж, мөрдүүлж ажилладаг.

Голомт банк нь олон улсын хэмжээний банкны стандарт шаардлагад нийцсэн комплаенсийн бодлогыг боловсруулж, банкны бүх түвшинд бэхжүүлж бий болгох зорилгоор гүйцэтгэх захирлын шууд удирдлагын хүрээнд Комплаенс хэлтсийг байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлсэн. Комплаенс хэлтэс нь комплаенсийн (хэрэгжилтийг ханган нийцүүлж төлөвшүүлэх) эрсдэлийг байгууллагын, үйл ажиллагааны болон мэргэжлийн ёс зүйн гэсэн гурван үндсэн чиглэлийн хүрээнд тодорхойлж удирдан чиглүүлж байна.

Банкны зүгээс комплаенсийн хянан нийцүүлэх, бизнесийн үйл ажиллагааг сайжруулах, комплаенс хяналтыг банкны бүх түвшинд мөрдлөг болгох, цаашид комплаенсын үйл ажиллагааг олон улсын түвшинд нийцэхүйц байдлаар явуулахаар зорилт тавин үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.

Комплаенс хэлтэс нь дараах үүрэг хариуцлагыг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Банкнид тулгарч буй комплаенс эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хянах, тайлагнах
- Комплаенс эрсдэлийг удирдах, хянах үүрэг бүхий банкны дээд удирдлагад дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх
- Банкны ажилтан бүрд комплаенс эрсдэлийг удирдах, хэрэгжилтийг ханган биелүүлэх үйл ажиллагаанд заавар, чиглэл, зөвлөгөө өгөх
- Банкны бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад дэмжлэг үзүүлж комплаенсийн магадлан шалгах, судалгааны ажлыг үр дүнтэй явуулах

- Мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагаа болон комплаенсийн бусад асуудлаар сургалт зохион байгуулах, энэ чиглэлээр холбогдох ажилтнуудыг мэргэшүүлж, дадлагажуулах
- Банкны ажилтнуудын ёс зүй, сахилга, хариуцлагын хэм хэмжээг дээшлүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бэхжүүлэх
- Ёс зүйн код, засаглалын кодекс зэрэг комплаенс асуудалтай холбоотой банкны дотоод бодлого, дүрэм, журам, удирдамж зэргийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт өгөх, боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлж санал, зөвлөмж хүргүүлэх

Голомт банк нь Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дотоодын болон олон улсын хууль, дүрэм, стандарт, зөвлөмжүүдийг чандлан сахиж, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын үйл ажиллагааг дэмжин, аливаа мэдээлэл, зохион байгуулалтын үйл ажиллагаанд тогтмол хамрагдаж ажилладаг. Банк нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зэрэг санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх үүргээ улам бүр бэхжүүлж энэ зорилгоор холбогдох зохицуулагч байгууллагуудтай байнга хамтран ажиллаж ирсэн.

Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээний хяналт, эрсдэлд суурилсан үнэлгээ хийх, дотоод сургалтуудыг зохион байгуулах зэрэг банкны МУТСТ үйл ажиллагааг өөрчлөгдөж буй хууль, эрх зүй, бизнесийн орчинд нийцүүлэн тогтмол хөгжүүлж, сайжруулах ажил хийгдсээр байна.

2015 онд удирдлагын зүгээс банкны комплаенсийн үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх зорилгын хүрээнд МУТСТ олон улсын тэргүүн туршлага, стандартыг банкинд бий болгоход анхааран ажиллаж байна. Тодруулбал МУТСТ бүтцийг томруулах, ажилтны мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, МУТСТ бодлогыг шинэчлэх, МУТСТ гүйлгээний системийг автоматжуулах зэрэг чухал ажлуудын эхлэл тавигдсан.

Цаашид олон улсын банкуудын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх зорилгын хүрээнд МУТСТ-ын ажилд улам бүр анхаарал хандуулж энэ чиглэлийн чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг шат дараалан авахаар төлөвлөж байна.

Актив, пассивын хосолсон удирдлага

Бид банкны салбарт актив, пассивын хосолсон удирдлагын менежментийг анх удаагаа амжилттай нэвтрүүлээ. Тус чиглэлээр актив, пассивын бүтцийг гадаад, дотоодын зах зээлийн цаг үеийн мэдээлэлд тулгуурласан судалгаа, дүгнэлтэд үндэслэн оновчтой удирдан ажиллаж байна.

Тухайлбал, хөрвөх чадвар, актив, пассивын эргэн төлөгдөх хугацааны ГАП тайлан болон хүүгийн өөрчлөлттэй холбоотойгоор үүсэх аливаа эрсдэлийн судалгаа, шинжилгээг олон улсын стандартад нийцүүлэн тогтмол хийж гүйцэтгэдэг. Үүнд:

Эргэн төлөгдөх хугацааны ГАП тайлан	Эх үүсвэрийн төвлөрлийн судалгаа	Хүүгийн эрсдэлийн судалгаа	Харьцаа үзүүлэлтийн шинжилгээ, таамаг	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шинжилгээ, таамаг	Богино болон дунд хугацааны мөнгөн урсгалын шинжилгээ, таамаг	Балансын бүтцийн шинжилгээ
-------------------------------------	----------------------------------	----------------------------	---------------------------------------	--	---	----------------------------

Голомт банк нь 2015 онд төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангалттай түвшинд хадгалах чиглэлд онцгой анхааран ажиллаж, олон улсын Базелын хорооны зөвлөмжийг дагаж мөрдөн, Монголбанкнаас арилжааны банкуудад тавьдаг шаардлагуудыг тогтмол ханган ажиллалаа. Манай банкны оны эцсийн байдлаарх төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 37.44 хувьтай байсан болно.



ГОЛОМТ БАНК ГРУПП

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу
бэлтгэгдсэн Санхүүгийн тайлангууд болон
Хараат бус аудиторын тайлан

2015 оны 12 дугаар сарын 31



Голомт Банк Групп

ГОЛОМТ БАНК ХХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

Байгууллагын талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр

Голомт Банк (цаашид “Банк” гэх) нь 1995 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн Бодь Интернэйшнл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр Бодь Интернэйшнл ХХК-ийн 100 хувийн охин компани болон анх үүсгэн байгуулагдсан.

Голомт Секюритиз ХХК (цаашид “Охин Компани” гэх) нь 2011 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 01 тоот шийдвэрийн дагуу Голомт Банкны 100 хувийн эзэмшлийн охин компани болон Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

Гэрчилгээ ба лиценз

Банк нь 2005 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас 2075377 тоот регистрийн дугаар бүхий 9016001014 тоот Улсын Бүртгэлийн гэрчилгээг авсан.

Банк нь 1995 оны 03 дугаар сарын 06-ны өдөр банкны үйл ажиллагаа эрхлэх 25 тоот Тусгай зөвшөөрлийг авсан.

Охин Компани нь 5481589 тоот регистрийн дугаар бүхий 9011287134 тоот Улсын Бүртгэлийн гэрчилгээг Монгол Улсын Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр авсан.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 317 тоот шийдвэрээр Үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа эрхлэх 3/97 тоот тусгай зөвшөөрлийг охин компани нь эзэмшдэг.

Төлөөлөн удирдах зөвлөл

Ч.Мөнхцэцэг	ТУЗ-ийн дарга
З.Тэмүүн	ТУЗ-ийн гишүүн
Урс Э.Шварценбах	ТУЗ-ийн гишүүн
Д.Мөнхтөр	ТУЗ-ийн гишүүн
Ж.Үнэнбат	Хараат бус гишүүн
Лопез Абелло	Хараат бус гишүүн

Гүйцэтгэх Удирдлага

Л.Оюун-Эрдэнэ	Гүйцэтгэх захирал
Ө.Ганзориг	Ерөнхийлөгч
О.Эрдэмбилэг	Хөрөнгө оруулалтын банк болон байгууллагын банк хариуцсан Тэргүүн дэд захирал
Б.Энхтуяа	Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал
Н.Цэрэндаваа	Мэдээллийн технологи хариуцсан дэд захирал
М.Чимэгмөнх	Санхүүгийн удирдлагын газрын захирал, дэд захирал
Т.Нямсүрэн	Зээлийн газрын захирал, дэд захирал
Б.Мөнхбаатар	Нөөцийн удирдлагын газрын захирал, дэд захирал
Д.Сугар	Бизнес хөгжлийн газрын захирал, дэд захирал
Р.Батсүрэн	Дотоод аудитын газрын захирал
Ё.Пүрэвбат	Бүртгэл тооцооны газрын захирал
У.Хосжаргал	Сувгийн удирдлагын газрын захирал
Б.Эрдэнэбаяр	Мэдээллийн технологийн газрын захирал
Ж.Хишигжаргал	Хөрөнгө оруулалтын банкны газрын захирал

Хаяг

Голомт Банк
Голомт Банкны төв байр
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 5, Ш/х-22
Улаанбаатар 15160, Монгол Улс

Аудитор

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК
Сентрал Тауэр, 6 давхар, 601
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай, СБД-8
Улаанбаатар, 14200, Монгол Улс

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Голомт Банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчид танаа:

Бид Голомт Банк ХХК (цаашид “Банк” гэх) болон түүний охин компани болох Голомт Секюритиз ХХК (хамтад нь “Групп” гэх) –ийн 2015 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаар Банкны бие даасан (хамтад нь “санхүүгийн тайлангууд” гэх) болон Группийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, мөн тус өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй болон бусад тайлбар мэдээллээс бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах, мөн залилан, эсвэл алдаанаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангууд бэлтгэхэд шаардагдах дотоод хяналтыг бүрдүүлэх хариуцлагыг Банкны удирдлага хүлээнэ.

Аудиторын хариуцлага

Өөрсдийн хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт өгөх нь бидний хариуцлага юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах, мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажил нь санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг агуулдаг. Сонгосон горимууд нь залилан, эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд материаллаг буруу илэрхийлэгдсэн байх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор бус, зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг төлөвлөх, байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг харгалзан үздэг. Мөн аудитын ажил нь даган мөрдсөн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохицол, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудын үндэслэлтэй байдал, мөн түүнчлэн санхүүгийн тайлангуудыг толилуулсан ерөнхий байдлын талаарх үнэлгээг агуулдаг.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын дүгнэлтээ гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК, Сентрал Тауэр,
601 тоот, 6 давхар, Их Эзэн Чингис Хааны Талбай 2, СБД-8, Улаанбаатар 14200, Монгол Улс
Утас: +976 70009089, Факс: +976 (11)322068 ; www.pwc.com/mn

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр хавсралтад буй нэгтгэсэн болон Банкны бие даасан санхүүгийн тайлангууд нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Группийн болон Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу бодитойгоор илэрхийлсэн байна.

Гарын үсэг:



Даваагийн Баярмаа
Гүйцэтгэх захирал
ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Зөвшөөрч баталсан:



Мэттью Поттл
Партнер

2016 оны 3 дугаар сарын 22-ны өдөр
Монгол улс, Улаанбаатар хот

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК, Сентрал Тауэр,
601 тоот, 6 давхар, Их Эзэн Чингис Хааны Талбай 2, СБД-8, Улаанбаатар 14200, Монгол Улс
Утас: +976 70009089, Факс: +976 (11)322068 ; www.pwc.com/mn

Голомт Банк Групп
Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлан

Мянган төгрөгөөр	Тод-руулга	Групп		Банк	
		2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Хөрөнгө					
Бэлэн мөнгө ба Төв Банкнд байршуулсан мөнгө (зайлшгүй байлгах нөөцөөс бусад)	7	158,189,289	557,135,627	158,124,287	557,038,818
Монголбанкнд байршуулсан зайлшгүй байлгах нөөц	8	260,739,412	278,718,087	260,739,412	278,718,087
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	9	5,442,398	227,942	5,410,038	227,942
Бусад банкуудад байршуулсан хөрөнгө	10	349,234,005	267,924,182	349,234,005	267,924,182
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	11	2,013,610,787	2,461,920,038	2,013,610,787	2,461,920,038
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас	12	68,088,050	61,020,731	68,088,050	61,020,731
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас	13	594,170,820	290,497,306	592,831,917	290,344,064
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	14	1,209,050	1,209,050	1,209,050	1,209,050
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	15	-	-	1,200,000	200,000
Үүсмэл санхүүгийн хэрэгсэл	37	40,207,014	6,086,475	40,207,014	6,086,475
Бусад хөрөнгө	16	22,786,957	14,217,002	22,738,029	14,189,348
Орлогын татварын авлага	31	-	162,627	-	162,627
Биет бус хөрөнгө	17	14,740,580	13,809,757	14,735,999	13,809,317
Үндсэн хөрөнгө	18	176,633,646	91,999,909	176,618,746	91,987,116
Өмчлөх бусад хөрөнгө	19	100,094,904	8,315,491	100,094,904	8,315,491
Нийт хөрөнгө		3,805,146,912	4,053,244,224	3,804,842,238	4,053,153,286
Өр төлбөр					
Бусад банкуудын байршуулсан хөрөнгө	20	90,000,670	133,346,664	90,000,670	133,346,664
Харилцагчдын харилцах, хадгаламж	21	2,079,828,919	2,232,083,285	2,079,800,594	2,232,269,586
Зээлийн бусад эх үүсвэр	22	1,014,934,955	1,011,499,028	1,014,934,955	1,011,499,028
РЕПО хэлцэл	23	174,280,920	251,646,410	174,280,920	251,646,410
Орлогын татварын өглөг	31	2,014,343	2,930	2,014,312	-
Хойшлогдсон татварын өр төлбөр	31	3,077,512	3,092,793	3,072,994	3,092,793
Бусад өр төлбөр	24	12,381,355	27,396,381	12,355,514	27,310,390
Хоёрдогч өглөг	25	70,060,229	66,248,404	70,060,229	66,248,404
Нийт өр төлбөр		3,446,578,903	3,725,315,895	3,446,520,188	3,725,413,275
Эзэмшигчдийн өмч					
Давуу эрхтэй хувьцаа	26	25,778,900	25,778,900	25,778,900	25,773,900
Хувьцаат капитал	26	26,367,593	26,217,093	26,367,593	26,217,093
Нэмэгдэж төлөгдсөн капитал		46,583,557	44,699,421	46,583,557	44,699,421
Хуримтлагдсан ашиг		247,780,795	222,858,983	247,534,836	222,670,665
Өмчийн бусад хэсэг		12,057,164	8,373,932	12,057,164	8,373,932
Нийт эзэмшигчдийн өмч		358,568,009	327,928,329	358,322,050	327,740,011
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		3,805,146,912	4,053,244,224	3,804,842,238	4,053,153,286

2016 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Банкны Удирдлагыг төлөөлж энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурав.

Ч.МӨНХЦЭЦЭГ
ТУЗ-ийн дарга

ГОЛОМТ БАНК

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн 74-151 дүгээр хуудсан дахь тодруулгууд нь уг санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Л.ОЮУН-ЭРДЭНЭ
Гүйцэтгэх захирал

М.ЧИМЭГМӨНХ
Санхүүгийн удирдлагын
газрын захирал, дэд захирал

Нэгтгэсэн Ашиг, Алдагдал болон бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	Групп		Банк	
		2015	2014	2015	2014
Хүүгийн орлого	27	314,978,219	338,373,380	314,829,554	338,365,925
Хүүгийн зардал	27	(213,293,561)	(209,311,862)	(213,295,342)	(209,311,862)
Хүүгийн цэвэр орлого		101,684,658	129,061,518	101,534,212	129,054,063
Зээлийн үнэ цэнийн бууралтын сангийн (зардал)/буцаалт	11	(49,703,415)	(25,777,881)	(49,703,415)	(25,777,881)
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардлын дараах хүүгийн цэвэр орлого		51,981,243	103,283,637	51,830,797	103,276,182
Хураамж, шимтгэлийн орлого	28	21,438,789	20,476,440	21,044,025	20,241,175
Хураамж, шимтгэлийн зардал	28	(6,949,406)	(6,815,563)	(6,886,011)	(6,748,505)
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтаас үүссэн олз		-	3,514,764	-	3,514,764
Нуугдмал үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн олз	25	-	962,305	-	962,305
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг оруулан бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз	9, 37	30,796,564	3,320,552	30,796,564	3,320,552
Гадаад валютын арилжаанаас үүссэн ашиг		14,145,897	16,807,266	14,143,685	16,807,266
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн алдагдал		(5,227,275)	(2,196,297)	(5,235,619)	(2,197,815)
Бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал	16	(1,245,821)	(1,681,412)	(1,245,821)	(1,681,412)
Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал	19	(950,575)	(440,287)	(950,575)	(440,287)
Ногдол ашгийн орлого		213,933	787	213,933	787
Үйл ажиллагааны бусад орлого	29	4,378,078	300,323	4,377,442	296,020
Удирдлага болон үйл ажиллагааны бусад зардал	30	(75,792,857)	(73,149,736)	(75,362,030)	(73,068,330)
Татварын өмнөх ашиг		32,788,570	64,382,779	32,726,390	64,282,702
Орлогын албан татварын зардал	31	(6,746,118)	(14,464,553)	(6,741,579)	(14,454,882)
Тайлант жилийн ашиг		26,042,452	49,918,226	25,984,811	49,827,820
Бусад дэлгэрэнгүй (зардал)/орлого:					
<i>Ирээдүйд ашиг алдагдалд ангилагдаж болзошгүй зүйлс:</i>					
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт:					
- Тухайн жилийн цэвэр олз/ (гарз)		6,539,214	(813,651)	6,539,214	(813,651)
- Борлуулалт болон үнэ цэнийн бууралтаас орлогын тайланд шилжүүлсэн дүн		-	(3,116,008)	-	(3,116,008)
<i>Шууд дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэсэн татварын зардал</i>		(1,311,457)	-	(1,311,457)	-
Тайлант жилийн нийт бусад дэлгэрэнгүй (зардал)/орлого	32	5,227,757	(3,929,659)	5,227,757	(3,929,659)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		31,270,209	45,988,567	31,212,568	45,898,161

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн 74-151 дүгээр хуудсан дахь тодруулгууд нь уг санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Голомт Банк Групп

Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	Группийн эздэд хамаарах							
		Давуу эрхтэй хувьцаа	Хувьцаат капитал	Нэмэгдэж төлөгдсөн капитал	Хувьцаанд суурилсан төлбөрийн нөөц	ББХО ҮЦ-ны дахин үнэлгээний нөөц	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	Эзэмшигчдийн өмчийн нийт дүн
2013 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		16,388,100	25,907,593	42,322,298	2,343,137	3,282,966	8,212,178	173,488,603	271,944,875
Тухайн жилийн ашиг		-	-	-	-	-	-	49,918,226	49,918,226
Бусад дэлгэрэнгүй орлого	32	-	-	-	-	(3,929,659)	-	-	(3,929,659)
2014 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	-	-	-	(3,929,659)	-	49,918,226	45,988,567
Нэмж гаргасан давуу эрхтэй хувьцаа	26	9,390,800	-	-	-	-	-	-	9,390,800
АХЭХ-н дагуу нэмж гаргасан хувьцаа	26	-	309,500	2,377,123	(1,500,000)	-	-	-	1,186,623
Хувьцаанд суурилсан төлбөр		-	-	-	333,349	-	-	-	333,349
Зарласан болон төлсөн ногдол ашиг	33	-	-	-	-	-	-	(915,885)	(915,885)
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		-	-	-	-	-	(368,039)	368,039	-
2014 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		25,778,900	26,217,093	44,699,421	1,176,486	(646,693)	7,844,139	222,858,983	327,928,329
Тухайн жилийн ашиг		-	-	-	-	-	-	26,042,452	26,042,452
Бусад дэлгэрэнгүй орлого	32	-	-	-	-	5,227,757	-	-	5,227,757
2015 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	-	-	-	5,227,757	-	26,042,452	31,270,209
АХЭХ-н дагуу нэмж гаргасан хувьцаа	26	-	150,500	707,650	-	-	-	-	858,150
Хувьцаанд суурилсан төлбөрийн буцаалт		-	-	1,176,486	(1,176,486)	-	-	-	-
Зарласан болон төлсөн ногдол ашиг	33	-	-	-	-	-	-	(1,488,679)	(1,488,679)
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		-	-	-	-	-	(368,039)	368,039	-
2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		25,778,900	26,367,593	46,583,557	-	4,581,064	7,476,100	247,780,795	358,568,009

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн 74-151 дүгээр хуудсан дахь тодруулгууд нь уг санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Нэгтгэсэн Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

		Банкны эздэд хамаарах							
Мянган төгрөгөөр	Тодруулга	Давуу эрхтэй хувьцаа	Хувьцаат капитал	Нэмэгдэж төлөгдсөн капитал	Хувьцаанд суурилсан төлбөрийн нөөц	ББХО ҮЦ-ны дахин үнэлгээний нөөц	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	Эзэмшигчдийн өмчийн нийт дүн
2013 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		16,388,100	25,907,593	42,322,298	2,343,137	3,282,966	8,212,178	173,390,689	271,846,961
Тухайн жилийн ашиг		-	-	-	-	-	-	49,827,820	49,827,820
Бусад дэлгэрэнгүй орлого		32	-	-	-	(3,929,659)	-	-	(3,929,659)
2014 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	-	-	-	(3,929,659)	-	49,827,820	45,898,161
Нэмж гаргасан давуу эрхтэй хувьцаа		26	9,390,800	-	-	-	-	-	9,390,800
АХЭХ-н дагуу нэмж гаргасан хувьцаа		26	-	309,500	2,377,123	(1,500,000)	-	-	1,186,623
Хувьцаанд суурилсан төлбөр			-	-	-	333,349	-	-	333,349
Зарласан болон төлсөн ногдол ашиг		33	-	-	-	-	-	(915,885)	(915,885)
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл			-	-	-	-	(368,039)	368,039	-
2014 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		25,778,900	26,217,093	44,699,421	1,176,486.0	(646,693)	7,844,139	222,670,665	327,740,011
Тухайн жилийн ашиг		-	-	-	-	-	-	25,984,811	25,984,811
Бусад дэлгэрэнгүй орлого		32	-	-	-	5,227,757	-	-	5,227,757
2015 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	-	-	-	5,227,757	-	25,984,811	31,212,568
АХЭХ-н дагуу нэмж гаргасан хувьцаа		26	-	150,500	707,650	-	-	-	858,150
Хувьцаанд суурилсан төлбөрийн буцаалт			-	-	1,176,486	(1,176,486)	-	-	-
Зарласан болон төлсөн ногдол ашиг		33	-	-	-	-	-	(1,488,679)	(1,488,679)
Хуримтлагдсан ашиг руу шилжүүлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл			-	-	-	-	(368,039)	368,039	-
2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл		25,778,900	26,367,593	46,583,557	-	4,581,064	7,476,100	247,534,836	358,322,050

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн 74-151 дүгээр хуудсан дахь тодруулгууд нь уг санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Голомт Банк Групп

Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	Групп 2015	2014	Банк 2015	2014
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Татварын өмнөх ашиг		32,788,570	64,382,779	32,726,390	64,282,702
Тохируулгууд:					
Харилцагчдад олгосон зээл, урьдчилгааны үнэ цэнийн бууралт	11	49,703,415	25,777,881	49,703,415	25,777,881
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтаас үүссэн олз		-	(3,514,764)	-	(3,514,764)
Нуугдмал үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн олз		-	(962,305)	-	(962,305)
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз	9, 37	(30,796,564)	(3,320,553)	(30,796,564)	(3,320,552)
Үндсэн хөрөнгө борлуулсны ашиг		(636)	(24,860)	-	(24,860)
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн цэвэр алдагдал		5,227,275	2,196,164	5,235,619	2,197,815
Бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралт	16	1,245,821	1,681,412	1,245,821	1,681,412
Элэгдлийн зардал	18	9,252,991	7,287,927	9,248,578	7,279,031
Хорогдуулалтын зардал	17	4,503,962	1,975,004	4,499,708	1,974,395
Данснаас хассан үндсэн хөрөнгө	18	315,510	17,537	315,510	17,537
Өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралт	19	950,575	440,287	950,575	440,287
Мөнгөн бусаар хүлээн авсан ногдол ашиг		213,933	-	213,933	-
Хувьцаанд суурилсан төлбөрийн зардал		-	333,349	-	333,349
Хүүгийн орлого	27	(314,978,219)	(338,373,380)	(314,829,554)	(338,365,925)
Хүүгийн зардал	27	213,293,561	209,311,862	213,295,342	209,311,862
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ		(28,279,806)	(32,791,660)	(28,191,227)	(32,892,135)
Монголбанкинд байршуулсан, зайлшгүй байлгах нөөцийн цэвэр (өсөлт)/бууралт					
		17,978,675	(18,908,544)	17,978,675	(18,908,544)
Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн цэвэр өсөлт		(199,047,369)	(567,921)	(199,047,369)	(567,921)
Харилцагчдад олгосон зээл, урьдчилгааны цэвэр өсөлт		(155,404,681)	(230,225,070)	(155,404,681)	(230,223,419)
Бусад хөрөнгийн цэвэр өсөлт		(10,844,015)	(930,258)	(9,794,501)	(913,189)
Бусад банкуудын байршуулсан хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)		(42,629,867)	107,239,362	(42,629,867)	107,239,362
Харилцагчдын харилцах, хадгаламжийн цэвэр өсөлт/(бууралт)		(162,408,755)	40,474,732	(162,408,755)	40,316,695
Бусад санхүүгийн өр төлбөрийн цэвэр өсөлт/(бууралт)		(14,994,007)	7,698,081	(14,954,876)	7,688,923
Татвар болон хүүгийн өмнөх үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгө		(595,629,825)	(128,011,278)	(594,452,601)	(128,260,228)
Төлсөн орлогын албан татвар					
		(4,552,279)	(13,725,467)	(4,544,841)	(13,715,796)
Хүлээн авсан хүү		281,427,485	304,502,728	281,258,500	304,495,273
Төлсөн хүү		(204,155,776)	(210,928,757)	(204,153,925)	(210,928,757)
Үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгө		(522,910,395)	(48,162,774)	(521,892,867)	(48,409,508)

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн 74-151 дүгээр хуудсан дахь тодруулгууд нь уг санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Нэгтгэсэн Мөнгөн Гүйлгээний Тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	Групп 2015	2014	Банк 2015	2014
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ					
Санхүүгийн хөрөнгө оруулалтын худалдан авалт		(96,781,862)	(141,049,957)	(97,781,862)	(140,899,816)
Санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны орлого		41,638,772	203,613,767	41,638,772	203,613,767
Үндсэн хөрөнгийн худалдан авалт		(94,013,459)	(47,139,930)	(93,996,055)	(47,139,732)
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	18	445,997	529,662	434,477	529,464
Биет бус хөрөнгийн худалдан авалт	17	(5,434,784)	(11,146,410)	(5,426,390)	(11,146,410)
Хөрөнгө оруулалтад (зарцуулсан)/ орсон цэвэр мөнгө		(154,145,336)	4,807,132	(155,131,058)	4,957,273
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Нэмж гаргасан хувьцаанаас орж ирсэн орлого		858,150	10,577,423	858,150	10,577,423
РЕПО хэлцлээс орж ирсэн орлого		1,067,333,211	3,455,153,703	1,067,333,211	3,455,153,703
РЕПО хэлцлийн эргэн төлөлт		(1,144,599,240)	(3,370,788,571)	(1,144,599,240)	(3,370,788,570)
Зээлийн бусад эх үүсвэрээс орж ирсэн орлого		664,996,429	485,447,395	664,996,430	485,447,395
Зээлийн бусад эх үүсвэрийн эргэн төлөлт		(224,354,043)	(512,068,364)	(224,354,043)	(512,068,364)
Төлсөн Ногдол ашиг	33	(1,488,678)	(915,885)	(1,488,678)	(915,885)
Санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ		362,745,829	67,405,701	362,745,830	67,405,702
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлт		2,821,108	-	2,821,108	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт		(311,488,794)	24,050,059	(311,456,987)	23,953,467
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,043,738,406	1,019,688,347	1,043,641,597	1,019,688,130
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7	732,249,612	1,043,738,406	732,184,610	1,043,641,597

Бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө шаардагдаагүй МИК-ТЗК-ийн хэлцлүүд нь Мөнгөн гүйлгээний тайланд ороогүй бөгөөд дэлгэрэнгүйг Тодруулга 3 болон 13-аас үзнэ үү.

Голомт Банк Групп

Санхүүгийн тайлангуудын тодруулгууд – 2015 оны 12 дугаар сарын 31

1 Танилцуулга

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Голомт Банк ХХК (“Банк”) болон Голомт Секюритиз ХХК (“Охин Компани”, хамтад нь “Групп” гэх)-ийн Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу бэлтгэгдсэн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангуудаас бүрдэнэ.

2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкныг шууд хянадаг, эцсийн шатны толгой компани нь Голомт Файнэншил Групп ХХК (2014 оны 12 дугаар сарын 31: Голомт Файнэншил Групп ХХК) байна. Банк нь Монгол Улсад бүртгэгдсэн, мөн тус улсад албан ёсны хаягтай юм. Банк нь хязгаарлагдмал хариуцлагатай компани бөгөөд анх Бодь Интернэйшнл ХХК (Банкны өмнөх толгой компани)-ийн 100 хувийн охин компанийн хэлбэрээр Бодь Интернэйшнл ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр Монгол Улсын хууль, эрх зүйн дагуу үүсгэн байгуулагдсан. 2014 онд өмнөх шууд хянадаг, эцсийн шатны толгой компани болох Бодь Интернэйшнл ХХК нь оруулсан өөрийн хөрөнгө оруулалтаа дахин бүтэцчилж, Банкны дахь эзэмшлийн бүх хувьцааг Монгол Улсад шинээр бүртгэгдсэн Голомт Файнэншил Групп ХХК-д шилжүүлсэн.

2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Голомт Файнэншил Групп ХХК-ийн эзэмшигч Д.Баясгалан нь 2015 оны 12 дугаар сарын 31 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Голомт Банкны шууд хянадаг, эцсийн шатны эзэмшигч юм.

2015 оны 12 дугаар сарын 31 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкны хувь эзэмшигчдийн талаарх мэдээллийг Тодруулга 26-аас үзнэ үү.

Банк нь 2005 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас олгосон 2075377 тоот регистрийн дугаартай, 9016001014 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээтэй. Банк нь 1995 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Монголбанкнаас (“МБ”) олгосон банкны үйл ажиллагаа эрхлэх 25 тоот тусгай зөвшөөрлийг авсан.

Банкны хүчин төгөлдөр дүрмийн дагуу Банкны үндсэн үйл ажиллагаа нь:

- Хадгаламж
- Зээлийн үйлчилгээ
- Картын үйлчилгээ
- Баталгаа ба аккредитив
- Мөнгөн шилжүүлэг
- Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах болон арилжаалах
- Үнэт метал худалдах, худалдан авах, хадгалах болон арилжаалах
- Гадаад төлбөр, тооцоо
- Үнэт цаас гаргах, арилжаалах
- Санхүүгийн түрээсийн үйлчилгээ
- Зээл болон бусад санхүүгийн хэрэглүүр худалдан авах, худалдах
- Кастодиан банкны үйлчилгээ
- Хууль эрх зүйн хүрээнд хязгаарлаагүй бусад санхүүгийн үйлчилгээ болон Монголбанк ба Засгийн Газрын байгууллагуудын хүлээн зөвшөөрсөн бусад үйлчилгээг үзүүлнэ.

Банк нь 2011 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 163 тоот тогтоолын дагуу андеррайтерийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос (“СЗХ”) авсан.

Банк нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсад 71 салбар, тооцооны төвтэй (2014 оны 12 дугаар сарын 31: 70 салбар, тооцооны төвтэй), мөн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 26 касс (2014 оны 12 дугаар сарын 31: 28 касс)-тайгаар үйл ажиллагаагаа явуулсан.

2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны ажилтны тоо 1,872 (2014 оны 12 дугаар сарын 31: 1,862) байсан.

Банкны бүртгэгдсэн албан ёсны хаяг, компанийн байршил нь: Монгол Улс, Улаанбаатар хот-15160, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 5, шуудангийн хайрцаг-22 байна.

Голомт Банк ХХК-ийн 100 хувийн эзэмшлийн охин компани болох Голомт Секюритиз ХХК (“Охин Компани”) нь Монгол Улсын хууль, эрх зүйн дагуу болон 2011 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн Банкны 1 тоот шийдвэрийн дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

Охин Компани нь 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлж, 5481589 тоот регистрийн дугаар, 9011287134 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээ авсан. Охин компани нь Үнэт Цаасны Зах зээл дээр үйл ажиллагаа эрхлэх 3/97 тоот Тусгай Зөвшөөрлийг 2011 оны 11 дугаар сарын 02-ны өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны 317 тоот тогтоолын дагуу авсан.

Охин компанийн үндсэн үйл ажиллагаа нь:

- Брокерийн үйл ажиллагаа;
- Санхүүгийн болон хөрөнгө оруулалтын үйлчилгээ;
- Андеррайтингийн үйлчилгээ;

2 Группийн үйл ажиллагааны орчин

2.1 Ерөнхий

Монгол Улсын эдийн засаг нь харьцангуй өндөр инфляцийн болон хүүгийн түвшинтэй, бусад гадаадын улс орнуудад чөлөөтэй хөрвөх чадваргүй үндэсний мөнгөн тэмдэгтэй зэрэг хөгжиж буй зах зээлийн шинж чанарыг агуулж байна. Олон улсын хөрөнгө оруулагчдын хувьд Монгол Улс нь хөгжих боломжтой орон гэж харагдаж байна. 2010, 2011 онуудад тогтмол өсөлттэй байсан эдийн засаг дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн уналт болон БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн удаашрал, 2012 онд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөс үүдэн гадны хөрөнгө оруулалт буурсан зэрэгтэй уялдан 2012 болон 2013 онд эдийн засгийн хөгжил саарах хандлага илэрч эхэлсэн. Энэ нь 2014 онд үргэлжилж үүний үр дүнд 2014 оны 7 дугаар сард Мүүди'с зэрэглэл тогтоох агентлаг Монгол Улсын зэрэглэлийг В1-ээс В2 болгон бууруулж, улмаар томоохон хэмжээний арилжааны банкуудын зэрэглэлийг мөн В1-ээс В2 болон В3 болгон бууруулсан. 2014 оны сүүлийн улирал болон 2015 оны эхний улирлуудад дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн огцом уналт болон БНХАУ-ын эдийн засгийн үргэлжилсэн удаашрал нь Монгол Улсын эдийн засагт муугаар нөлөөлсөөр байна. 2015 оны 11 дүгээр сарын 3-нд Стандарт ба Пүүрс үнэлгээний агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сөрөг төлөвтэй "В+/В" байсныг тогтвортой төлөвтэй "В/В" болгож бууруулсан.

2013 оны 10 дугаар сарын 03-нд Улсын Их Хурал Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Хөрөнгө оруулалтын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг баталсан ба эдгээр хууль нь 2013 оны 11 дүгээр сарын 01-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэ хууль батлагдсанаар Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль болон Стратегийн ач холбогдолтой салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль тус тус хүчингүй болсон. Хөрөнгө оруулалтын хуулийн зорилго нь Монгол дахь хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн баталгааг гаргах, хөрөнгө оруулалтыг дэмжих, татварын орчныг тогтворжуулах, төрийн байгууллагын эрх хэмжээ болон хөрөнгө оруулагчдын эрх, үүргийг тодорхойлох болон хөрөнгө оруулалттай холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.

Монгол Улсын засгийн газрын зүгээс Өрийн удирдлагын Тухай Хууль, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль зэрэг хуулиудыг батлуулж, мөн өртгийг бууруулан, ажиллах хүчний бүтээмжийг нэмэгдүүлж үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг сайжруулах зэрэг олон шинэчлэлийг хийхээр ажиллаж байна. Түүнчлэн Монгол Улсын засгийн газар нь гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, бизнесийн орчинг сайжруулахаар ажиллаж байна.

Хэдийгээр засгийн газрын зүгээс дээрх шинэчлэлүүдийг хийхээр ажиллаж байгаа боловч УИХ-ын дараагийн сонгууль болох гэж байгаатай холбоотойгоор учирч болох эрсдэл их байна.

2015 оны 12 дугаар сард арилжааны банкууд болон олон улсын засгийн газруудын төлөөлөл нар Рио Тинто ХК-ний Оюутолгой төслийн өргөтгөлийн санхүүжилт дээр тохиролцоонд хүрснээр томоохон хөрөнгө оруулалт орж ирсэн. Уул уурхайн томоохон төсөл хэрэгжсэнээр валютын их хэмжээний мөнгөн урсгал Монгол Улс руу орж ирэх, улмаар хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, экспортын орлогыг нэмэгдүүлэн дунд хугацааны эдийн засгийн өсөлтийн суурь болох боломжтой. Монгол Улсын хувьд байгалийн баялагаа оновчтой байдлаар ашиглан эдийн засгаа бодитоор өргөжүүлэх нь томоохон шалгуур болоод байгаа. Оновчтой байдлаар байгалийн баялагаа ашиглах нь зөвхөн иргэдийн ахуй амьдралыг сайжруулахаас гадна Монгол Улсын эдийн засаг болон хөрөнгө оруулагчдын бизнесийн орчинг сайжруулах ашиг тустай.

Засгийн газрын зүгээс эдийн засгийг тогтворжуулахын тулд баримтлах бодлого нь тодорхойгүй байгаа боловч Монгол Улсын цаашдын эдийн засгийн өсөлт нь мөнгөний болон төсвийн бодлогын үр ашигтай байдлаас ихээхэн хамаарна. 2016 онд Монгол Улсын мөнгөний бодлого болон төсвийн бодлогын үндсэн зорилт нь макро эдийн засгийн тэнцвэрийг хангаж, зохистой төсвийн бодлогоор дамжуулан улсын төсвийг алдагдалгүй байлгах, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх замаар төлбөрийн тэнцлийг хадгалах, мөн зохистой өрийн удирдлагыг нэвэрүүлэх замаар эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн засгийг дунд болон урт хугацаанд тэнцвэртэй бөгөөд тогтвортой өсөх орчинг бүрдүүлэхэд чиглэнэ.

Хууль зүйн, татвар болон зохицуулагч журмын хувьд үе үе өөрчлөлтүүд хийгдэж, үргэлжлүүлэн сайжруулалт хийгдсээр байна. Монгол Улсын татварын болон бусад хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэйгээр тайлбарлагдах, ойр ойрхон өөрчлөгдөх хандлагатай байдаг (Тодруулга 36-г харна уу). Монголын эдийн засгийн ирээдүйн хөгжил нь дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнийн цаашдын өсөлт болон БНХАУ-ын эрэлт хэрэгцээ, мөн Засгийн газраас эдийн засаг, санхүү, мөнгөний бодлогын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн үр өгөөж болоод татвар, эрх зүй, улс төрийн өөрчлөлт, хөгжилтэй хамааралтай юм.

Голомт Банк Групп

2 Группийн үйл ажиллагааны орчин (үргэлжлэл)

2.1 Ерөнхий (үргэлжлэл)

Дэлхийн болон бусад улс орнуудын санхүүгийн зах зээлийн тодорхойгүй бөгөөд тогтворгүй байдал, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн уналт, БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн удаашрал болон бусад томоохон эрсдэл бүхий хүчин зүйлс нь Монгол Улсын санхүүгийн болон бизнесийн секторт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм. Харилцагчдад олгосон зээл болон бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын санг нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартуудын шаардлагын дагуу “учирсан алдагдлын” загварыг ашиглан тодорхойлдог. Уг стандартууд нь өмнөх үед болсон үйл явдлаас үүссэн авлагын үнэ цэнийн бууралтын санг хүлээн зөвшөөрөхийг шаардаж, ирээдүйн үйл явдлаас үүсч болзошгүй үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөхийг хориглодог. Ирээдүйд болох үйл явдал гэдэгт эдийн засгийн нөхцөл байдалд гарах өөрчлөлт хамаарна. Ирээдүйн үйл явдлаас үүсч болзошгүй үнэ цэнийн бууралт хэдий өндөр магадлалтай байлаа ч ирээдүйн үйл явдлаас үүссэн үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрдөггүй. Тиймээс, санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз нь байгуулсан нөөцийн түвшингээс нилээд өөр байж болох юм.

Удирдлага нь Монголын эдийн засагт нөлөө үзүүлж болох ирээдүйн бүх үйл явдлыг урьдчилан харах боломжгүй бөгөөд улмаар тэдгээр нь Банкны ирээдүйн санхүүгийн байдалд хэрхэн нөлөөлж болохыг таамаглах бололцоогүй билээ. Хэдий тийм боловч удирдлага нь Банкны бизнесийн тогтвортой хөгжлийг дэмжихэд шаардагдах бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа гэдэгт итгэлтэй байна.

2.2 Валютын арилжаа

Гол гадаад валют болох Ам.доллар болон Евро зэрэг нь Монгол Улсын ихэнх бизнесийн төлбөр тооцоонд ашиглагдаж, суурь эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг. Доорх хүснэгт нь Монгол Улсын Төв Банкнаас зарласан Ам.доллар болон Еврогийн Төгрөгтэй харьцах ханшийг харуулав.

Огноо	Ам.доллар	Евро
2015 оны 12 сарын 31	1,995.98	2,182.70
2014 оны 12 сарын 31	1,885.60	2,293.36
2013 оны 12 сарын 31	1,654.10	2,275.63
2012 оны 12 сарын 31	1,392.10	1,835.83
2011 оны 12 сарын 31	1,396.37	1,806.76
2010 оны 12 сарын 31	1,256.47	1,662.31

3 Тайлан бэлтгэх үндэслэл

3.1 Ерөнхий зарчмууд

Эдгээр Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд болон Банкны тусдаа санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (“СТОУС”)–ын дагуу, санхүүгийн хэрэглүүрүүдийг анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх, мөн борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийг дахин үнэлэн бүртгэхээс бусад тохиолдолд түүхэн өртгөөр бүртгэх тогтсон зарчмыг баримтлан бэлтгэгдсэн.

Групп болон Банк нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу нягтлан бодох бүртгэлээ хөтөлдөг. Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь СТОУС-тай бүх материаллаг зүйлсийн хувьд нийцсэн нягтлан бодох бүртгэлийн суурийн дагуу бэлтгэгдсэн. Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг тодруулга 4-т толилуулав.

Монголбанкны тайлан бэлтгэх журмын дагуу эдгээр нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудийн тодруулгууд нь Групп болон Банкны хөрөнгө, өр төлбөр, эзэмшигчдийн өмч, орлого болон зардлын дүн болон бусад тодруулгуудыг багтаасан болно. Групп болон Банкны дүнгүүд өөр тохиолдолд, Группийн санхүүгийн байдал болон ажил гүйлгээ нь холбогдох тодруулгуудад тусгагдсан болно.

3.2 Гүйлгээний болон тайлагналын валют

Группийн үйл ажиллагааны валют нь түүний үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үндсэн орчны валют байна. Банкны болон түүний охин компанийн үйл ажиллагааны болон тайлагналын валют нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөг юм. Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Группийн гүйлгээний болон тайлагналын валют болох Монгол Улсын Үндэсний Төгрөг (“төгрөг”)–өөр илэрхийлэгдсэн ба өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд бүх үзүүлэлтүүдийг мянгачлан илэрхийлсэн.

3.3 НББ-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглагдсан шийдвэрлэх тооцоолол ба үнэлэлтүүд

Санхүүгийн тайланг бэлтгэх нь санхүүгийн тайлан бэлтгэсэн өдрөөр тайлагнасан болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн дүн, тайлагналын өдрөөрх болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн нэмэлт тодруулга, тайлант хугацааны орлого болон зардлын тайлагнасан дүнд нөлөөлөх

тооцоолол болон таамаглалыг шаарддаг. Удирдлагын туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх тухайн нөхцөл байдалд зохистой гэж үзсэн хүлээлт зэрэг бусад хүчин зүйлүүдэд үндэслэдэг чухал тооцоолол дүгнэлтүүд нь байнга дахин хянагдаж байдаг. Удирдлага нь мөн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо хэрэгжүүлэхдээ тооцоололос гадна тодорхой дүгнэлт хийдэг. Нэгтгэсэн Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд хамгийн мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэлтүүд болон дараагийн санхүүгийн жилийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнгүүдэд мэдэгдэхүйц тохируулга хийх шаардлага үүсгэж болох тооцоолуудад дараах зүйлс хамаарна. Үүнд:

(i) Зээл болон урьдчилгааны үнэ цэнэ бууралтын гарз

Групп зээлийн багцын үнэ цэнэ бууралтыг тогтмол эргэн шалгадаг. Үнэ цэнэ бууралтын гарзыг тайлант жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлохдоо Групп зээлийн багц доторх дан ганц зээлийн хувьд үнэ цэнийн бууралт үүссэн эсэхийг тодорхойлохын өмнө, тухайн багцын ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгал хэмжихүйц хэмжээгээр буурсны шинж тэмдэг илэрснийг харуулсан нээлттэй мэдээлэл байгаа эсэх талаар шийдвэр гаргадаг. Энэ нотолгоонд бүлэг доторх зээлдэгчдийн төлбөр төлөх байдалд, мөн тухайн бүлэг доторх хөрөнгийн нөхөн төлөгдөх байдалтай уялдаа холбоотой дотоодын болон орон нутгийн эдийн засгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлөх өөрчлөлтүүдийн талаарх нээлттэй олдох мэдээлэл орсон байж болно.

Удирдлага нь ирээдүйн мөнгөн урсгалыг товлэхдоо ижил төрлийн зээлийн эрсдлийн шинж чанартай хөрөнгийн зүйлүүдийн хувьд хохирол учирсан түүхэн мэдээлэл, мөн багц доторхи хөрөнгийн үнэ цэнийн бууралтын талаарх бодит нотолгоон дээр үндэслэн тооцоолол хийдэг. Тооцоолсон байсан гарзыг бодитоор үүссэн гарзын хэмжээтэй ойртуулах үүднээс ирээдүйн мөнгөн урсгалын хэмжээ болон цаг хугацааг тооцоолоход ашигласан аргачлал болон үндэслэлүүдийг тогтмол эргэн хянадаг.

Бодитоор үүсэх гарзын хэмжээг тооцоолсон гарзын хэмжээнээс 20 хувиар ихэсгэх буюу бууруулахад зээлийн үнэ цэнийн бууралтын гарз 19,018,891 мянган төгрөгөөр (2014: 15,396,332 мянган төгрөгөөр) ихсэх буюу буурна. Өндөр дүнтэй тусгай зээлүүдийн үнэ цэнийн бууралтын гарзыг тухайн зээл бүрийн аливаа эргэн төлөлт болон зээлийн барьцаа хөрөнгийг борлуулснаас орж ирэх мөнгөн урсгал зэргийг харгалзан үзэж ирээдүйн мөнгөн урсгалыг хямдруулсан дүнд үндэслэн тооцоолдог.

(ii) Барилга байгууламж болон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ

Групп нь барилга байгууламжыг үнэлэхдээ дахин үнэлгээний арга ашигладаг ба хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлдэг.

Групп 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар шинээр худалдаж авсан төв оффисын барилгын бодит үнэ цэнийг тодорхойлохын тулд тусгай үнэлгээний мэргэжилтэнг хөлсөлж ажиллуулсан ба бусад барилга байгууламжуудыг хөндлөнгийн тусгай үнэлгээний мэргэжилтнээр 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үнэлүүлсэн. Барилга байгууламж, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг үнэлсэн тус мэргэжилтний ашигласан суурь нь харьцуулагдах зах зээлийн мэдээлэлд үндэслэсэн хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэ юм. 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Группийн нийт барилга байгууламж болон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолохдоо идэвхтэй зах зээл дээрх зах зээлийн үнийг ашигласан бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг тодруулга 14 болон 18-с үзнэ үү.

2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Монгол улсын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал болон Группийн барилга байгууламж болон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнэд нөлөөлж болохуйц нээлттэй мэдээлэл дээр үндэслэн (тодруулга 2) удирдлагын зүгээс 2015 оны 12 дугаар сарын 31 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний хооронд Группийн үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнэд ямар нэгэн мэдэгдэхүйц том өөрчлөлт байхгүй гэж үзсэн. Мөн түүнчлэн 2015 онд хийсэн үл хөдлөх хөрөнгийн томоохон худалдан авалтууд нь шударга зах зээлийн шинжтэй буюу тухайн үеийн зах зээлийн үнээр хийгдсэн.

Хэрэв барилга байгууламжийн дундаж үнэлгээг одоогийн дансны үнээс 10 хувиар ихэсгэвэл 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт барилга байгууламж болон түүний дахин үнэлгээний нөөцийн дансны үнэ ойролцоо дүнгээр 14,541,873 мянган төгрөгөөр өснө (2014 оны 12 дугаар сарын 31: 5,992,900 мянган төгрөгөөр). Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнийн өөрчилөлтийн нөлөө нь материаллаг бус байх магадлалтай байна.

(iii) Засгийн Газар, Монголбанк, төрийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас зээлээр авсан эх үүсвэр

Банк нь Монгол Улсын Засгийн Газар (Монгол Улсын Хөгжлийн Банк, Монголбанк г.м), төрийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас урт хугацаат санхүүжилтийг хэвийн үед зээлүүлдэг зээлийн хүүтэй ижил хүүгээр авдаг бөгөөд тус зээлийн хүү нь Банкны бусад зээлдүүлэгчдээс авдаг зээлийн хүүгээс доогуур байж болзошгүй. Ийм санхүүжилтийн үр дүнд Банк эдгээр эх үүсвэрүүдийг зээлдүүлэгчийн тодорхойлсон зорилтот харилцагч нарт ашигтай нөхцөлтэйгөөр зээлүүлэх боломжтой юм. Удирдлага эдгээр хэрэглүүрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед олз, гарз үүссэн эсэхийг авч үзсэн. Уг ажил гүйлгээнүүд нь холбоогүй этгээдүүдтэй хийгддэг тул удирдлагын үнэлэлтээр эдгээр эх үүсвэрүүд болон холбогдох зээл олголтууд нь зах зээлийн үнээр хийгдсэн бөгөөд эдгээрийг анх хүлээн зөвшөөрөхөд олз, гарз үүсэхгүй гэж үзсэн. Уг үнэлэлтийг хийхдээ удирдлага эдгээр хэрэглүүрүүд нь тусгай зах зээл (тусгай сегмент г.м) болдог гэж үзэж байгаа. Мөн түүнчлэн дээрх удирдлагын үнэлэмжид Засгийн газрын санаачлагаар Монголбанкны Үнэ Тогтворжуулах Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй 4 хувийн хүүтэй эх үүсвэртэй, харилцагчид 8 хувийн хүүтэй олгогдож буй Ипотекийн орон сууцны зээлийн хөтөлбөр хамрагдаж байна.

3.3 НББ-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглагдсан шийдвэрлэх тооцоолол ба үнэлэлтүүд (үргэлжлэл)

(iii) Засгийн Газар, Монголбанк, төрийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас зээлээр авсан эх үүсвэр (үргэлжлэл)

Засгийн Газар, Монголбанк, төрийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас зээлээр авсан эх үүсвэрүүд нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 478,754,724 мянган төгрөг (2014 оны 12 дугаар сарын 31: 965,964,085 мянган төгрөг)-ийн дүнтэй байсан. Энэ талаарх мэдээллийг тодруулга 22-т толилуулсан.

Тодруулга 22-т заасны дагуу барилгын салбарыг санхүүжүүлэх хөтөлбөрийн хүрээнд авсан эх үүсвэрийг Банк нь тодорхой шаардлагыг хангасан (орон сууцны зориулалттай барилга барьж буй, Монголбанкны харьцааны шаардлагыг хангасан) зээлдэгч нарт зээл олгох замаар ашиглах юм. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн хүүг Банк тогтоох эрхтэй бөгөөд холбогдох зээлийн хүү нь барилгын зээлийн зах зээлийн хүүгээс их зөрүүгүй байхаар тогтооно. Өөрөөр хэлбэл Банкны өөр эх үүсвэр ашиглан олгосон бусад зээлийн хүүтэй ойролцоо байна. Тиймээс тусгай нөхцөлүүд хангагдсан тул (зээл олгох тусгай урьтгал нөхцөл, буцаан төлөх болон ашиглаагүй эх үүсвэрт хамгийн өндөр хүү төлөх шаардлага, Засгийн газрын зуучлагчийн үүргийг Монголбанк гүйцэтгэж буй гэх мэт) НББОУС 20-ын дагуу энэхүү зээл нь засгийн газрын хөнгөлөлтийн нөхцөлийг хангаж байна. Төгрөгийн зах зээлийн хүүгийн хамгийн оновчтой харьцуулалт нь Монголбанкны бодлогын 10.5 хувийн хүү гэж Удирдлага үзсэн. 2015 оны 12 дугаар сарын 31 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх засгийн газрын төслийн эх үүсвэрийн үлдэгдэл дүнг тодруулга 22-т толилуулсан.

(iv) Монголын ипотекийн корпораци (МИК)-ийн орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас (ипотекийн зээлийн багцыг үнэт цаасжуулах ажил гүйлгээ)

2015 онд Банк нь 4 удаагийн МИК-ийн орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаасны хэлцэлд оролцсон. Банк нь 8%-ийн хүүтэй зээлийн багцыг Монголын Ипотекийн Корпорацийн 100 хувийн эзэмшлийн компани болох МИК ТЗК4, МИК ТЗК5, МИК ТЗК6 болон МИК ТЗК7 тусгай зориулалтын компанид зарж, 4.5%-ийн хүүтэй, давуу эрхтэй ипотекийн зээлээр баталгаажсан бонд мөн 10.5%-ийн хүүтэй, энгийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд хүлээн авсан. МИК, тусгай зориулалтын компанийн худалдан авсан зээлийн багц нь буцаах нөхцөлгүй. Давуу эрхтэй үнэт цаасны үндсэн төлбөр хийгдсэн тохиолдолд энгийн үнэт цаасны үндсэн төлбөрийг авах боломжтой ба давуу эрхтэй үнэт цаас эзэмшигчид нь төлбөрийн хувьд давуу эрхтэй.

Банк нь зарагдсан зээл тус бүрийн хувьд Үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэх ба үйлчилгээний шимтгэлд цуглуулсан төлбөрөөс 2.5 хувийн шимтгэл авна. МИК-д үлдсэн цэвэр хөрөнгө нь (хэрэв байгаа бол) МИК-ийн хувьцаа эзэмшигчдэд очно. Түүнчлэн, МИК-ийн цэвэр хөрөнгө нь дутсан тохиолдолд үүнийг давуу болон энгийн үнэт цаас эзэмшигчид МИК-д буцаах нөхцөлгүйгээр хариуцна (төлбөр болон давуу эрхийн хувьтай тэнцүү хэмжээгээр).

Энэхүү гэрээний дагуу Банкны эзэмшиж буй давуу эрхтэй үнэт цаас нь Монголбанкнаас анх 8 хувийн хүүтэй орон сууцны зээлийг санхүүжүүлэх зорилгоор авсан 4 хувийн хүүтэй эх үүсвэрийг буцаан төлөхөд ашиглагдана.

Эдгээр зээлүүд нь НББОУС 39-ийн 36-д заасан данснаас хасах шаардлагыг хангасан эсэхийг Удирдлага үнэлж үзсэн. Мөнгөн хөрөнгийн эрхийн хугацаа дуусаагүй байгаа боловч эдгээр 8 хувийн Орон сууцны зээлийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ шилжүүлснээр бүх эрсдэл өгөөжийг давхар шилжүүлсэн гэж Удирдлага үзсэн. Тус шийдвэрийг гаргахдаа удирдлага банк бүрийн бүлгийн буюу ерөнхий эрсдлийн багц нь өөр өөр зээлдэгч, үүрэг хүлээгч, ипотекийн хөрөнгийн байршил зэргээс хамаараад зарсан зээлийн эрсдлийн багцаас эрс ялгаатай гэж үзсэн. Мөн эдгээр хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөхөд ашиг алдагдал үүсэх эсэхийг тооцсон.

Эдгээр хэлцлийг зах зээл дээр оролцогчид сайн дураараа хийсэн ба уг хэрэглүүрүүд нь зах зээлийн хүүтэй тул ашиг алдагдлыг анх хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж Удирдлага үзсэн. Түүнчлэн шийдвэр гаргахдаа Удирдлага нь эдгээр хэрэглүүр нь зах зээлийн тусдаа сегмент (тусдаа зах зээл) болохыг бодолцож үзсэн.

(v) Хөрөнгө оруулалтын сан (ХОС)-д оруулсан хөрөнгө оруулалт

Тодруулга 12-д заасны дагуу 2014 оны 12 дугаар сарын сүүлээр Банк нь Монгол Улсад байгуулагдсан анхны хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийсэн. Ингэснээр 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тухайн хөрөнгө оруулалтын сангийн нэгжийн 10 хувийг Банк эзэмшиж, үлдсэн нэгжийн 90 хувь нь энэхүү санхүүгийн тайлангийн батлагдсан өдрийн байдлаар бусдад худалдагдаагүй байсан. Удирдлагын зүгээс Банк нь тус хөрөнгө оруулалтын санг удирдах эрхгүй ба үйл ажиллагааны чиглэлд нөлөөлж чадахгүй гэж үзсэн тул уг хөрөнгө оруулалтыг НББОУС 39-д заасны дагуу борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт гэж ангилсан. Энэхүү дүгнэлтэд хүрэхийн тулд удирдлага нь доорх зүйлсийг авч үзсэн:

- 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тухайн хөрөнгө оруулалтын сан нь Банкинд хамааралгүй удирдлагын багтай бөгөөд Банкны эзэд болон удирдлагын зүгээс уг ХОС-н удирдлагыг өөрчлөх ямар нэгэн эрхгүй;

- Хөрөнгө оруулалтын сангийн удирдлагын зүгээс үлдэгдэл нэгжийн 90 хувьд хөрөнгө оруулагчийг идэвхтэй хайж байгаа бөгөөд хэрэв тухайн нэгжид хөрөнгө оруулагч олдохгүй тохиолдолд ХОС үйл ажиллагаагаа явуулж чадахгүйд хүрэх магадлалтай;
- Түүнчлэн холбогдох хуулийн болон гэрээний хүрээнд Голомт Банк болон бусад хөрөнгө оруулагчид ХОС-н удирдах компанийн үйл ажиллагаа, шийдвэр гаргалт болон хараат бус байдалд нөлөөлөх нь хориглогдсон;
- Голомт Банк нь хамгийн ихдээ өөрийн оруулсан хөрөнгө оруулалтыг алдаж болох ба бусад хөрөнгө оруулагчдын алдагдлыг үүрэх ямар нэгэн үүрэг байхгүй. Ашиг өгөөжийн хувьд Банк нь зөвхөн өөрийн оруулсан хөрөнгө оруулалтад хамаарах хэсгийн хүртэх ба бусад хөрөнгө оруулагчдын хийсэн хөрөнгө оруулалттай холбоотой аливаа урамшууллаас хүртэх эрхгүй;
- Банк нь тухайн ХОС-н хөрөнгө оруулалтын шийдвэрт оролцохгүй бөгөөд удирдлагын компани бие даан бусад төрлийн хөрөнгө оруулалтыг хийх шийдвэр гаргана.

(vi) Тасралтгүй байх зарчим

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Монгол Улсын бизнесийн орчны нөлөөлөл Группийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдалд нөлөөлөх Группийн удирдлагын өнөөгийн үнэлгээг тусгасан. Монгол Улсын эдийн засгийн ирээдүйн хандлага нь Засгийн газрын авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ болон улс төр зохицуулалтын хөгжлөөс шууд хамаарна. Энэ нь Группийн хяналтаас гадуур юм. Эдгээр хүчин зүйлс нь ирээдүйд Группийн санхүүгийн байдалд хэрхэн нөлөөлөхийг Группийн удирдлагууд таамаглаж чадахгүй юм.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ тасралтгүй байх зарчмыг баримтлалсан. Группийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон хөрвөх чадварын эрсдлийн менежментийг Тодруулга 34-өөс үзнэ үү. Хөрвөх чадварын эрсдлээ цаг алдалгүй удирдахын тулд Групп нь Группийн хөрвөх чадварын түвшинд нөлөө үзүүлж болох гадаад хүчин зүйлсийг тогтмол хянаж, мөнгөн урсгалаа төлөвлөдөг. Хөрвөх чадварын дунд болон урт хугацааны эрсдлийг удирдахдаа хөрөнгө болон өр төлбөрийн дуусгавар болох хугацааны зөрүүтэй байдлыг шинжилдэг. Эрсдэлд өртөх магадлалыг бууруулахын тулд Групп хөрвөх чадварын зөрүүний хязгаар тогтоодог бөгөөд энэхүү тогтоосон хязгаарыг гадаад болон дотоод орчны өөрчлөлттэй уялдуулан тогтмол хугацаагаар шалгадаг.

Хөрвөх чадварын шаардлагатай түвшинг хадгалахын тулд Групп болон Банк нь Монголбанкнаас болон банк хоорондын зах зээл дээрээс эх үүсвэр татах боломжтой. Хөрвөх чадварын эх үүсвэрийг төрөлжүүлэх нь Группийг ямар нэг эх үүсвэрээс хараат байх эрсдлийг хамгийн бага түвшин хүртэл бууруулж өр төлбөрөө бүрэн барагдуулах боломжийг олгодог. Группийн хуримтлуулсан өнөөгийн хөрвөх чадварын байдал болон нэмэлт санхүүжилт бий болгох боломжит эх үүсвэр зэрэг нь Группийг урт хугацааны турш үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах боломжийг олгодог. Өнгөрсөн үеийн түүхээс үндэслэн харахад харилцагчийн харилцах болон хадгаламж нь Банкны тогтвортой, урт хугацааны эх үүсвэрийг бүрдүүлж буй томоохон хэсэг юм. Тодруулга 34-өөс дэлгэрэнгүйг харна уу. Мөн Банк нь ойрын ирээдүйд тогтвортой үйл ажиллагаагаа явуулна гэж дүгнэхэд Удирдлагын зүгээс Банк нь хангалттай хэмжээний өөрийн хөрөнгөтэй (Тодруулга 35), толгой компаниас авсан нэг сарын дотор хөрвөх чадвартай томоохон хэмжээний санхүүгийн хөрөнгө болох хоёрдогч өглөг, түүний дуусах хугацааг сунгах боломж зэрэг боломжит санхүүжилт болон өөр бусад хүчин зүйлсийг тооцож үзсэн. Тодруулга 34-өөс дэлгэрэнгүйг харна уу.

(vii) Ханшийн тэгшитгэлийн зөрүү болон үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хойшлогдсон татвар

Одоо мөрдөгдөж буй татварын хууль тогтоомж болон холбогдох нэмэлт татварын хууль тогтоомжинд үүсмэл санхүүгийн хэрэглэлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүсэх олз гарзад хойшлогдсон татвар хүлээн зөвшөөрөх талаар тусгаагүй байдаг. Холбогдох татварын хууль нь зөвхөн ханшийн тэгшитгэлийн олз, гарзын татварыг хэрхэн тооцох талаар тусгасан бөгөөд байгууллагын орлогын албан татварын хуульд зөвхөн хэрэгжсэн ханшийн тэгшитгэлийн олзод татвар ногдуулна, хэрэгжсэн гарзыг татвар ногдуулах орлогоос хасна, хэрэгжээгүй олз, гарзыг хэрэгжих хугацааг хойшлуулж бүртгэнэ хэмээн заасан. Тиймээс орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөртөл татвар төлөхгүй орлого болон татвар ноогдох орлогоос хасахгүй зардал гэж үздэг ба дээрх хэрэгжээгүй олз, гарз нь татварын түр зөрүү үүсгэдэг. 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хүлээн зөвшөөрсөн цэвэр хойшлогдсон татварын өглөг нь 10,051,754 мянган төгрөг (2014 оны 12 дугаар сарын 31: 1,521,619 мянган төгрөг) байна. Дэлгэрэнгүйг тодруулга 31-ээс харна уу.

Дээрх шийдвэрийг гаргахдаа Банкны Удирдлага СТОУС-ын үндсэн зарчмууд, тухайн гүйлгээний шинж чанар, дээрх ажил гүйлгээтэй адил төрлийн гүйлгээг татварын хуулиар авч үзсэн байдал (жишээ нь: Гадаад валютын гүйлгээний болон гадаад валютын хөрөнгийн ханшийн тэгшитгэлийн зөрүүтэй холбоотой татварын хууль гэх мэт), мөн татварын байгууллагын сүүлийн үеийн практик, өмнөх татварын шалгалтын дүгнэлт, Банкны салбарын ерөнхий татварын практик болон хэрэгжсэн, хэрэгжээгүй татварын олз гарз гэсэн ойлголтыг авч үзэх байдал зэрэг хүчин зүйлсийг тооцож үзсэн. Татварын хууль тогтоомжид деривативын бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн хэрэгжээгүй олз, гарзыг татварын зорилгоор хэрхэн авч үзэх талаар тусгайлан заагаагүй болон гадаад валютын ханшийн тэгшитгэлийн олз, гарзыг хэрэгжсэн, хэрэгжээгүйгээр нь ялгах шаардлагыг харгалзан үзсэний үндсэнд удирдлага татварын байгууллага бодит үнэ цэнийн хэрэгжээгүй олзыг татвар ногдох орлого гэж авч үзэж нэмэлт татвар ногдуулах эсвэл Банкныг НББ-ын бодлогоо (Тодруулга 4) эргэн хянах шаардлага тавих эрсдлийг үнэлж дүгнэн, мөн санхүүгийн тайлан гарах өдрөөрх боломжит бүх мэдээлэлд үндэслэн уг эрсдлийг бага гэж дүгнэсэн.

Орлогын татварын талаар дэлгэрэнгүйг тодруулга 31-ээс, Монгол Улсад мөрдөгдөж буй татварын хуулийн тайлбарын тодорхойгүй байдлыг тодруулга 36-аас үзнэ үү.

Голомт Банк Групп

3 Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)

3.3 НББ-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглагдсан шийдвэрлэх тооцоолол ба үнэлэлтүүд (үргэлжлэл)

(viii) Монголбанкны журам болон СТОУС-ын зөрүүгээс үүдэлтэй хойшлогдсон татвар

Банк нь СТОУС-ын дагуу үнэ цэнэ бууралтын сан байгуулахаас гадна Монголбанкны (Төв Банк) тайлагналын шаардлагын дагуу үнэ цэнэ бууралтын санг Монголбанк болон Сангийн яамны баталсан Активыг ангилах, Эрсдлийн сан байгуулах журмын дагуу байгуулдаг. Эдгээр журмын дагуу Банк нь харилцагчид олгосон зээл болон урьдчилгааны чанарыг тоо хэмжээний болон чанарын хүчин зүйлс дээр үндэслэн тодорхойлдог. Чанарын хүчин зүйлсд хугацаа хэтэрсэн байдал гэх мэт хугацааны шинжтэй хүчин зүйлс хамаардаг. Харилцагчид олгосон зээл нь дараах байдлаар ангилагддаг: хэвийн, хугацаа хэтэрсэн, мөн чанаргүй гэж. Хэвийн бус, эргэлзээтэй мөн муу зээлийг чанаргүй зээл гэж үздэг. Ангилал бүрт урьдчилж тодорхойлсон хувийн дагуу эрсдлийн санг байгуулдаг. Байгууллагын орлогын албан татварын хуулийн дагуу хэвийн зээл дээр байгуулагдсан үнэ цэнэ бууралтын эрсдлийн сан нь татвар төлөх орлогоос хасагдах зардал гэж үзэхгүй. Харин бусад ангилалын зээлд байгуулсан эрсдлийн санг татвар төлөх орлогоос хасагдах зардал гэж үздэг. Өмнөх жилүүдийн адил 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк нь СТОУС-ын дагуу үнэ цэнэ бууралтын эрсдлийн сан байгуулахдаа хэвийн зээлд мөн эрсдлийн сан байгуулж татвар төлөх орлогоос хасагдахгүй зардал хэмээн тооцсон. Үүнээс гадна Монголбанкны эрсдлийн сан байгуулах журмын дагуу байгуулсан эрсдлийн сан нь татвар төлөх орлогоос хасагдах зардал байдаг ба СТОУС-ын дагуу байгуулсан эрсдлийн сангаас бага байсан. Удирдлагын зүгээс СТОУС-ын дагуу байгуулсан эрсдлийн сангийн (учирсан алдагдлын загвар дээр суурилсан) Монголбанкны журмын дагуу байгуулсан эрсдлийн сангаас давсан хэсэг нь Монгол банкны журмын дагуу ирээдүйд байгуулагдах санд орж улмаар ирээдүйд татвар төлөх орлогоос хасагдах зардал болно гэж үзсэн. Удирдлагын зүгээс хэвийн зээлийн эрсдлийн сангийн зардал болон хэвийн зээлийн эрсдлийн сангийн буцаалтын нягтлан бодох бүртгэл болон татварын тооцооллын талаар, мөн Монголбанкны журам болон СТОУС-ын дагуу байгуулсан эрсдлийн сангийн зөрүүнээс үүссэн татварын нөлөөллийг нарийвчлан үзсэн бөгөөд эдгээр нь түр зуурын татварын зөрүү үүсгэж, улмаар хойшлогдсон татварын авлага болох 11,495,335 мянган төгрөгийг (2014 оны 12 дугаар сарын 31: 808,016 мянган төгрөг) санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн.

Татварын хууль тогтоомжид хэвийн зээлийн сан буцаасантай холбоотой орлогын тухай тусгайлан заагаагүй ба Монголын татварын хуулийг олон янзаар тайлбарладаг зэрэг нөхцөл байдлыг (Тодруулга 36) харгалзан үзвэл Татварын байгууллагаас уг орлогод албан татвар ноогдуулах байр суурьтай хандах магадлалтай тул уг хойшлуулсан татварыг буцаан авах боломжгүй байх магадлалтай гэж үзсэн. Гэхдээ Банкны удирдлагууд энэхүү тайланг бэлтгэх өдрийн байдлаар хойшлогдсон татварын нөлөөллийг бага хэмээн үзэж байна. Мөн дээр дурьдсан Монголбанкны журмын дагуу 90-ээс дээш хоног хугацаа хэтрэлттэй зээлийн хүүгийн орлого нь ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрөгдөхгүй ба СТОУС-д уг хүүгийн орлогыг ашиг алдагдалд хүлээн зөвшөөрдөг. Татварын байгууллага нь Монголбанкны дээрх журмыг татвар суутгах орлого болон татвар төлөх орлогоос хасагдах зардлыг тооцохдоо мөрддөг тул дээрхтэй холбоотой СТОУС-н дагуу санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн хүүгийн орлогыг татвар суутгахгүй орлого үзэх буюу энэ нь түр зуурын зөрүүг үүсгэнэ. Энэхүү хүүгийн орлогыг харилцагчаас авсны дараа Монголбанкны журмын дагуу татвар суутгах орлого гэж үзнэ. Үүнээс үүдэн Банк нь 5,143,512 мянган төгрөгийг (2014 оны 12 дугаар сарын 31: 3,941,902 мянган төгрөг) хойшлогдсон татварын өглөгийг хүлээн зөвшөөрсөн. Удирдлагын зүгээс Татварын байгууллагаас уг хүүгийн орлогод албан татвар ноогдуулах байр суурьтай хандах магадлалтай, эсвэл Группийн татварын бодлогыг буруу гэж үзэн нэмэлт татвар ноогдуулах эрсдэлтэй гэж үзсэн. Гэвч энэхүү тайлант огнооны байдлаар мэдэгдэж буй мэдээлэл, татварын байгууллагын сүүлийн үеийн практик, өмнөх татварын шалгалтын дүгнэлт, Банкны салбарын ерөнхий татварын практик дээр үндэслэн Удирдлагын зүгээс дээр дурьдсан эрсдэл нь бага гэж үзсэн.

Орлогын татварын талаар дэлгэрэнгүйг тодруулга 31-ээс, Монгол улсад мөрдөгдөж буй татварын хуулийн тайлбарын тодорхойгүй байдлыг тодруулга 36-аас үзнэ үү.

4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Банкны болон Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг дор толилуулав. Өөрөөр заагаагүй тус бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үе бүрт тууштай хэрэгжүүлсэн болно (Тодруулга 5-аас үзнэ үү).

4.1 Нэгтгэл

Охин компани гэж Банкны хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийг хэлнэ. Групп нь (i) тухайн аж ахуйн нэгжийн ашигт байдалд мэдэгдэхүйц хэмжээгээр нөлөөлөх үйл ажиллагааг чиглүүлэх эрхтэй тул, (ii) тухайн хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжээс ашиг хүртэх эрхтэй тул, мөн түүнчлэн (iii) хөрөнгө оруулагчид хүртээх ашгийн хэмжээг тогтоох эрхтэй тул Групп энэхүү аж ахуйн нэгжийг удирддаг гэж үзнэ. Групп нь өөр аж ахуйн нэгжийг шууд удирддаг эсэхийг тодорхойлоход Группийн эрх мэдлийн хэм хэмжээ болон нөлөөлөхүйц эрх мэдэлтэй эсэхийг авч үздэг. Үүнд санал өгөх эрх зэрэг орно. Нөлөөлөхүйц эрх мэдэл гэж хөрөнгө оруулсан тухайн аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагааны чиглэлийн зайлшгүй шийдвэр гаргах үед хөрөнгө оруулагч нь бие даан шийдвэр гаргах эрхтэй байхыг хэлнэ. Групп нь дийлэнхээс бага саналын эрхийг эзэмшдэг хэр нь тухайн хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжээс илүү эрхтэй байж болно. Энэ тохиолдолд хөрөнгө оруулсан тухайн компаниас илүү саналын эрхтэй эсэхийг тодорхойлохдоо өөрийн саналын эрхийг бусад хөрөнгө оруулагчдын саналын эрхийн хэмжээнд харьцуулж тогтооно. Бусад хөрөнгө оруулагчдын

хамгаалагдсан эрх (онцгой тохиолдолд үйлчлэх гэх мэт) нь Группийн хөрөнгө оруулалтаа хийсэн аж ахуйн нэгжийг удирдах эрхийг хааж чадахгүй. Охин компанийн санхүүгийн тайлангийн нэгтгэл нь тухайн компани Группийн шууд удирдлаганд орсон цагаас эхлэх ба шууд удирдлагаас гарсан өдрөөс эхлэн санхүүгийн тайлангийн нэгтгэл зогсоно.

Группийн хооронд хийгдсэн ажил гүйлгээнээс үүссэн хэрэгжээгүй олзыг хасах бөгөөд түүнчлэн буцаан нөхөгдөх хэрэгжээгүй гарзыг мөн хасна. Банк болон түүний охин компаниуд Группийн адилаар нэг ижил нягтлан бодох бүртгэлийн бодлого баримталдаг.

4.2 Санхүүгийн хөрөнгүүд

Групп нь санхүүгийн хөрөнгүүдээ дараах байдлаар ангилна:

- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө (Тодруулга 4.4 ба 4.5)
- Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгө (Тодруулга 4.6);
- Зээл ба авлага (Тодруулга 4.7 ба 4.8);
- Дуусах хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас (Тодруулга 4.9);
- Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас (Тодруулга 4.10).

Санхүүгийн хөрөнгийн хэмжилтийн ангиллын талаар тодруулга 39 -ийг үзнэ үү.

Групп санхүүгийн хөрөнгүүдийн ангиллыг анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр тодорхойлдог. Анхдагч хүлээн зөвшөөрөлтөөрх санхүүгийн хөрөнгүүдийн ангилал нь тэдгээрийг олж эзэмших болсон зорилго болон тэдгээрийн шинж чанараас хамаарна. Санхүүгийн хэрэглүүрүүдийн ангиллаас хамааран тэдгээрийг дор тайлбарласны дагуу бодит үнэ цэнэ эсвэл хорогдуулсан өртгөөр бүртгэлд тусгадаг.

(i) Үндсэн нэр томъёо

Бодит үнэ цэнэ нь зах зээлд оролцогчдын хооронд хөрөнгө худалдах эсвэл өр төлбөр барагдуулах гүйлгээг хэмжилтийн огноогоор зохион байгуулалттай явуулахад авах үнэ юм. Бодит үнэ цэнийн хамгийн тод жишээ бол идэвхтэй зах зээл дээрх үнэ юм. Идэвхтэй зах зээл гэдэг нь хөрөнгө болон өр төлбөрийн хэлцлүүд нь үнийн мэдээллээр тогтмол хангахуйц түвшинд явагддаг зах зээлийг хэлнэ. Идэвхтэй зах зээлд арилжаалагдаж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хэмжихдээ тухайн хөрөнгө болон өр төлбөрийн заасан үнэ болон тухайн байгууллагын эзэмшиж буй хэмжээний үр дүнгээр тооцдог. Үүнийг зах зээлийн ердийн өдөр тутмын арилжааны хэмжээ нь эзэмшиж буй дүнгийн түвшинд хүрэхгүй бөгөөд позицийг нэг арилжаагаар зарах захиалга өгсөнөөр заасан үнэнд нөлөөлөх нөхцөл үүсгэсэн байлаа ч үүнийг ашиглах боломжтой.

Идэвхтэй зах зээлд арилжаалагддаггүй санхүүгийн үүсмэл хэрэглүүр болон бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн багцыг хэмжихдээ бүлэг санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг ашиглана. Ингэхдээ тодорхойлох өдрийн байдлаар зах зээлд оролцогч нарын хооронд тухайлсан эрсдэлийн дүнгийн хувьд цэвэр урт позицийг (өөрөөр хэлбэл хөрөнгө) зарахад хүлээн авах үнэ эсвэл цэвэр богино позицийг (өөрөөр хэлбэл хөрөнгө) шилжүүлэхэд төлөх үнэнд суурилна. Энэ нь давтагдах байдлаар бодит үнэ цэнээр бүртгэгдсэн хөрөнгийн хувьд хамааралтай ба Банк (а) Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийг зах зээлийн тодорхой эрсдэлийн хувьд эсхүл байгууллагын баримтжуулсан эрсдэлийн удирдлага болон хөрөнгө оруулалтын стратегийн дагуу тодорхой талын зээлийн эрсдэлийн хувьд удирддаг бол (б) Хөрөнгө болон өр төлбөрийн мэдээллийг гол удирдлагад мэдээллэдэг бол (в) тухайн байгууллагын зах зээлийн тодорхой эрсдэл (эсвэл эрсдлүүд)-д өртөх байдал, санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөртэй холбоотой гарах зах зээлийн тодорхой эрсдлүүд нь үндсэндээ ижил бол тус хамааралтай байна.

Гадаад зах зээлийн мэдээлэл авах боломжгүй тохиолдолд санхүүгийн тодорхой хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцохдоо хямдруулсан мөнгөн урсгалын загвар, сүүлийн үеийн ойролцоо хэлцэлд ашигласан загвар болон хөрөнгө оруулсан талын санхүүгийн тайлан мэдээ зэрэг үнэлгээний аргачлалыг ашиглана. Бодит үнэ цэнийг бодит үнэ цэнийн ангилал тус бүрт тодорхойлох ба эдгээр түвшин нь (i) Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан 1-р түвшинд тодорхойлно (ii) Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлыг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийг тодорхойлох аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ (iii) 3-р түвшинд зах зээлийн ашиглаж болох өгөгдөл тулгуурлахгүйгээр (ашиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийг тодорхойлно. Тайлант хугацааны эцэст бодит үнэ цэнийн түвшин хооронд шилжүүлэг явагдсан гэж үзсэн ба дэлгэрэнгүйг Тодруулга 38-с үзнэ үү.

Өртөг нь тухайн хөрөнгийг худалдан авах үед зарцуулсан мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө, мөн бусад төлбөрийн нөхцөлийн бодит үнэ цэнэ болон үүнтэй холбоотой гүйлгээний зардлыг хэлнэ. Зах зээлийн жишиг үнэ байхгүй, бодит үнэ цэнэ нь хэмжигдэх боломжгүй үнэт цаасны хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг анхны өртгөөр нь хэмжинэ.

4.2 Санхүүгийн хөрөнгүүд (үргэлжлэл)

(i) Үндсэн нэр томъёо (үргэлжлэл)

Гүйлгээний зардлууд нь санхүүгийн хэрэглүүрүүдийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал нь гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх зардал юм. Гүйлгээний зардалд агент (борлуулагч агентын үүрэг гүйцэтгэж буй ажиллагсад), зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах агентлаг болон хөрөнгийн биржийн ногдуулсан хураамж төлбөрүүд, мөн шилжүүлэлтэнд ногдуулсан татвар хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт буюу нэмэгдэл, санхүүгийн зардлууд, дотоодын удирдлагын буюу хадгалалтын зардлууд орохгүй.

Хорогдуулсан өртөг нь санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн дүнгийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон гүйлгээний зардлын хорогдуулалт, мөн үнийн аливаа нэмэгдэл буюу хөнгөлөлтийн дүнгийн үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулалт орно.

Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн хорогдуулсан нэмэгдэл буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийг санхүүгийн байдлын тайлан дахь тэнцэлд хамаарах хэсэгт бүртгэлийн үнээр тусгасан болно.

Үр ашигт хүүгийн арга нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны туршид дансны үнээс тооцогдох хүүгийн хувийг тогтмол байлгах аргаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн орлого, гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны туршид хямдруулж санхүүгийн хэрэглүүрүүдийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүгийн хувь болно. Үр ашигт хүүгийн хувь нь хувьсах хүүтэй хэрэглүүрийн мөнгөн урсгалыг хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл хямдруулах боловч хэрэглүүрт тусгагдсан хөвөх хүү дээр нэмэгдэх зээлийн хүүгийн зөрүүг илэрхийлсэн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг, мөн зах зээлийн түвшинд тохируулагддаггүй бусад хувьсах хүчин зүйлсэд үл хамаарна. Тийм нэмэгдэл, хөнгөлөлтийг хэрэглүүрийн хүлээгдэж буй нийт хугацаагаар хорогдуулна. Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд өгч авалцах бүх хураамжийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болно.

(ii) Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх

Арилжааны үнэт цаас, үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд болон санхүүгийн бусад хэрэглүүрүүд нь анх бодит үнэ цэнээр бүртгэгдэнэ. Бусад санхүүгийн хэрэглүүрүүд нь анх бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардал нэмсэн дүнгээр бүртгэгддэг. Анх бүртгэх бодит үнэ цэнэ нь гүйлгээ хийгдсэн үнээр хамгийн баталгаатайгаар нотлогдоно. Анх бүртгэх үед үүсэх олз эсвэл гарз нь бодит үнэ цэнэ болон гүйлгээний үнийн хооронд зөрүү гарсан тохиолдолд л бүртгэгдэх бөгөөд үүнийг зөвхөн ижил төрлийн хэрэглүүрийг сүүлийн үед арилжсан талаарх зах зээлийн нээлттэй мэдээллээр баталгаажуулсан эсвэл зөвхөн нээлттэй зах зээлээс авсан мэдээлэл дээр үндэслэж хийсэн үнэлгээний аргачлалаар тооцсон тохиолдлуудад бүртгэгдэх.

Зохицуулалт эсвэл зах зээлийн жишгээр тогтоогдсон ("хэвийн" худалдаа болон худалдан авалт) тодорхой хугацаанд багтаан нийлүүлэх шаардлагтай санхүүгийн хөрөнгийн бүхий л худалдаа болон худалдан авалтыг арилжаа хийсэн өдөр буюу Банк тухайн санхүүгийн хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээсэн үед бүртгэнэ. Бусад бүх худалдан авалтыг Банк санхүүгийн хэрэглүүрийн гэрээний тал болсон үед хүлээн зөвшөөрнө.

(iii) Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах

Групп нь санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд бүртгэлээс хасдаг: (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ Групп бусдад шилжүүлэн өгсөн эсвэл хүлээн зөвшөөрөгдсөн дамжуулан өгөх хэлцэлд оролцож (1) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь өөрөөсөө шилжүүлсэн, эсвэл (2) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг үндсэнд нь өөрөөсөө шилжүүлээгүй ч, мөн өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй тохиолдолд. Хяналтын эрхийг хадгалж үлдэнэ гэдэг нь нөгөө тал хөрөнгийн борлуулалтанд нэмэлт хязгаарлалт хийлгүйгээр холбоогүй гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах боломжгүй тохиолдлыг хэлнэ.

4.3 Гадаад валютын хөрвүүлэлт

Мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг тайлант хугацааны эцсийн өдрийн Монголбанкны албан ханшаар хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ болон гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг жилийн эцсийн өдрийн Монголбанкны албан ханш руу хөрвүүлснээс үүсэх ханшийн олз, гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Түүхэн өртгөөр бүртгэдэг мөнгөн бус зүйлүүдийг тайлант жилийн хаалтын ханшаар хөрвүүлж бүртгэхгүй.

Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар илэрхийлэгддэг мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрүүдийг (үүнд үнэт цаасны хөрөнгө оруулалт орно) бодит үнэ цэнэ тооцогдсон өдрийн ханшийг ашиглан хөрвүүлнэ. Гадаад валютын ханшийн зөрүүгээс гарсан өөрчлөлт нь бодит үнэ цэнийн олз (гарз) дээр бүртгэгддэг.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхэд ашиглагдсан валютын ханшийг доорх хүснэгтэд үзүүлэв:

	2015	2014
Монгол улсын төгрөг /Ам.доллар		
12 сарын 31	1,995.98	1,885.60
Монгол улсын төгрөг /Евро		
12 сарын 31	2,182.70	2,293.36
Монгол улсын төгрөг / Фунт Стерлинг		
12 сарын 31	2,957.54	2,927.58
Монгол улсын төгрөг / Юань		
12 сарын 31	307.54	303.57
Монгол улсын төгрөг /Рубль		
12 сарын 31	27.40	33.25

4.4 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд тодорхой хэмжээний мөнгө рүү түргэн хөрвөх боломжтой, үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлс хамаарна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд Төв Банкинд (Монголбанкинд) байршуулсан, зайлшгүй байлгах нөөцөөс бусад хадгаламжууд, Монголбанк ба Засгийн газрын үнэт цаас, мөн бусад Банкуудад 3-аас доош сарын анхны хугацаатай байршуулсан бүх мөнгөн хөрөнгө орно. Ашиглалтанд нь анх гурван сараас дээш хугацаагаар хязгаарлалт хийсэн эх үүсвэрийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулахгүй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Мөнгөн гүйлгээний тайланд тусгасан төлбөрт Группийн шилжүүлсэн бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө орох ба үүнд Группийн харилцагч талуудын Банкинд байршуулсан харилцах дансанд оруулсан болон гаргасан үндсэн эзэл болон хүүгийн орлого, зарлага зэргийг багтаасан. Учир нь харилцагчдад олгосон эзэл нь харилцагчийн хувьд бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг төлөөлөх учир ийнхүү оруулсан.

4.5 Төв Банкинд байршуулсан, заавал байлгах нөөцийн үлдэгдэл

Монгол Улсын Төв Банкинд байршуулсан заавал байлгах нөөцийн үлдэгдэл гэж Группийн өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжгүй, Төв Банкинд байршуулсан нөөцийн дансыг хэлнэ. Энэхүү нөөцийн үлдэгдлийг мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулахгүй.

4.6 Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгө

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгөнд арилжааны үнэт цаас болон бусад бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгүүд багтана.

Арилжааны үнэт цаас нь үнийн эсвэл арилжаалагчийн ашгийн түвшний богино хугацааны хэлбэлзлээс ашиг хүртэх зорилгоор олж эзэмшсэн үнэт цаас эсвэл богино хугацааны арилжааны загвар оршин буй тохиолдолд багцад багтсан үнэт цааснуудыг илэрхийлнэ. Групп нь үнэт цаасыг худалдан авснаас хойш богино хугацааны дотор борлуулахаар зорьж байвал арилжааны үнэт цаас гэж ангилна. Арилжааны үнэт цаасыг ойрын хугацаанд тохиолдох магадлал маш бага, ер бусын, маш тодорхойгүй нэг үйл явдлаас үүссэн ховор тохиолдлоос бусад үед дахин ангилахгүй.

Арилжааны үнэт цаасыг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрнө. Арилжааны үнэт цааснаас олсон хүүгий орлогыг нэгтгэсэн орлогын тайлан болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүүгийн орлогоор тусгана. Ногдол ашгийг Групп авах эрх нь үүссэн бөгөөд хүлээн авах нь тодорхой үед нэгтгэсэн орлогын тайлан болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн авсан ногдол ашгаар хүлээн зөвшөөрнө. Бодит үнийн цэнийн өөрчлөлт болон үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз, гарзын бусад бүх элементүүдийг үүссэн тайлант үед нь нэгтгэсэн орлогын тайланд бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз гарзын зөрүүгээр бүртгэнэ.

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрт голчлон гадаад валютын хүүгийн түвшний форвард арилжааны хэлцлүүд болон валют солилцооны гэрээ багтана. Дериватив санхүүгийн хэрэглүүр нь бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгийг төлөөлдөг бөгөөд бодит үнэ цэнээр бүртгэгддэг. Бүх дериватив санхүүгийн хэрэглүүрүүд бодит үнэ цэнэ нь эерэг бол хөрөнгөөр, сөрөг тохиолдолд өр төлбөрөөр бүртгэгддэг. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн жилийн орлого, зардалд тусгадаг (Деривативын ашгаас алдагдлыг хассан дүнгээр). Групп нь эрсдлээс хамгаалалтын нягтлан бодох бүртгэл хөтөлдөггүй.

Голомт Банк Групп

4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.6 Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

Мөн хоёрдогч өглөг гэх зэрэг зарим санхүүгийн хэрэглүүрт үүсмэл санхүүгийн хэрэглүүр агуулагдсан байдаг тул түүний эрсдэл болон шинж чанар нь үндсэн гэрээний нөхцөлтэй холбоогүй үед тусдаа үүсмэл санхүүгийн гэж авч үздэг. Дэлгэрэнгүйг тодруулга 25-аас үзнэ үү. Эдгээр агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй Орлогын Тайланд тусдаа мөрөнд үзүүлсэн.

4.7 Бусад Банкуудад байршуулсан хөрөнгө

Бусад Банкуудад байршуулсан хөрөнгийг Банк харилцагч Банк руу арилжааны бус зорилгоор мөнгө шилжүүлснээр хөрөнгийн зах зээл дээр бүртгэгдээгүй, дериватив бус, тодорхой буюу тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх авлага үүсэх үед хүлээн зөвшөөрнө. Бусад Банкуудад байршуулсан хөрөнгийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

4.8 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг Групп нь харилцагчдаасаа хөрөнгийн зах зээл дээр бүртгэгдээгүй, дериватив бус, тодорхой буюу тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх авлагыг худалдан авах буюу үүсгэх зорилгоор мөнгө шилжүүлсэн үед, мөн уг авлагаа арилжих зорилгогүй тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

4.9 Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас

Энэ ангилалд тогтсон эсвэл тодорхой төлбөр болон тогтсон дуусах хугацаатай, Групп нь хугацаа дуусах хүртэл эзэмших эрмэлзэл, боломжтой үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрүүд багтана. Хэрэв үнэт цаас гаргагчийг хугацаанаас нь өмнө эргэн төлөлт хийх эсвэл хөрөнгө оруулалтыг буцаан авахыг Банк шаардах эрхтэй ба хөрөнгийг хугацаа дуусах хүртэл нь эзэмших зорилгыг өөрчлөх боломжтой бол хөрөнгө оруулалтыг дуусах хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтаар ангилахгүй. Дуусах хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтыг анх хүлээн зөвшөөрөх үед нь Удирдлага ангилдаг ба тухайн ангиллын зохистой эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт дахин үнэлдэг. Дуусах хугацаа хүртэл эзэмших үнэт цаасыг хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

Хэрэв Групп дуусах хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын багцын нөлөө бүхий хэсгийг хугацаанаас нь өмнө борлуулвал энэхүү ангиллын үлдэх санхүүгийн хөрөнгүүдийг борлуулах зориулалттай санхүүгийн хөрөнгөөр дахин ангилна. Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтаас үүссэн хүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрнө.

4.10 Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас

Энэ ангилалд Банк нь хөрвөх чадвар хэрэгтэй болсон үед болон хүү, ханш, хөрөнгийн үнэ өөрчлөгдөхөд зарах зориулалтаар тодорхойгүй хугацаагаар эзэмшиж буй хөрөнгө оруулалтын үнэт цаасыг багтаана. Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаасыг бодит үнээр бүртгэдэг. Борлуулахад бэлэн өрийн үнэт цаасыг үр ашигт хүүгийн аргаар тооцож жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг.

Борлуулахад бэлэн өрийн хөрөнгийн хэрэглүүрийн ногдол ашгийг төлбөр хүлээн авах Банкны эрх үүсч, ногдол ашиг авах нь тодорхой болсон үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн бусад хэсгийг тухайн хөрөнгө оруулалт эргүүлэн хүлээн зөвшөөрөгдөх эсвэл үнэ цэнийн бууралтад орох хүртэл бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх ба энэ үед нийт ашиг, алдагдал нь бусад дэлгэрэнгүй орлогоос жилийн ашиг, алдагдалд шилжин ангилагдана. Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон нэг болон хэд хэдэн үйл явдлын ("алдагдлын тохиолдол") үр дүнд алдагдал үүсэх үед үнэ цэнийн бууралтын алдагдлыг жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Өөрийн хөрөнгийн үнэт цаас өөрийн үнээс доогуур түвшинд бодит үнэ нь үргэлжлэн буурах нь тухайн үнэт цаас үнэ цэнийн бууралтад орсны илэрхийлэл юм. Худалдаж авахад гарсан зардал болон одоогийн бодит үнийн зөрүүгээс ашиг, алдагдалд өмнө нь хүлээн зөвшөөрөгдсөн тухайн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассанаар тооцоологддог үнэ цэнийн бууралтын нийт алдагдал нь бусад дэлгэрэнгүй орлогоос жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөгдөнө. Өөрийн хөрөнгийн хэрэглүүрийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаахгүй ба цаашид гарсан аливаа ашгийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Хэрэв дараа дараагийн хугацаан дахь борлуулахад бэлэн ангилалд багтсан өрийн хэрэглүүрийн бодит үнэ өсч, энэхүү өсөлт нь ашиг, алдагдалд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрснөөс хойшхи үйл явдалтай холбоотой бол жилийн ашиг алдагдлаас үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.

4.11 Худалдан авсан өрийн бичиг

Худалдан авсан өрийн бичиг нь тэдгээрийн эдийн засгийн мөн чанараас хамааран борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө, дуусах хугацаа хүртэл нь эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас, бусад Банкнаас авах авлага эсвэл харилцагчдад олгосон зээлд багтах ба хөрөнгийг эдгээр ангиллуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу бүртгэнэ.

4.12 Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Санхүүгийн хөрөнгийг анх бүртгэснээс хойш тохиосон нэг буюу олон үйл явдлын (“гарз учруулсан үйл явдлууд”) үр дүнд үүссэн бөгөөд санхүүгийн дан ганц эсвэл бүлэг хөрөнгөөс ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын хэмжээ болон цаг хугацаанд нөлөө үзүүлэх үнэ цэнийн алдагдлыг тухайн нөлөөг баталгаатай тооцох боломжтой үед тайлант жилийн орлого, зарлагд бүртгэнэ. Хэрэв Банк нь дан ганцаар үнэлсэн санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнэ буурсаныг илэрхийлэх бодит нотолгоо байхгүй гэж тодорхойлсон бол тухайн санхүүгийн хөрөнгийг ижил төрлийн зээлийн эрсдлийн шинж чанартай санхүүгийн хөрөнгийн бүлэгт багтаан уг бүлгийн үнэ цэнийн бууралтыг хамтатган үнэлдэг. Банкны санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлохдоо авч үздэг үндсэн хүчин зүйлс нь тэдгээрийн хугацаа хэтрэлтийн байдал, мөн аливаа холбогдох барьцаа хөрөнгийг борлуулах бололцоо юм.

Үнэ цэнийн алдагдал үүссэн эсэхийг илэрхийлэх бодит нотолгоог тодорхойлоход дараах бусад үндсэн шалгууруудыг мөн авч үздэг:

- хуваарьт төлбөрүүдийн аль нэг нь хугацаа хэтэрсэн бөгөөд хугацаа хэтрэлт нь төлбөр тооцооны системээс үүссэн сааталтай хамааралгүй;
- зээлдэгч санхүүгийн мэдэгдэхүйц хүндрэлд орсон нь Банкны олж авсан санхүүгийн мэдээллээр баталгаажсан;
- зээлдэгч дампуурлаа зарлах буюу санхүүгийн бүтцийн өөрчлөлт хийхээр төлөвлөж байгаа;
- улсын буюу орон нутгийн эдийн засгийн нөхцөл байдал зээлдэгчид нөлөөлөхүйцээр өөрчлөгдсөнөөс түүний төлбөр төлөлтийн байдал муудсан;
- зах зээлийн нөхцөл байдал муудсанаас барьцаа хөрөнгийн үнэ цэнэ мэдэгдэхүйц хэмжээгээр буурсан.

Үнэ цэнийн бууралтыг хамтатган үнэлэх зорилгоор санхүүгийн хөрөнгүүдийг зээлийн эрсдлийн шинж чанарт үндэслэж, ижилсүүлэн бүлгүүдэд хуваарилдаг. Тэдгээр шинж чанарууд нь өглөгтэй талууд бүх өр төлбөрөө гэрээний нөхцлийн дагуу эргэн төлөх чадварыг илэрхийлдэг тул тухайн бүлгийн ирээдүйн мөнгөн урсгалыг тооцоолоход ач холбогдолтой юм.

Бүлэг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хамтатган үнэлж буй тохиолдолд тэдгээрийн ирээдүйн мөнгөн урсгалыг гэрээгээр заасан мөнгөн урсгал, мөн өмнөх үеийн хугацаа хэтрэлт болон төлбөр нөхөн төлөгдсөн түүхийн талаарх удирдлагын туршлага дээр үндэслэн тооцоолдог. Өнөө үеийн мэдээллийн үндсэн дээр өмнөх үеийн туршлагаа баяжуулж өмнөх үед нөлөө үзүүлээгүй шинэ нөхцөл байдлын нөлөөг оруулж өнөө үед арилсан өмнөх үеийн нөхцөл байдлын нөлөөг арилгадаг.

Хэрэв хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан бөгөөд түүний нөхцлийг өөрчлөн тохиролцсон эсвэл нөхцлүүдийг зээлдэгч эсвэл үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал муудсанаас өөрчилсөн тохиолдолд үнэ цэнийн бууралтыг нөхцөл өөрчлөгдөхийн өмнөх үр ашигт хүүг ашиглан тооцно.

Үнэ цэнийн алдагдлыг үргэлж нөөцийн сангийн дансанд бүртгэж хөрөнгийн дансны үнийг хүлээгдэж буй мөнгөн урсгалын (зээлийн хэрэгжээгүй ирээдүйн алдагдлыг оруулаагүй дүнгээр) анхны үр ашигт хүүгээр тооцсон өнөөгийн үнэ цэнэ хүртэл бууруулж бүртгэнэ. Барьцаат хөрөнгөөр баталгаажсан санхүүгийн хөрөнгийн ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын өнөөгийн өртгийг барьцаа хөрөнгийг хураан авах нь магадлалтай эсэхээс үл хамааран түүнийг хураан авч борлуулснаас олох орлого болон зардлын зөрүүн дээр үндэслэн тооцно.

Хэрэв үнэ цэнийн алдагдал дараах үеүдэд буурсан бөгөөд уг бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш тохиосон бодит үйл явдалтай холбох боломжтой бол өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн алдагдлыг үнэ цэнэ бууралтын сангийн дансанд залруулан бичих замаар тухайн жилийн орлого, зарлагд бүртгэнэ. Эргэн төлөгдөх боломжгүй болсон хөрөнгийг хасагдуулахдаа хөрөнгийг нөхөн төлүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авсан бөгөөд алдагдлын хэмжээ тодорхой болсон үед холбогдох алдагдлын сангийн дансанд бүртгэн хасагдуулна. Өмнө нь хасагдуулсан хөрөнгийн дүн дараа нь нөхөн төлөгдсөн тохиолдолд нөхөн төлөгдсөн дүнг тухайн жилийн орлого, зарлагд бүртгэж алдагдлын сангийн дансыг бууруулна.

Групп нь дангаараа өндөр дүнтэй зээл болон урьдчилгаа бүрт тусгайлан сан байгуулна. Үнэ цэнийн бууралтын сангийн хэмжээг тодорхойлоход зээлдэгчийн бизнес төлөвлөгөөний тогтвортой байдал, санхүүгийн хүндрэл гарахад үйл ажиллагаагаа сайжруулах чадвар, дампуурсан тохиолдолд төлөвлөснөө хүлээн авах болон ногдол ашгийн төлбөр, гаднаас авах санхүүгийн дэмжлэгийн боломж, барьцаа хөрөнгийн борлуулах үнэ болон мөнгөн урсгалын хүлээгдэж буй цаг хугацаа гэх мэтийг авч үзнэ. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг төлөвлөөгүй нөхцөл байдлын улмаас илүү нарийн авч үзэхээс гадна тайлант хугацаа бүрээр үнэлнэ.

Дангаараа өндөр дүнгүй зээлүүд болон дангаараа өндөр дүнтэй боловч дангаараа үнэ цэнэ буурсан гэх бодит нотолгоо гараагүй зээл болон урьдчилгаанд бүлгээр нь сан байгуулна. Багц тус бүрт тайлант үед байгуулсан сангийн хэмжээг удирдлагын зүгээс хяналт тавина. Тусгайлан үнэлэхэд үнэ цэнэ бууралтын бодит нотолгоо илрээгүй боловч бүлгээр үнэлэхэд гарсан үнэ цэнийн бууралтыг багцын үнэ цэнийн бууралтаар тооцно. Үнэ цэнийн бууралтын алдагдалд дараах зүйлсийг авч үзнэ: багцад гарч байсан түүхэн алдагдал, эдийн засгийн өнөөгийн байдал, алдагдал тохиох болон үнэ цэнийн бууралтыг нь тусгайлан авч үзэх шаардлагатай хэмээн үзэх хүртэлх хугацааны хожимдол болон үнэ цэнийн бууралтад орсны дараах эргэн төлөлт гэх зэрэг.

Голомт Банк Групп

4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.13 Хөрөнгө, өр төлбөрийг хооронд нь хаах

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хооронд нь хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр бүртгэх нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийн хаалт хийх эрх зүйн үндэслэл байгаа бөгөөд төлбөрийг цэвэр дүнгээр хийх эсвэл хөрөнгийг худалдаж, нэгэн зэрэг өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө байгаа тохиолдолд л зөвшөөрөгдөнө. Эдгээр хооронд нь хаах эрх нь (а) ирээдүйд болох ямар нэгэн үйл явдлаас хамааралгүй байх, мөн (б) доорхи нөхцөл байдалд хуулийн хүрээнд шийдвэрлэх боломжтой байх ёстой. Үүнд: (i) бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед, (ii) дампуурах үед, мөн түүнчлэн төлбөрийн чадваргүй болсон үед.

4.14 Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн өр төлбөр эсвэл хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилна.

Групп нь бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгддөггүй санхүүгийн өр төлбөрийг анх бүртгэхдээ түүний бодит үнэ цэнэ болон санхүүгийн өр төлбөрийг худалдан авах үед зарцуулсан ажил гүйлгээний дүнгийн нийлбэрээр бүртгэнэ.

Санхүүгийн өр төлбөрийн үүрэг чөлөөлөгдөх, хүчингүй болох, эсвэл хугацаа нь дуусах үед санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөрийг өөр заалттай өр төлбөрөөр солих эсвэл заалтийг их хэмжээгээр өөрчлөх үед анхны өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрж, өөрчлөгдсөн өр төлбөрийг шинээр хүлээн зөвшөөрнө. Өр төлбөрийн өөрчлөлтөөс үүссэн зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ.

Бусад Банкнаас байршуулсан хөрөнгө - Бусад Банкнаас байршуулсан хөрөнгийг харилцагч Банк Банк руу мөнгө буюу бусад төрлийн хөрөнгө шилжүүлсэн үед хүлээн зөвшөөрнө. Дериватив бус өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Хэрэв Банк өөрийн гаргасан өрийн хэрэгслийг эргүүлэн худалдаж авах тохиолдолд холбогдох өр төлбөрийг санхүүгийн байдлын тайлангаас хасч дансны үнэ болон тухайн өрийг худалдан авахад төлсөн төлбөрийн дүнгийн зөрүүг өрийг хасагдуулахад үүссэн олз эсвэл гарзад оруулан бүртгэнэ.

Харилцагчдын харилцах, хадгаламж - Харилцагчдын харилцах, хадгаламжууд нь хувь хүмүүс, улсын болон хувийн эзэмшлийн аж ахуйн нэгж, байгууллагад төлөх дериватив бус өр төлбөр бөгөөд хорогдуулсан өртгөөр бүртгэгддэг.

Зээлээр авсан бусад эх үүсвэр - Зээлээр авсан бусад эх үүсвэрт олон улсын санхүүгийн байгууллагууд, Монгол Улсын Засгийн Газар, төрийн байгууллагуудаас авсан зээл болон гаргасан өрийн бичгүүд багтана. Эдгээр санхүүгийн өр төлбөрүүдийг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

Хоёрдогч өглөг - Хоёрдогч өглөгийг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Хоёрдогч өглөг нь энгийн хувьцаанд хөрвөх боломжтой бөгөөд энэ нь агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглэлийн тодорхойлолтыг хангаж байвал тайлант хугацааны эцэс бүрт тухайн агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглэлийн үнэ цэнийг тооцож, өөрчлөлтийг тухайн жилийн орлого зарлагад хүлээн зөвшөөрнө. Дэлгэрэнгүйг тодруулга 25-с үзнэ үү.

Худалдааны болон бусад өглөг - Худалдааны өглөгийг нөгөө тал гэрээнд заасан үүргээ биелүүлсэн үед хуримтлуулан тооцож хорогдуулсан өртгөөр тусгана.

4.15 Борлуулалт болон буцаан худалдан авах хэлцэл

Борлуулалт болон буцаан худалдан авах хэлцэл ("репо хэлцэл")-ийг зээлдэгчийн эргэн төлөлтийг үр дүнтэйгээр хангах баталгаат санхүүгийн гүйлгээ гэж үздэг. Repo хэлцлийн хүрээнд худалдсан үнэт цаасыг бүртгэлээс хасдаггүй.

Үнэт цаасны санхүүгийн байдлын тайлан дахь ангиллыг ерөнхийдөө өөрчилдөггүй боловч үнэт цаасаа шилжүүлж буй тал гэрээний дагуу эсвэл тогтсон хэвшлийн дагуу үнэт цаасыг зарах эсвэл барьцаанд өгөх эрхтэй тохиолдолд үнэт цаасыг эргэн худалдан авах авлага гэж ангилна. Холбогдох өглөгийг санхүүгийн байдлын тайланд "репо хэлцлүүд" гэж тусад нь толилуулдаг.

Буцаан худалдах хэлцлийн дагуу худалдан авсан үнэт цаас ("урвуу repo хэлцэл") нь зээлдэгчээс Банкинд эргэн төлөлтийг үр дүнтэйгээр хангах бөгөөд бусад Банкнаас авах авлага буюу харилцагчдаас авах зээл ба урьдчилгааны аль тохиромжтойгоор нь бүртгэнэ. Худалдах болон дахин худалдан авах үнийн зөрүүгээр хүүгийн орлого хүлээн зөвшөөрөх ба repo хэлцлийн хугацааны турш үр ашигт хүүний аргаар хуримтлуулна.

4.16 Байшин барилга болон үндсэн хөрөнгө

Барилгыг дор дурьдсанчлан дахин үнэлэгдсэн өртгөөс хуримтлагдсан элэгдлийг, мөн шаардлагатай бол үнэ цэнэ бууралтын зардлыг хассан дүнгээр тусгадаг.

Банкны эзэмшиж буй барилгыг анх өртгөөр нь бүртгэнэ. Үл хөдлөх хөрөнгийн дансны үнэ нь бодит үнээс материаллаг зөрүүтэй эсэхийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлнэ. Дахин үнэлгээнээс нэмэгдсэн дансны үнээр бусад дэлгэрэнгүй орлогыг кредитлэн, өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг нэмэгдүүлнэ. Ижил хөрөнгийн өмнө үүссэн нэмэгдлийг хааж буй дахин үнэлгээний бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөд өмнө хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулна; Бусад бүх бууралтыг тухайн жилийн орлого зарлагад хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийг данснаас хасахад гарсан нэмэгдэл буюу хөрөнгийг Банк ашиглаж буй тохиолдолд өөрийн хөрөнгөд орсон барилга тоног төхөөрөмжийн дахин үнэлгээний нөөцийг хуримтлагдсан алдагдал буюу хуримтлагдсан ашиг руу шууд хаана; сүүлийн тохиолдолд бодит зөрүүгийн хэрэгжсэн өсөлт нь хөрөнгийн дахин үнэлсэн дансны үнээс бодсон элэгдэл болон хөрөнгийн анхны өртгөөс бодсон элэгдлийн зөрүүтэй тэнцэнэ.

Группийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг адил төрлийн үл хөдлөх хөрөнгийг үнэлж байсан туршлагатай хараат бус мэргэжлийн хөрөнгийн үнэлгээний байгууллагаар хийлгэсэн үнэлэлт дээр тулгуурлаж хийнэ. Групп нь 2012 ба түүнээс өмнө ашиглаж байсан өртгийн аргыг 2013 өөрчилж дахин үнэлгээний аргыг үнэлгээндээ ашиглаж эхэлсэн. Дэлгэрэнгүйг тодруулга 3 болон 18-с үзнэ үү.

Банкны эзэмшиж буй тоног төхөөрөмжийг үнэ цэнэ бууралтын алдагдал болон элэгдлийг хассан дүнгээр бүртгэнэ. Бага хэмжээний засварын өртгийг гарсан даруйд нь зарлагадна. Барилгын томоохон хэсэг эсвэл бүрэлдэхүүн хэсгийг шинэчлэхтэй холбоотой гарсан зардлыг капиталжуулж, сольсон хэсгийг ашиглалтаас хасна.

Үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан шинж тэмдэг илэрсэн эсэхийг удирдлага тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Тийм шинж тэмдэг илэрсэн тохиолдолд удирдлага хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн аль ихээр нь нөхөн сэргээгдэх өртгийг тооцож, дансны үнийг нөхөн сэргээгдэх өртөг хүртэл бууруулан гарзыг тухайн жилийн орлого, зарлагад бүртгэдэг (байшин барилгын хувьд өмчийн өмнөх дахин үнэлгээний нэмэгдлийг давах хэмжээгээр). Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ, бодит үнэ цэнэ эсвэл борлуулах зардлын тооцоололд өөрчлөлт орсон бол өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг шаардлагатай бол залруулан бүртгэнэ.

Борлуулсны олз, гарзыг тодорхойлохдоо борлуулалтаас олсон орлогыг бүртгэлийн дүнтэй харьцуулж тооцох бөгөөд олз, гарзыг тухайн жилийн орлого, зарлагад бүртгэнэ (үйл ажиллагааны бусад орлого, зардал хэсэгт).

Дуусаагүй барилгыг элэгдүүлдэггүй. Үндсэн хөрөнгийн бусад зүйлүүдийн элэгдлийг тэдгээрийн өртгийг доорх хүлээгдэж буй ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь бууруулан хуваарилж тооцно:

- Барилга – 40 жил
- Тээврийн хэрэгсэл – 10 жил
- Тавилга – 10 жил
- Тоног төхөөрөмж ба компьютер болон бусад хөрөнгө – 3-10 жил
- Түрээсийн сайжруулалт – Хөрөнгийн ашиглагдах хугацаа болон түрээсийн хугацааны аль богиноор нь

Үлдэх өртөг гэдэг нь тухайн хөрөнгийн ашиглалтын хугацаа дуусах үед хөрөнгийг зарж борлуулах дүнгээс түүнтэй холбоотой гарах зардлыг хассан дүнг урьдчилан тооцоолсон дүн юм. Хөрөнгийн үлдэгдэл өртөг, ашиглагдах хугацааг тайлант үе бүрийн эцэст дахин үнэлж шаардлагатай гэж үзвэл тохируулга хийнэ.

4.17 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэдэг нь удирдлагын зорилгоор эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх зорилгоор ашигладаг, бизнесийн ерөнхий үйл явцад зарагдах бус, түрээсийн орлого ба капиталын өгөөж хүртгэх зорилготой эсвэл тус 2 зорилгыг хоёуланг нь хэрэгжүүлэхээр эзэмшиж буй өмч хөрөнгө юм.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг анх бодит үнэ цэнээр буюу худалдаж авсан үнэ дээр худалдан авахтай холбоотой шууд зардлыг нэмж бүртгэдэг. Дараа нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг тухайн тайлант хугацааны зах зээлийн нөхцөл байдал дээр үндэслэн бодит үнэ цэнээр хэмждэг. Тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг уг үл хөдлөх хөрөнгийн зах зээл дээр худалдагдах үнэ гэж үзнэ. Холбогдох гүйлгээний зардлыг хасахгүй.

Голомт Банк Групп

4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.17 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (үргэлжлэл)

Үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлттэй холбоотой олз гарзыг тухайн олз гарз нь бүртгэгдсэн жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Худалдаж авсны дараах зардлыг зөвхөн тухайн хөрөнгөөс үүдэлтэй Группийн ирээдүйд олох ашиг нь тодорхой болсон болон тухайн зардлыг бодитоор хэмжих боломжтой үед уг хөрөнгийн дансны үнэд нэмж бүртгэнэ. Бусад бүх засвар үйлчилгээтэй холбоотой зардлыг тухайн жилийн ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгийг данснаас хасах эсвэл ашиглалтаас бүр мөсөн хасах үед болон хөрөнгийн ашиглалтаас ирээдүйд өгөөж өгөхгүй бол үл хүлээн зөвшөөрнө. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг данснаас хасах, актласнаас үүсэх олз ба гарз нь тухайн жилдээ орлогын тайланд хүлээн зөвшөөрөгддөг.

Группийн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг адил төрлийн үл хөдлөх хөрөнгийг үнэлж байсан туршлагатай хараат бус мэргэжлийн хөрөнгийн үнэлгээний байгууллагаар хийлгэсэн үнэлэлт дээр тулгуурлаж хийнэ. Групп нь 2012 ба түүнээс өмнө ашиглаж байсан өртгийн аргыг 2013 өөрчилж дахин үнэлгээний аргыг үнэлгээндээ ашиглаж эхэлсэн. Дэлгэрэнгүйг тодруулга 14-өөс үзнэ үү.

4.18 Биет бус хөрөнгө

Группийн биет бус хөрөнгө нь ашиглах тодорхой хугацаатай бөгөөд үндсэндээ капиталжуулсан компьютерийн программ хангамжийн лицензүүд болон газар ашиглах эрх юм. Худалдан авсан компьютерийн программ хангамжийн лицензүүдийг тэдгээрийг худалдан авах үед үүсэх зардал болон ашиглахад бэлэн болгоход гарсан зардлын үндсэн дээр бүртгэдэг. Хэрэв Группийн эзэмшлийн бүх төрлийн программ хангамжын урт хугацааны өгөөж нь зардлаас их байх нь тодорхой бол тухайн программ хангамжыг хөгжүүлсэнтэйхолбоотойзардлыг биет бус хөрөнгө гэж бүртгэнэ. Капиталжих зардалд программыг хөгжүүлсэн ажилчдын зардал болон хамаарах илүү цагийн зардлууд багтана. Компьютерийн программ хангамжтай холбоотой бусад бүх зардлуудыг ашиг алдагдалд зардал гэж хүлээн зөвшөөрнө.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийг шулуун шугамын аргаар эдийн засгийн ашигтай хугацааны турш хорогдуулах ба үнэ цэнэ бууралтын шинэ тэмдэг илэрсэн үед тухайн хөрөнгийн үнэ цэнэ бууралтыг үнэлэнэ. Энэхүү хорогдуулалтын аргачлалыг хамгийн багадаа жил бүрийн тайлант хугацааны эцэст хянаж үздэг. Биет бус хөрөнгийн төлөвлөсөн ашиглагдах хугацааг дараах байдлаар тогтоосон.

- Программ хангамжийн лицензүүд — 3 жил
- Газар ашиглах эрх — газар ашиглах эрхийн хугацаа

4.19 Үйл ажиллагааны түрээс

Групп нь түрээсийн гэрээнд түрээслэгчээр оролцож, өмчлөлийн ихэнх эрсдэл болон урамшуулал нь түрээслүүлэгчээс Групп-д шилжин ирээгүй тохиолдолд түрээсийн нийт төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан хуваарилж тухайн тайлант жилүүдийн орлого, зарлагад (түрээсийн зардлаар) бүртгэнэ.

Хэрэв хөрөнгийг үйл ажиллагааны түрээсээр түрээслүүлсэн тохиолдолд түрээсийн авлагыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар хуваарилан түрээсийн орлогоор бүртгэнэ.

4.20 Хувьцаат капитал болон давуу эрхтэй хувьцаа

Энгийн хувьцаа болон буцаан төлөх, эргэн дуудах нөхцөлгүй давуу эрхтэй хувьцааг эзэмшигчдийн өмч гэж ангилдаг. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбоотой нэмэлт зардлыг хувьцаа борлуулсны татварын дараах орлогоос хасах дүнгээр эзэмшигчдийн өмчид тусгадаг. Хувьцаа борлуулснаас орж ирсэн орлогын бодит үнэ цэнэ нь хувьцааны нэрлэсэн үнээс илүү гарсан хэсгийг нэмэгдэж төлөгдсөн капитал гэж эзэмшигчдийн өмчид тусгадаг.

4.21 Нэмэгдэж төлөгдсөн капитал

Нэмж төлөгдсөн капитал нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнээс давуулан оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

4.22 Ногдол ашиг

Ногдол ашгийг зарласан хугацаанд эзэмшигчдийн өмчид бүртгэнэ. Тайлант үеийн эцсээс хойш, гэхдээ санхүүгийн тайлангуудыг нийтлэхийг зөвшөөрөхөөс өмнө зарлагдсан ногдол ашгийг тайлант хугацааны дараах үйл явдлын тодруулгад оруулан толилуулдаг. Ногдол ашгийн хуваарилалтыг хуримтлагдсан ашгаас олгоно.

4.23 Болзошгүй хөрөнгө ба болзошгүй өр төлбөр

Болзошгүй хөрөнгийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй боловч эдийн засгийн өгөөжийн орох урсгал магадлалтай үед санхүүгийн тайланд нэмж тодруулна.

Төлбөрийг барагдуулахтай холбоотой мөнгөн урсгал гарах магадлалтай бол болзошгүй өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй боловч нэмж тодруулна.

4.24 Зээлтэй холбоотой хүлээсэн үүргүүд

Групп нь санхүүгийн баталгаа болон зээл олгох үүрэг хүлээх үйлчилгээ үзүүлдэг. Санхүүгийн баталгаа нь гуравдагч этгээдэд хүлээсэн үүргээ харилцагч биелүүлж чадаагүй тохиолдолд Банк харилцагчийн өмнөөс төлбөр гүйцэтгэхээр буцалтгүй нөхцлөөр олгосон баталгаа бөгөөд зээлтэй адил зээлийн эрсдэл агуулдаг. Санхүүгийн баталгаа болон зээл олгох үүрэг нь анх бодит үнэ цэнээрээ хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд энэ үнэ цэнэ нь хэвийн үед хүлээн авсан хураамжийн дүнгээр нотлогддог. Уг дүнг хүлээсэн үүргийн хүчинтэй байх хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулан бүртгэдэг.

Энэ арга нь Банк зээл олгох үүрэг хүлээж уг үүргийнхээ дагуу тодорхой зээлийн хэлцэлд оролцох нь магадлалтай бөгөөд уг зээлээ олгосны дараа богино хугацаанд бусад шилжүүлэх төлөвлөгөөгүй тохиолдолд үйлчлэхгүй. Энэ тохиолдолд зээлийн үүргийн хураамжийг хойшлуулж олгосон зээлийн анхны хүлээн зөвшөөрөх дүнд оруулан тооцно. Тайлант үе бүрийн эцэст үүргүүдийг (i) анх хүлээн зөвшөөрсөн тухайн өдрөөрх хорогдуулаагүй дүнгийн үлдэгдэл, (ii) үүргийг тухайн өдөр барагдуулахад шаардагдах зардлын хамгийн баталгаатайгаар тооцоолсон дүнгийн аль ихээр бүртгэнэ. Хураамжуудыг үүргийн үлдэгдэл дүнтэй холбоотойгоор тогтмол давтамжтай тооцдог тохиолдолд тэдгээрийг үүргийн үйлчлэх хугацааны туршид пропорциональ хэмжээгээр орлогод хүлээн зөвшөөрдөг.

4.25 Нөөц

Групп нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн эрх зүйн хувьд эсвэл бодит үндэслэлтэй үүрэг хүлээсэн бөгөөд энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн үнэ цэнэ бүхий эх үүсвэрийг төлөх магадлалтай, мөн уг үүргийн дүнг баталгаатайгаар тооцоолох боломжтой үед нөөц/санг хуримтлуулан байгуулна.

4.26 Засгийн газрын хөнгөлөлтүүд

Монголбанк (Засгийн газрын зуучлагчийн үүргээр оролцож буй)-наас зах зээлээс доогуур хүүтэй авсан зээлийн үр ашгийг засгийн газрын хөнгөлөлтөд тооцно. Энэхүү төрлийн зээлийг зах зээлийн хүүг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжих ба зээлийн бусад эх үүсвэрт хүлээн зөвшөөрнө. Зах зээлийн хүүгээс доогуур хүүний үр ашгийг (өөрөөр хэлбэл, зээлийг анх хүлээн зөвшөөрөхөд гарах ашиг) НББОУС 39-ийн дагуу тодорхойлсон зээлийн анхны дансны үнэ болон хүлээн авсан төлбөрийн зөрүүгээр хэмждэг ба засгийн газрын хөнгөлөлтийн орлогоор хүлээн зөвшөөрдөг. Хөнгөлөлтийн холбогдох орлогыг зээлийн хугацааны турш үр ашигт хүүгийн аргаар ашиг алдагдалд системтэйгээр хүлээн зөвшөөрдөг. Хөнгөлөлтийн орлогыг хүүний зардлаар цэвэршүүлэн бүртгэдэг.

Удирдлагын зүгээс засгийн газрын хөнгөлөлтүүдийн өр төлбөрийн дүн нь материаллаг бус тул тусдаа мөр байх шаардлагагүй гэж үзээд “Зээлээр авсан бусад эх үүсвэр” –н мөрөнд багтаасан.

4.27 Итгэмжлэгдсэн хөрөнгө

Гуравдагч этгээдийн дансанд бүртгэлтэй байгаа Группийн нэр дээрх хөрөнгийг энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланд оруулаагүй. Үүнээс орох шимтгэлийн орлогыг “Хураамж, шимтгэлийн орлого” хэсэгт багтаасан.

4.28 Орлогын албан татвар

Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст бүхэлд нь эсвэл ерөнхийд нь батлагдсан хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө. Орлогын албан татварын зардал нь тухайн жилийн болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн буюу өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл өмчид шууд бүртгэгдсэнээс бусад тохиолдолд тухайн жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрөгдөнө.

Тайлант хугацааны татвар нь тухайн болон өмнөх хугацаанд үүссэн татвар ногдуулах ашиг, алдагдалтай холбоотой татварын байгууллагад төлөх эсвэл түүнээс нөхөн авах дүн болно. Санхүүгийн тайланг холбогдох татварын албанд тушаахаас өмнө баталж амжаагүй тохиолдолд татвар ногдуулах ашиг, алдагдлыг урьдчилан тооцно. Орлогын албан татвараас бусад татваруудыг үйл ажиллагааны зардалд бүртгэдэг.

Голомт Банк Групп

4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд (үргэлжлэл)

4.28 Орлогын албан татвар (үргэлжлэл)

Хойшлогдсон татварыг Балансын өглөгийн аргыг ашиглан дараа тайлант хугацаанд шилжүүлэн тооцох татварын алдагдал дээр мөн санхүүгийн тайлангийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь болон санхүүгийн тайлан дахь бүртгэлийн дүнгийн хооронд үүсэх түр зөрүүн дээр үндэслэж тооцдог.

Хойшлогдсон татвар нь бизнесийн нэгдлээс өөр гүйлгээний явцад анх хүлээн зөвшөөрсөн бөгөөд тухайн үедээ бүртгэлийн ашиг болон татвар ногдох ашигт нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрөөс үүсэх түр зөрүүнүүдэд хүлээн зөвшөөрдөггүй. Хойшлогдсон татварыг хөрөнгө ашиглагдах эсвэл өглөг төлөгдөх тайлант хугацаанд ашиглагдах, санхүүгийн тайлангийн өдрийн байдлаар батлагдсан буюу үндсэндээ батлагдсан байгаа хууль тогтоомжоор тогтоосон татварын хувь хэмжээгээр эсвэл дараа тайлант хугацаанд шилжүүлэн ашиглагдах татварын алдагдлаар тооцдог. Банк хойшлогдсон татварын хөрөнгө болон өглөгийг хооронд нь хааж бүртгэдэг. Хойшлогдсон татварын өглөг нь татвар ногдуулах бүхий л түр зөрүүнд, хойшлогдсон татварын хөрөнгийг татвараас хасагдах бүхий л түр зөрүүнд, мөн ашиглагдаагүй татварын алдагдал, татварын хөнгөлөлтөнд тэдгээрийг ирээдүйн татвар ногдуулах ашигт татвараас хасагдах түр зөрүү, ашиглагдаагүй татварын алдагдал болон хөнгөлөлтийг хасагдуулан ашиглах магадлалтай.

Гадаад валютын арилжааны үүсмэл хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөөгүй олз гарз гэж үздэг ба түр зуурын зөрүү гэж бүртгэдэг (Тодруулга 3 болон 31). Бусад хөрөнгө болон бусад өр төлбөрийн гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зөрүү нь гадаад валютын арилжааны олз гарз гэж үздэг ба энэ нь түр зуурын зөрүү үүсгэдэггүй.

Группийн татварын тодорхой бус байр суурийг удирдлага тайлант үеийн эцэс бүрт дахин үнэлдэг. Группийн орлогын татварын байр суурийг татварын байгууллага хүлээн зөвшөөрөхгүй байж болохоос үүдэн нэмэлт татвар ногдуулах нь ногдуулахгүй байхаас илүү магадлалтай гэж удирдлага үзсэн тохиолдолд өглөг хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн тайлангийн өдрийн байдлаар бүхэлдээ буюу үндсэндээ батлагдсан байсан хууль тогтоомжийн тайлбар, мөн ижил асуудлыг шүүх байгууллагын шийдвэрлэсэн байдал дээр үндэслэн үнэлгээ хийгддэг. Торгууль, алданги болон орлогын бус татвартай холбоотой өглөгийн хувьд тайлант хугацааны эцэс дэх өр төлбөрийг барагдуулахад шаардагдах зардлыг удирдлага хамгийн боломжит аргаар тодорхойлсноор хүлээн зөвшөөрнө.

4.29 Ажиллагсдын тэтгэмж ба нийгмийн халамж

(i) Богино хугацаат тэтгэмж

Цалин, хөлс, бусад цалин хөлстэй холбоотой бусад зардлууд нь Групп болон Банкны ажилтан нь холбогдох ажил үйлчилгээг үзүүлсэн тухайн жилдээ зардлаар хүлээн зөвшөөрөгддөг. Цалинтай ээлжийн амралт зэрэг нөхөн олговортой бусад богино хугацаат хуримтлагдах ажлын чөлөөг ажиллагсад ирээдүйд нөхөн олговортой чөлөө авах эрхийг үүсгэх үйлчилгээг үзүүлсэн үед, нөхөн олговортой богино хугацаат хуримтлагдахгүй ажлын чөлөөг (жишээ нь, өвчний улмаас чөлөө авах) тухайн үед нь хүлээн зөвшөөрдөг.

(ii) Тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй компаниуд хуулийн дагуу улсын тэтгэврийн болоод нийгэм, эрүүл мэндийн даатгалын сангуудад шимтгэл төлдөг. Эдгээр шимтгэлүүдийг үүссэн үед нь орлого, зарлагад зардлаар бүртгэдэг. Групп өөрсдийн байгуулсан тэтгэврийн санд шимтгэл төлдөг. Төлсөн шимтгэлийг ажилтны Групп-д ажилласан хугацаанд нь хувь тэнцүүлэн "Тэтгэврийн сангийн зардал" дансанд бүртгэнэ.

4.30 Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт

Хүүгийн орлого, зардлыг өрийн хэрэгсэл бүрийн хувьд аккруэль суурь дээр үндэслэн үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ аргын дагуу гэрээний талуудын хооронд төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх үнийн нэмэгдэл буюу хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүгийн орлого эсвэл зардалд бүртгэдэг.

Үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэхэд шууд холбоотойгоор нэмэгдэн гардаг, жишээлбэл төлбөрийн чадварыг үнэлэх, зээлийн баталгаа эсвэл барьцааг үнэлэх болон бүртгэх, хэрэглүүрийн нөхцлүүдийг хэлэлцэх болон холбогдох баримт бичиг боловсруулах зэрэг гэрээ байгуулахтай холбоотой аливаа хураамжууд орно. Групп нь харилцагчид зээл олгосны дараах богино хугацаанд тухайн зээлийн худалдах магадлалтай тохиолдолд тухайн зээлийг зах зээлийн хүүгээр олгохтой холбоотой хураамж, шимтгэлийг үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болгон тооцно. Зээл олгохоор хүлээсэн үүргийг Банк ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилдаггүй.

Зээл болон бусад өрийн хэрэгслүүд найдваргүй болсон үед тэдгээрийг хүлээгдэж буй мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ хүртэл бууруулж бүртгэх бөгөөд түүнээс хойш өнөөгийн үнэ цэнийн өсөлтийг тухайн хөрөнгийн үнэ цэнэ бууралтын гарзыг тооцоход ашигласан үр ашигт хүүгийн үндсэн дээр тооцоолж хүүгийн орлогоор бүртгэдэг.

Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлын зүйлүүдийг ерөнхийдөө аккруэль суурь дээр үндэслэн тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт тохирсон үйлчилгээнээс бодитоор үзүүлсэн үйлчилгээний хувь хэмжээгээр тооцдог.

4.31 Өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад хөрөнгө гэдэг нь хугацаа хэтэрсэн зээлийн үүргийг хангуулахаар хураан авсан санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгө (барилга зэрэг үл хөдлөх, машин тоног төхөөрөмж, бараа материал зэрэг хөдлөх, үнэт цаас зэрэг санхүүгийн хөрөнгө)-ийг хэлнэ. Хөрөнгийг анхлан бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх бөгөөд тухайн хөрөнгийн шинж чанар, Группийн сонирхол зэргээс шалтгаалж холбогдох хөрөнгийн бүлэгт хамаарах нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу дахин хэмжиж бүртгэнэ.

Санхүүгийн бус хөрөнгийн хувьд, хэрэв Групп нь хураан авсан барьцаа хөрөнгийг (үл хөдлөх хөрөнгийг) өөрийн бизнесийн үйл ажиллагаанд ашиглах бол уг хөрөнгийг “Байшин барилга ба үндсэн хөрөнгө” гэж дахин ангилан, Байшин барилга ба үндсэн хөрөнгөтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу бүртгэнэ (Тодруулга 4.16). Хэрэв Групп нь хураан авсан барьцаа хөрөнгийг түрээслүүлэх болон үнэ цэнийн өсөлтийн зорилгоор, эсвэл уг 2 тохиолдлын хоёулангийн зорилгоор өөрөө ашиглахгүйгээр хадгалж үлдсэн бол Групп нь уг хөрөнгийг “Өмчлөх бусад хөрөнгө”-өөс “Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө” хэсэг рүү дахин ангилан холбогдох нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу бүртгэнэ (Тодруулга 4.17). Хэрэв Групп нь хураан авсан барьцаа хөрөнгөөр авсан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг худалдах тохиолдолд Групп нь бараа материалтай холбоотой нягтлан бодох бүртгэлийн журмыг баримтлан зөвхөн СТОУС-5 –ын шаардлага биелэн худалдах зорилготой хөрөнгө гэж ангилснаас бусад тохиолдолд уг хөрөнгийг “Өмчлөх бусад хөрөнгө” гэж Санхүүгийн Байдлын Тайланд тусгана. Худалдахаар төлөвлөсөн санхүүгийн бус хураан авсан барьцаа хөрөнгийн талаар тодруулга 19-өөс үзнэ үү.

Хэрэв хураан авсан санхүүгийн хөрөнгө (Үнэт цаас гэх мэт)-ийг худалдснаар анхны үнээ нөхөх бол Группийн зүгээс энэхүү хөрөнгийг “Өмчлөх бусад хөрөнгө” гэж үзэн СТОУС-ын хэмжилтийн дагуу борлуулахад бэлэн үнэт цаас гэж ангилан бодит үнэ цэнээр хэмждэг. Хураан авсан санхүүгийн барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнийг тайлант хугацаа бүрт тооцдог бөгөөд бодит үнэ цэнийн тохируулгыг өмчийн хэсэг дэх Борлуулахад бэлэн үнэт цаасны нөөцөд хүлээн зөвшөөрдөг. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар тодруулга 4.10 –т тусгасан. Хураан авсан санхүүгийн барьцаа хөрөнгийн талаар тодруулга 19-ийг үзнэ үү.

4.32 Бараа материал

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар бүртгэнэ. Цэвэр боломжит үнэ цэнэ нь бизнесийн энгийн нөхцөлд барааг худалдахаар таамаглаж буй үнээс барааг гүйцээх болон худалдахтай холбоотойгоор гарах таамагласан зардлыг хассан дүн.

4.33 Нөхцөл өөрчлөгдсөн зээлүүд

Групп барьцаа хөрөнгийг хураан авахаасаа илүү аль болох төлбөр хийх хугацааг сунгах, зээлийн нөхцлийг шинээр тохиролцох зэрэг замаар зээлийн нөхцлийг өөрчлөх боломжийг хайдаг. Нөхцлүүдийг дахин хэлэлцэн тохиролцсоны дараа тухайн зээлийг хугацаа хэтэрсэнд ангилдаггүй. Удирдлага нөхцөл өөрчлөгдсөн зээлүүдийг үргэлж эргэн шалгаж, бүх шалгуурууд биелэгдсэн эсэх, ирээдүйд орж ирэх төлбөрүүд төлөгдөх магадлалтай эсхийг авч үздэг. Эдгээр зээлүүдийг мөн цаашид ч тэдгээрийн анхны үр ашигт хүүг ашиглан дан ганцаар нь эсвэл бүлгийн үнэлгээгээр нь үнэ цэнийн бууралтын хувьд шинжилдэг.

4.34 Хувьцаанд суурилсан төлбөрүүд

Хувьцаанд суурилсан төлбөр оролцуулсан ажил гүйлгээний хүрээнд хүлээн авсан буюу худалдаж авсан үйлчилгээг Банк тухайн үйлчилгээг хүлээн авсан үед хүлээн зөвшөөрдөг. Хэрэв хувьцаанд суурилсан бөгөөд хувьцаагаар төлөх төлбөр оролцуулсан ажил гүйлгээний хүрээнд үйлчилгээ хүлээн авсан бол эзэмшигчдийн өмчийг нэмэгдүүлэн бүртгэдэг, харин хувьцаан дээр суурилсан бөгөөд мөнгөөр төлөх төлбөр оролцуулсан ажил гүйлгээний хувьд өглөгийг нэмэгдүүлэн бүртгэдэг.

Хувьцаанд суурилсан бөгөөд хувьцаагаар төлөх төлбөр оролцуулсан ажил гүйлгээний хувьд Банк хүлээн авсан үйлчилгээ болон эзэмшигчдийн өмчийн холбогдох өсөлтийг олгосон хувьцааны бодит үнэ цэнэ дээр үндэслэн шууд бус аргаар тооцно. Хувьцаанд суурилсан бөгөөд мөнгөөр төлөх төлбөр оролцуулсан ажил гүйлгээний хувьд Банк хүлээн авсан үйлчилгээ болон үүссэн өр төлбөрийг уг өр төлбөрийн бодит үнээр хэмжинэ. Өр төлбөр барагдаж дуусал Банк тайлант үе бүрийн эцэст болон өр төлбөр барагдаж дуусах өдөр тухайн өр төлбөрийн бодит үнэ цэнийг дахин үнэлэх ба дахин үнэлгээнээс үүсэх бодит үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг тухайн үеийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрдөг.

4.35 Санхүүгийн тайлангуудыг нийтэлсний дараа хийгдэх өөрчлөлтүүд

Банкны удирдлага болон хувьцаа эзэмшигчид санхүүгийн тайлангуудыг нийтэлсний дараа өөрчлөх эрх мэдэлтэй болно.

Группийн хувьд дараах шинэ стандарт болон тайлбаруудыг хэрэгжилт нь 2015 оны 01 дүгээр сарын 01-ээс хүчинтэй:

НББОУС 19-д орсон нэмэлт өөрчлөлтүүд — “Тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө: Ажилчдын төлсөн шимтгэл” (2013 оны 11 сард батлагдсан ба 2014 оны 07 дугаар сарын 01-нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөнө). Хэрвээ ажилчдын төлсөн шимтгэл нь ажиллах хугацаатай хамааралгүй бол ажиллах хугацаанд хуваарилахгүйгээр ажилтан ажил үүргээ гүйцэтгэсэн хугацаанд ажил олгогчоос гарсан үйлчилгээний өртгийг бууруулж болно гэж заасан. Банкны Удирдлагууд эдгээр өөрчлөлтүүд нь Группийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна

СТОУС-уудад жил бүр хийгддэг сайжруулалтууд 2012 (2013 оны 12 сард батлагдсан ба доорх мөрөнд өөрөөр заагаагүй бол 2014 оны 07 дугаар сарын 01-нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөнө). Сайжруулалтад нийтдээ 7 стандарт хамрагдсан.

СТОУС 2-т “баталгаажих нөхцөл” гэдгийг “гүйцэтгэлийн нөхцөл” болон ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл гэж салгаж нарийн тодорхойлсон. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөх тохиолдолд хувьцаанд суурилсан төлбөрийн гүйлгээ хийхийг зөвшөөрсөн өдөр нь 2014 оны 07 дугаар сарын 01-нээр эсвэл түүнээс хойшхи өдөр байна.

СТОУС 3-д дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд: 1) НББОУС 32-ын тодорхойлолтын үндэслэлийн дагуу санхүүгийн хэрэгслийн тодорхойлолтыг хангаж байгаа санхүүгийн өр төлбөр эсвэл өмчөөр ангилсан, болзошгүй өр төлбөрийн төлбөр хийх үүрэг; 2) санхүүгийн болон санхүүгийн бус, өмчийн хэрэгслээр төлөгдөхгүй болзошгүй төлбөрийг тайлант үе бүрээр бодит үнэ цэнээр хэмжиж бодит үнэ цэнийн зөрүүг тайлант үеийн ашиг алдагдалд бүртгэнэ. СТОУС 3-д орсон нэмэлт өөрчлөлтийг зөвхөн 2014 оны 07 дугаар сарын 01-нээрх болон түүнээс хойшхи хугацаанд үүссэн бизнесийн нэгдэлд дагаж мөрдөнө.

СТОУС 8-д дараах нэмэлт өөрчлөлтүүд орсон. Үүнд: 1) Нэгтгэсэн үйл ажиллагааны сегментүүдийн нэр мөн нэгтгэх үндэслэл болох тухайн сегментүүд нь ижил төрлийн эдийн засгийн шинж чанартай гэдгийг нотлох эдийн засгийн үзүүлэлт зэргийг багтаасан үйл ажиллагааны сегментийг нэгтгэх удирдлагын үнэлэлт болон шийдвэр гаргалтын талаар тодруулах шаарлагатай болсон; Сегментийн хөрөнгийг тайлагнасан тохиолдолд сегментийн хөрөнгийг аж ахуйн нэгжийн хөрөнгөтэй тааруулсан хүснэгт; СТОУС 13 гарахад НББОУС 39-өөс цөөн тооны мөр арилгасанаар үнэ цэнийг нь хорогдуулахад үүсэх нөлөө нь материаллаг бус бол богино хугацаат авлага болон өглөгийг нэхэмлэхийн үнээр хэмжиж болох боломжтой гэдгийг хасаагүй гэдгийг тодруулсан.

НББОУС 16 болон НББОУС 38-д орсон нэмэлт өөрчлөлтөөр, аж ахуйн нэгж дахин үнэлгээний загвар ашиглаж байгаа үед дансны нийт дүн болон хуримтлагдсан элэгдлийг хэрхэн авч үзэх талаар нарийн тодорхой зааж өгсөн.

НББОУС 24-д орсон нэмэлт өөрчлөлтөөр тайлан гаргагч аж ахуйн нэгжид удирдлагын үйлчилгээ үзүүлсэн эсвэл тайлан гаргагч аж ахуйн нэгжийн толгой компанид удирдлагын үйлчилгээ үзүүлсэн бол удирдлагын үйлчилгээ үзүүлэгч компаниас авсан үйлчилгээний шимтгэлийг холбоотой талуудын тодруулгад тусгана. Групп нь дээрх шинэ стандартуудын санхүүгийн тайланд нөлөөлөх байдлыг үнэлж байгаа.

СТОУС-уудад жил бүр хийгддэг сайжруулалтууд 2013 (2013 оны 12 сард батлагдсан ба 2014 оны 07 дугаар сарын 01-нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Сайжруулалтад нийтдээ 4 стандартын өөрчлөлт багтсан.

СТОУС 1-ийн дүгнэлт гаргах үндэслэл хэсэгт стандартын шинэ хувилбар гарсан бөгөөд дагаж мөрдөх шаардлагагүй ч хугацаанаас нь өмнө хэрэглэх боломжтой бол стандартыг анх удаа хэрэглэж байгаа хэрэглэгч хуучин эсвэл шинэ хувилбарыг хэрэглэж болно гэхдээ толилуулсан тайлангийн хугацаанд адилхан стандарт хэрэглэсэн байна гэж заасан.

СТОУС 11-ийн дагуу хамтарсан хэлцэл бий болох үеийн бүртгэлийг СТОУС 3-аар бүртгэхгүй гэж заасан. Хамтарсан хэлцлийн санхүүгийн тайланд бизнесийн нэгдлийн бүртгэлийг хэрэглэхгүй болохыг мөн дээрх нэмэлт өөрчлөлтөөр зааж өгсөн.

СТОУС 13-д орсон нэмэлт өөрчлөлтөөр, СТОУС 9 эсвэл НББОУС 39-д хамаарагдах бүх гэрээтэй (санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрийг худалдах болон худалдан авах хэлцэл мөн хамаарна) холбоотой санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бүлгийн бодит үнэ цэнийг цэврээр нь хэмжиж болно гэж заасан.

НББОУС 40-д НББОУС 40 болон СТОУС 3-ыг зэрэг хэрэглэх боломжтой гэж нэмэлт өөрчлөлт оруулсан. НББОУС 40-өөр санхүүгийн тайланг бэлтгэгчдэд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө болон өмчлөгч нь эзэмшиж буй хөрөнгийн ялгааг хэрхэн гаргах талаар заавар өгсөн. Санхүүгийн тайланг бэлтгэгч нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг худалдан авах нь СТОУС 3- бизнесийн нэгдлийг үүсгэж буй эсэхийг нягтална. Групп нь дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг дүгнэж байгаа.

6 Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан мэдэгдлүүд

2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш эхлэх тайлант хугацаанд заавал мөрдөх стандартууд ба тайлбарууд шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн ба эдгээрийг Банк хугацаанаас өмнө хэрэгжүүлж эхлээгүй.

СТОУС 9, “Санхүүгийн хэрэглүүр: Ангилал ба хэмжилт” (2014 оны 07 сард нэмэлт өөрчлөлт оруулсан ба 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс эхэлсэн болон үүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Энэхүү стандартын гол агуулгаас дурьдвал:

- Санхүүгийн хөрөнгүүдийг дараагийн тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр нь хэмжих, бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бүртгэгдэх бодит үнэ цэнээр нь хэмжих болон тайлант үеийн ашиг алдагдалд бодит үнэ цэнийн зөрүү нь бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүд гэж 3 ангилна.
- Өрийн хэрэгслийг ангилах нь аж ахуйн нэгжийн санхүүгийн хөрөнгийг удирдах бизнесийн модел болон гэрээнд заасан мөнгөн гүйлгээ нь зөвхөн үндсэн зээл болон хүүгийн төлбөр байх эсэхээс хамаарна. Хэрэв өрийн хэрэгсэл нь зөвхөн үндсэн зээл болон хүүгийн төлбөрийг авах зорилготой байвал хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Хэрэв аж ахуйн нэгж нь өрийн хэрэгслийг үндсэн зээлийн төлбөр болон хүүг авах мөн шаардлагатай тохиолдолд зарах зорилгоор эзэмшиж байвал бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бүртгэгдэх бодит үнэ цэнээр нь хэмжих санхүүгийн хөрөнгө гэж ангилна. Үндсэн зээл болон хүүгийн төлбөрийн мөнгөн гүйлгээгүй санхүүгийн хөрөнгийг тайлант үеийн ашиг алдагдалд бодит үнэ цэнийн зөрүү нь бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүд гэж ангилна (жишээ нь дериватив). Нуугдмал деривативыг санхүүгийн хөрөнгөөс салгаж үзэхгүй болсон ба зөвхөн үндсэн зээл болон хүүгийн төлбөрийн нөхцлийг хангаж буй эсэхийг үнэлнэ.
- Бүх өмчийн хэрэгслийг дараагийн тайлант үеүдэд үргэлж бодит үнэ цэнээр хэмжинэ. Хэрэв санхүүгийн хөрөнгийг арилжаалах зорилгоор эзэмшээгүй бол бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бүртгэгдэх ангилалын сонголтыг хийж болох ба энэ сонголтыг буцаах боломжгүй. Хэрэв өмчийн хэрэгслийг арилжаалах зорилготой бол тайлант үеийн ашиг алдагдалд бодит үнэ цэнийн зөрүүг нь бүртгэнэ.
- НББОУС 39-д заасан санхүүгийн өр төлбөрийн ангилал болон хэмжилтийн ихэнх шаардлагууд нь СТОУС 9-д шилжихдээ өөрчлөгдөөгүй. Гол өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бүртгэгдэх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөрийн зээлийн эрсдлийн тайланд өөрчлөлтийн нөлөөний талаар тусгах шаардлагатай гэж заасан.
- СТОУС 9-д үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөх шинэ загвар болох ирээдүйд учирч болох зээлийн гарзны загварыг нэвтрүүлсэн. Эхний хүлээн зөвшөөрөлтөөс хойш санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарт гарах өөрчлөлтөд үндэслэсэн “3 үе шат”-ны арга байна гэж заасан. Практикийн хувьд шинэ аргаар үнэ цэнэ нь буураагүй санхүүгийн хөрөнгийг (дансны авлагын хувьд авлага хаагдах хүртэл буюу хугацаанд үндэслэхгүйгээр учирч болох эрсдлийн гарзны сан байгуулна) анх хүлээн зөвшөөрөхдөө ирэх 12 сард учирч болох зээлийн гарзыг тэр даруйд нь хүлээн зөвшөөрнө гэж заасан. Зээлийн эрсдэлд томоохон сөрөг өөрчлөлт гарсан тохиолдолд 12 сарын биш хугацаагүй учирч болох зээлийн гарзны сан байгуулна. Энэхүү загварт түрээс болон дансны авлагыг арай энгийн байдлаар авч үзсэн.
- Хэйджийн бүртгэлийг аж ахуйн нэгжийн эрсдлийн удирдлагатай уялдахуйц байхаар нэмэлт өөрчлөлт оруулсан. СТОУС 9-д макро хейджийг хэрхэн бүртгэх талаар тусгаагүй тул СТОУС 9-ийн хэйджийн бүртгэл эсвэл НББОУС 39-ийн хэйджийн бүртгэлийг үргэлжлүүлэн ашиглах талаар нягтлан бодох бүртгэлдээ тусгах сонголтыг аж ахуйн нэгжид үлдээсэн.

Групп шинээр гарсан стандартуудын санхүүгийн тайланд нөлөөлөх байдлыг үнэлж байгаа хэдий ч СТОУС 9-ийн хэрэгжилт нь ихэнх санхүүгийн байгууллагуудад нөлөөлнө.

СТОУС 11-д орсон нэмэлт өөрчлөлт – Хамтарсан үйл ажиллагаан дахь ашиг сонирхолыг эзэмших ажил гүйлгээг бүртгэх (2014 оны 05 дугаар сарын 06-нд батлагдсан ба 2016 оны 01 сарын 01 нээр эхлэж буй болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Энэхүү өөрчлөлтөөр бизнесийн үйл ажиллагаа үүсгэж байгаа хамтарсан хэлцэл дэх ашиг сонирхолын эзэмшлийг хэрхэн бүртгэх талаар зааж өгсөн. Групп дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг дүгнэж байгаа.

НББОУС 16 болон НББОУС 38-д орсон нэмэлт өөрчлөлт- Элэгдэл болон хорогдлыг тооцох аргыг илүү тодорхой болгох нь (2014 оны 05 дугаар сарын 12-нд батлагдсан ба 2016 оны 01 дугаар сарын 01 нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Энэхүү өөрчлөлтөөр хөрөнгийг ашиглаж буй үйл ажиллагаанаас бий болсон орлогод тухайн хөрөнгийн эдийн засгийн үр өгөөжийн ашиглалтаас гадна өөр бусад хүчин зүйлс нөлөөлсөн байдаг тул нь орлогод суурилсан аргаар үндсэн хөрөнгийг элэгдүүлэх нь тохиромжгүй гэж НББОУС-ын зөвлөл оруулж өгсөн. Групп дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг дүгнэж байгаа.

СТОУС 14, Зохицуулалтын хойшлогдсон дансууд (2014 оны 01 дүгээр сард батлагдсан ба 2016 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). СТОУС 14-т зааснаар уг стандартыг анх удаа хэрэглэж байгаа хэрэглэгч өмнөх нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын шаардлагад нийцсэн үнэ зохицуулалттай холбоотой дүнг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрч болно гэж заасан. Гэсэн хэдий ч СТОУС-ыг нэвтрүүлсэн болон дээрх дүнг хүлээн зөвшөөрөөгүй бусад аж ахуйн нэгжтэй харьцуулж болохуйц байлгах үүднээс, СТОУС 14-т үнэ зохицуулалтын нөлөөллийг бусад бүлгээс тусад нь толилуулна гэж заасан. СТОУС-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэдэг аж ахуйн нэгж уг стандартыг хэрэглэх боломжгүй.

СТОУС 15, Харилцагчтай байгуулсан гэрээний орлого (2014 оны 05 дугаар сарын 28-нд батлагдсан ба 2017 оны 01 дүээр сарын 01-нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Шинэ стандартаар бараа, ажил үйлчилгээг харилцагчид шилжүүлсэн үед ажил гүйлгээний үнээр орлогыг заавал хүлээн зөвшөөрнө гэсэн үндсэн зарчмыг танилцуулсан. Салгаж болохуйц багцын бараа, ажил үйлчилгээний орлогыг салгаж бүртгэнэ, гэхдээ гэрээний хөнгөлөлт, урамшуулалыг холбогдох зүйлд нь заавал хуваарилж бүртгэнэ гэж заасан. Харилцагчтай байгуулсан гэрээний эрсдлийг бууруулахтай холбоотой гарсан зардлыг капиталжуулж гэрээний орлого олох хугацаанд хорогдуулна. Групп дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг дүгнэж байгаа.

НББОУС 16 болон НББОУС 41-д орсон нэмэлт өөрчлөлт - Хөдөө аж ахуй: Биологийн хөрөнгө (2014 оны 6 дугаар сарын 30-нд батлагдсан ба 2016 оны 01 дүээр сарын 01-нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Усан үзмийн мод, резины мод болон тосны мод нь үйлдвэрлэлийн шинж чанартай тул үндсэн хөрөнгөөр бүртгэнэ гэж нэмэлт өөрчлөлт оруулсан. Тиймээс дээрх өөрчлөлтийг НББОУС 16-д оруулж НББОУС 41-ээс хассан. Гэхдээ биологийн ургамалыг ургуулах хугацаанд НББОУС 41-ийг баримтална. Банк дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг дүгнэж байгаа.

НББОУС 27-д орсон нэмэлт өөрчлөлт-Бие даасан санхүүгийн тайлан дахь өмчийн арга (2014 оны 08 дугаар сарын 12-нд батлагдсан ба 2016 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр аж ахуйн нэгж нь бие даасан санхүүгийн тайландаа охин компани, хараат компани, хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтыг өртгийн аргаар бүртгэх боломжтой болсон. Банк дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг дүгнэж байгаа.

СТОУС 10 болон НББОУС 28-д орсон нэмэлт өөрчлөлтүүд- Хөрөнгө оруулагч, түүний хараат компани болон хамтарсан үйлдвэрийн хооронд хөрөнгө борлуулах болон хандивлах (2014 оны 09 дүгээр сарын 11-нд батлагдсан ба 2016 оны 01 дүгээр сарын 01 нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Хөрөнгө оруулагч, түүний хараат компани болон хамтарсан үйлдвэрийн хооронд хөрөнгө борлуулах болон хандивлах ажил гүйлгээг хэрхэн бүртгэх талаар СТОУС 10 болон НББОУС 28-д ялгаатай байдлаар тусгасан байдлыг арилгахад чиглэгдсэн. Өөрчлөлтийн үр дүнд, хөрөнгө борлуулах эсвэл хандивлах ажил гүйлгээ нь бизнесийн шинж чанартай бол олз, гарзыг нийт дүнгээр хүлээн зөвшөөрнө гэж заасан. Бизнесийн үйл ажиллагаанд ашиглагддаггүй хөрөнгийг хараат компани эзэмшиж байсан ч хөрөнгө борлуулах болон хандивлах ажил гүйлгээний олз, гарзыг хэсэгчлэн хүлээн зөвшөөрнө. Банк дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг дүгнэж байгаа.

СТОУС 2014-үүдэд жил бүр хийгддэг сайжруулалтууд- (2014 оны 09 дүгээр сарын 25-нд батлагдсан ба 2016 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн тайлангуудад дагаж мөрдөнө). Дээрх өөрчлөлтөд 4 стандарт хамрагдсан. СТОУС 5-д, ашиглах эрхийг шилжүүлэх хэлбэр өөрчлөгдсөн (жнь борлуулах ангилалаас эздэд хуваарилах ангилалд шилжүүлэх эсвэл эсрэгээрээ) нь уг хөрөнгийг зарж борлуулах эсвэл эздэд хуваарилах төлөвлөгөөг өөрчилсөн гэж үзэхгүй бөгөөд тийм байдлаар бүртгэхгүй гэж нэмж дэлгэрүүлж өгсөн. СТОУС 7-ын тодруулгын шаардлагын дагуу, шилжүүлсэн санхүүгийн хөрөнгөтэй холбоотой гэрээний нөхцлүүдэд шилжүүлэгчийн зүгээс цаашид уг санхүүгийн хөрөнгөтэй холбоотой оролцоо байгаа эсэхийг удирдлага тодорхойлоход илүү дөхөмтэй болгосон. НББОУС 34-өөр шаардаагүй тохиолдолд, завсрын тайлангуудад СТОУС 7-ийн дагуу санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг цэвэршүүлж толилуулахгүй байх боломжтой гэж заасан. НББОУС 19-д орсон нэмэлт өөрчлөлтөөр ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн өр төлбөрийг хорогдуулах хүүгийн түвшин тодорхойлохдоо өндөр зэрэглэлтэй байгууллагын гаргасан бонд, эсвэл уг бонд байхгүй бол засгийн газрын бондын хүүг авахдаа уг өрийн хэрэгслийг гаргасан улсын валют биш тухайн өрийн хэрэгсэл гарсан валютаарх өрийн хэрэгслийн хүүг суурь болгоно гэж заасан. НББОУС 34 –ийн дагуу “завсрын санхүүгийн тайлан мэдээнд толилуулсан мэдээ” гэж бичихдээ санхүүгийн тайлангаас тухайн мэдээлэл байгаа хэсгийг зааж өгнө гэж нэмж оруулсан. Групп нь дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг дүгнэж байгаа.

НББОУС 1-д орсон санхүүгийн тайлангийн толилуулгатай холбоотой нэмэлт өөрчлөлт (2014 оны 12 дугаар сард батлагдсан ба 2016 оны 01 дүгээр сарын 01 нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Өөрчлөлтөөр материаллаг байдал гэсэн ойлголтыг дэлгэрүүлж дараах байдлаар тайлбарласан: СТОУС-ын дагуу тодруулах шаардлагатай тусгай зүйлсийн жагсаалтад орсон эсвэл хамгийн багадаа тухайн зүйлийг тодруулна гэж заасан байсан ч хэрэв тухайн тодруулгаар харуулсан мэдээлэл нь материаллаг бус бол СТОУС-ын дагуу заавал толилуулах шаардлагатай зүйлсийг ч тодруулахгүй байж болно гэж заасан. Мөн, стандартаар санхүүгийн тайлан дахь дэд бүлгийн нийт дүнгийн талаар шинэ заавар өгсөн. Үүнд: (i) дэд бүлгийн нийт дүнг бүрдүүлж буй зүйлс нь СТОУС-ын дагуу хэмжигдэж хүлээн зөвшөөрөгдсөн байх; (ii) дэд бүлгийн тоог бүрдүүлж буй зүйлсийн нэрсийг тусгаж, харахад ойлгомжтой цэвэрхэн байдлаар толилуулна; (iii) тайлант үеүдэд толилуулах байдлыг тууштай хадгалах; (iv) СТОУС-ын дагуу дэд бүлгийг бүрдүүлж буй зүйлсэд дэд бүлгийн нийт дүн болон үндсэн бүлгийн нийт дүнгээс илүү ач холбогдол өгөхгүйгээр толилуулах. Групп нь дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг дүгнэж байгаа.

СТОУС 10, СТОУС 12 болон НББОУС 28-д орсон нэгтгэл хийхээс чөлөөлөгдөх нэмэлт өөрчлөлт (2014 оны 12 дугаар сард батлагдсан ба 2016 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн тайланд дагаж мөрдөнө). Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхэлдэг охин компаниа тайлант үеийн ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжинэ гэж нэмэлт өөрчлөлт оруулсан. Мөн, хэрэв охин компанийн эцсийн эсвэл дундын толгой компани олон нийтийн хүртээл болгох нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг бол нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахаас чөлөөлөгдөнө гэснийг охин компанийн эцсийн болон дундын толгой компанийн санхүүгийн тайландаа охин компанийг нэгтгэсэн эсвэл СТОУС 10-ын дагуу тайлант үеийн ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр охин компанийг бүртгэсэн эсэхээс үл хамааран

нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхээс чөлөөлөгдөнө гэж нарийн тодорхойлж өгсөн. Групп нь дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг дүгнэж байгаа.

СТОУС 16, Түрээс (2016 оны 01 дүгээр сард батлагдсан ба 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэх болон түүнээс хойшхи санхүүгийн жилүүдэд дагаж мөрдөнө). Уг стандарт нь НББОУС 17 “Түрээс”, ОУСТХ 4 “Хэлцэлд түрээсийн шинж чанар агуулагдсан эсхийг тодорхойлох”, СТХ 15 “Үйл ажиллагааны түрээс - Урамшуулал” болон СТХ 27 “Түрээсийн хууль эрх зүйтэй холбоотой гүйлгээний агуулгыг дүгнэх” зэрэг стандартуудыг орлоно. Групп нь дээрх шинэ стандарт нь санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг дүгнэж байгаа.

НББОУС 12-ийн өөрчлөлтүүд – Хэрэгжээгүй гарзаас үүдэлтэй хойшлогдсон татварын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт (2016 оны 01 дүгээр сард батлагдсан ба 2017 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн жилүүдэд дагаж мөрдөнө). Уг өөрчлөлт нь өрийн хэрэглүүрийн хэрэгжээгүй гарзаас үүдэлтэй хойшлогдсон татварын хөрөнгийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх шаардлага, нөхцөлүүдийг тодорхойлж өгсөн.

Аж ахуйн нэгж нь тус санхүүгийн хэрэглүүрийг дуусгавар хугацаа нь хүртэл эзэмшихээр төлөвлөж байгаа, мөн уг санхүүгийн хэрэглүүрийг буцаан худалдахад ямар нэгэн татвар төлөхгүй нөхцөлтэй хэдий ч ирээдүйн мөнгөн урсгалыг зах зээлийн хүүгээр дискаунтчилан гаргасан хэрэгжээгүй гарзтай холбоотой хойшлогдсон татварын хөрөнгийг бүртгэнэ. Уг хойшлогдсон татварын хөрөнгөөс үүсэлтэй эдийн засгийн өгөөж нь тухайн өрийн хэрэглүүрийн эзэмшигч ирээдүйд тус хэрэглүүрээс олох олз (хямдруулалтын нөлөөллөөс) дээр татвар төлөхгүйд оршино. Групп нь дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг дүгнэж байгаа.

НББОУС 7-д орсон санхүүгийн тайлангийн толилуулгатай холбоотой нэмэлт өөрчлөлт (2016 оны 01 дүгээр сарын 29-нд батлагдсан ба 2017 оны 01 дүгээр сарын 01-нээрх болон түүнээс хойшхи санхүүгийн жилүүдэд дагаж мөрдөнө). Уг өөрчлөлтөд санхүүгийн үйл ажиллагаанаас үүдэлтэй өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулгын талаар тодруулах шаардлагатай гэж заасан. Групп нь дээрх нэмэлт өөрчлөлтийн санхүүгийн тайлангуудад нөлөөлөх байдлыг дүгнэж байгаа.

7 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө (зайлшгүй байлгах нөөцөөс бусад)

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Бэлэн мөнгө	91,866,379	100,664,369	91,801,377	100,567,560
Монголбанкинд байршуулсан мөнгө (заавал байлгах нөөцөөс бусад)	66,322,910	456,471,258	66,322,910	456,471,258
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	158,189,289	557,135,627	158,124,287	557,038,818

Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгөн (заавал байлгах нөөцөөс бусад) хөрөнгө нь барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй. 2015 оны 12 дугаар сарын 31 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тус хөрөнгийн дүнд хугацаа хэтэрч, эсвэл үнэ цэнэ буурсан дүн байхгүй. Монголбанк нь Мүүди’с-ийн В2 үнэлгээтэй.

Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгөн (заавал байлгах нөөцөөс бусад) хөрөнгийн валют, хүү болон дуусах хугацааны шинжилгээг Тодруулга 34-с үзнэ үү.

Мөнгөн гүйлгээний тайланд тусгасан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан хөрөнгө (Тодруулга 7)	158,189,289	557,135,627	158,124,287	557,038,818
Бусад Банкуудад байршуулсан хөрөнгө (Тодруулга 10)	149,605,676	267,284,933	149,605,676	267,284,933
Монголбанкны үнэт цаас (Тодруулга 13)	424,454,647	209,591,218	424,454,647	209,591,218
Засгийн Газрын бонд (Тодруулга 13)	-	9,726,628	-	9,726,628
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	732,249,612	1,043,738,406	732,184,610	1,043,641,597

Голомт Банк Групп

8 Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц

	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Мянган төгрөгөөр		
Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц	260,739,412	278,718,087
Монголбанкинд байршуулсан заавал байлгах нөөц	260,739,412	278,718,087

Банк нь Төв Банк буюу Монголбанкн дахь харилцах дансандаа Монголбанкнаас тавьдаг шаардлагын дагуу зайлшгүй байлгах нөөц байршуулдаг. Төв Банкн дахь байршуулдаг хөрөнгийн үлдэгдэл нь 14 хоногийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн 12.0% (2014: 12.0 %) -аас багагүй байдаг. Группийн болон Банкны заавал байлгах нөөцийн дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

9 Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгө

Хөрөнгийн биржид арилжаалагддаг бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгүүд нь Хонг Конг, Торонто болон Нью Йоркийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй өмчөөрх хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

2015 оны 12 дугаар сарын 31 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ны байдлаарх бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх санхүүгийн хөрөнгийн өөрчлөлтийг доороос харна уу:

	Групп		Банк	
	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Мянган төгрөгөөр				
1 сарын 1-нээрх бодит үнэ цэнэ	227,942	184,554	227,942	184,554
Худалдаж авсан	8,629,537	99,218	8,597,177	99,218
Худалдсан	(693,695)	-	(693,695)	-
Гадаад валютын ханшийн зөрүүгийн нөлөө	282,309	159,142	282,309	159,142
Бодит үнэ цэнийн тохируулга	(3,003,695)	(214,972)	(3,003,695)	(214,972)
12 сарын 31-нээрх бодит үнэ цэнэ	5,442,398	227,942	5,410,038	227,942

Эдгээр үнэт цаасыг нийтэд нээлттэй зах зээлийн мэдээлэл (харьяалагдах хөрөнгийн биржээс) дээр үндэслэн бодит үнэ цэнээр бүртгэдэг тул Групп эдгээр үнэт цаасны үнэ цэнэ бууралтын шинж тэмдгийг хянадаггүй.

Банк 2015 онд Нью Йоркийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Туркуаз Хилл Ресурс ХК-ны хувьцааг 4,408 мянган ам.доллараар худалдаж авсан. Банк нь тайлант жилд эдгээр хувьцааны зах зээлийн үнийн өөрчлөлтөөс үүссэн 2,878,574 мянган төгрөгийн алдагдлыг хүлээн зөвшөөрсөн.

10 Бусад банкуудад байршуулсан хөрөнгө

	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Мянган төгрөгөөр		
Бусад банкууд дахь харилцах данс		
Дотоод	14,294,479	12,050,621
Гадаад	334,909,197	179,606,349
Богино хугацаат хөрөнгө		
Дотоод	-	75,658,290
Гадаад	-	-
Бусад банкуудад анх 3 сараас их хугацаагаар байршуулсан хөрөнгө	30,329	608,921
Нийт бусад банкуудад байршуулсан хөрөнгө	349,234,005	267,924,182

Бусад гадаадын банкууд дахь харилцах дансанд гадаадын банкнаас авсан зээлийн барьцаа болох 100 сая ам.доллар багтсан (тодруулга 22, 36) ба үүнээс бусад банкуудад байршуулсан хөрөнгө нь барьцаалагдаагүй. Зээлийн эрсдэлийн чанарын тодруулгад эдгээр банкуудын үнэлгээг Стандарт ба Пүүрсийн үнэлгээгээр эсвэл бусад Мүүди'с болон Фитчийн үнэлгээг Стандарт ба Пүүрсийн ойлцоох зэрэглэл рүү хөрвүүлсэн зээлийн эрсдэлийн чанарыг дор үзүүлэв:

	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Мянган төгрөгөөр		
Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй		
AA	72,182,743	-
AA-	1,559,383	57,294,804
A+	13,117,265	7,985,477
A	19,186,352	74,676,504
A-	246,998	25,151,220
BBB+	214,492,075	4,426,915
BBB	438,100	3,626,232
BBB-	138,566	-
BB+	-	245,882
BB	2,416,949	3,756,909
B+	-	88,779,886
B	14,261,918	-
Зэрэглэл хийгдээгүй	11,193,656	1,980,353
Нийт хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй	349,234,005	267,924,182

Бусад банкуудад байршуулсан зэрэглэл хийгдээгүй хөрөнгө нь дунд хэмжээтэй Монгол болон гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө юм. Удирдлагын зүгээс зэрэглэл хийгдээгүй банкуудад байршуулсан хөрөнгийг тухайн банкны нэр хүнд болон бусад олон нийтэд нээлттэй мэдээллийг (олон нийтэд нээлттэй санхүүгийн тайлан гэх мэт) ашиглан үнэлсэн.

Бусад банкуудад байршуулсан хөрөнгийн валют, хүү болон дуусах хугацааны шинжилгээг Тодруулга 34-с үзнэ үү.

Группийн болон Банкны дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

11 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Мянган төгрөгөөр		
Бизнесийн зээл	1,205,437,537	1,164,191,875
Жижиг дунд бизнесийн зээл	461,558,818	554,558,265
Хувь хүнд олгосон хэрэглээний зээл	194,024,822	197,177,121
Хувь хүнд олгосон орон сууцны зээл	247,684,064	622,974,437
Харилцагчдад олгосон нийт зээл ба урьдчилгаа	2,108,705,241	2,538,901,698
Хасах нь: Зээлийн үнэ цэнэ бууралтын сан	(95,094,454)	(76,981,660)
Харилцагчдад олгосон нийт зээл ба урьдчилгаа	2,013,610,787	2,461,920,038

2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 30 том зээлдэгчдэд олгосон зээлийн дүн 886,299,597 мянган төгрөг (2014 оны 12 дугаар сарын 31: 814,405,751 мянган төгрөг) байсан бөгөөд нийт харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны 41.9% хувийг (2014 оны 12 дугаар сарын 31: 31.9% хувийг) эзэлж байсан. Группийн болон Банкны дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

Голомт Банк Групп

11 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Зээлийн үнэ цэнийн бууралтын санд 2015 онд гарсан өөрчлөлтүүдийг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Жижиг дунд бизнесийн зээл	Орон сууцны зээл	НИЙТ
Зээлийн үнэ цэнэ бууралтын сан 2015 оны 01 сарын 01	49,180,880	2,871,780	23,690,355	1,238,645	76,981,660
Тайлант жилд байгуулсан сан	29,054,370	3,375,532	14,836,115	2,437,398	49,703,415
Ханшийн зөрүү	679,099	4,893	26,347	636	710,975
Тайлант жилд данснаас хассан дүн	(19,103,086)	(839,897)	(12,358,613)	-	(32,301,596)
2015 оны 12 сарын 31 –нээрх зээлийн үнэ цэнэ бууралтын сан	59,811,263	5,412,308	26,194,204	3,676,679	95,094,454

Зээлийн үнэ цэнийн бууралтын санд 2014 онд гарсан өөрчлөлтүүдийг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Жижиг дунд бизнесийн зээл	Орон сууцны зээл	НИЙТ
Зээлийн үнэ цэнэ бууралтын сан 2014 оны 01 сарын 01	45,841,017	2,063,664	9,430,834	219,538	57,555,053
Тайлант жилд байгуулсан сан	10,565,749	397,569	13,763,027	1,051,536	25,777,881
Ханшийн зөрүү	362,555	727,828	1,734,277	-	2,824,660
Тайлант жилд данснаас хассан дүн	(7,588,441)	(317,281)	(1,237,783)	(32,429)	(9,175,934)
2014 оны 12 сарын 31 –нээрх зээлийн үнэ цэнэ бууралтын сан	49,180,880	2,871,780	23,690,355	1,238,645	76,981,660

Харилцагчдын зээлийн багц дахь бизнесийн салбарын эрсдлийн төвлөрлийг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2015		2014	
	Дүн	%	Дүн	%
Орон сууц, орон сууцны засвар	247,684,064	11.75%	622,974,437	24.54%
Боловсруулах үйлдвэр	405,779,805	19.24%	392,218,432	15.45%
Уул уурхай, хайгуул	317,435,450	15.05%	264,470,798	10.42%
Барилга	252,836,499	11.99%	242,971,931	9.57%
Бөөний болон жижиглэн худалдаа	226,603,476	10.75%	210,326,761	8.28%
Цалин, хэрэглээ	188,046,423	8.92%	180,584,629	7.11%
Эрчим хүч, шатахуун	94,299,062	4.47%	150,886,448	5.94%
Үл хөдлөх хөрөнгө	84,369,105	4.00%	98,224,022	3.87%
Санхүү	61,402,508	2.91%	81,665,181	3.22%
Хөдөө аж ахуй	63,806,431	3.03%	64,061,373	2.52%
Тээвэр ба харилцаа холбоо	33,417,701	1.58%	57,849,209	2.28%
Аялал жуулчлал	27,276,789	1.29%	42,726,221	1.68%
Дэд бүтэц	18,485,159	0.88%	26,231,413	1.03%
Засвар үйлчилгээ	23,080,842	1.09%	24,489,574	0.96%
Эрүүл мэнд	19,417,976	0.92%	20,368,107	0.80%
Зочид буудал, ресторан	15,204,794	0.72%	20,063,947	0.79%
Нийгмийн халамж	19,960,309	0.95%	18,203,961	0.72%
Гэр ахуйн цахилгаан бараа	2,155,270	0.10%	9,686,200	0.38%
Авто машин	3,823,128	0.18%	6,904,957	0.27%
Боловсрол	2,617,177	0.12%	2,988,761	0.12%
Олон нийтийн үйлчилгээ	331,831	0.02%	517,260	0.02%
Хувиараа эрхлэх аж ахуй	606,498	0.03%	484,860	0.02%
Олон улсын байгууллага	64,944	0.00%	3,216	0.00%
Нийт харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үнэ цэнийн бууралтын өмнөх)	2,108,705,241	100%	2,538,901,698	100%

2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх зээлийн барьцаа хөрөнгийн мэдээлэл:

Мянган төгрөгөөр	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Жижиг дунд бизнесийн зээл	Орон сууцны зээл	НИЙТ
Зээлийн барьцааны төрөл:					
- оршин суух ҮХХ	297,457,780	2,887,092	260,371,996	222,760,173	783,477,041
- бусад үл хөдлөх хөрөнгө	251,057,173	66,178	29,292,151	1,261,999	281,677,501
- борлуулагдах үнэт цаас	152,916,301	-	20,564,676	19,638	173,500,615
- мөнгөн хадгаламж	150,057,252	33,402,171	8,965,304	778,930	193,203,657
- бусад хөрөнгө	353,949,031	16,004,452	142,364,691	22,863,324	535,181,498
Барьцаа хөрөнгөгүй зээл	-	141,664,929	-	-	141,664,929
Харилцагчдад олгосон нийт зээл ба урьдчилгаа	1,205,437,537	194,024,822	461,558,818	247,684,064	2,108,705,241

2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх зээлийн барьцаа хөрөнгийн мэдээлэл:

Мянган төгрөгөөр	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Жижиг дунд бизнесийн зээл	Орон сууцны зээл	НИЙТ
Зээлийн барьцааны төрөл:					
- оршин суух ҮХХ	328,300,175	3,512,426	280,022,814	593,221,812	1,205,057,227
- бусад үл хөдлөх хөрөнгө	201,911,998	141,375	37,453,986	1,095,300	240,602,659
- борлуулагдах үнэт цаас	134,071,800	-	18,399,902	-	152,471,702
- мөнгөн хадгаламж	175,104,531	33,199,227	27,780,845	1,408,642	237,493,245
- бусад хөрөнгө	324,803,371	5,363,179	190,900,718	27,248,683	548,315,951
Барьцаа хөрөнгөгүй зээл	-	154,960,914	-	-	154,960,914
Харилцагчдад олгосон нийт зээл ба урьдчилгаа	1,164,191,875	197,177,121	554,558,265	622,974,437	2,538,901,698

Дээрх тодруулгад зээл болон зээлийн барьцаанд авсан хөрөнгийн бүртгэлийн дүнгийн аль багыг тусгасан ба үлдсэн хэсгийг барьцаагүй зээлийн хэсэгт толилуулсан.

Барьцаа хөрөнгөгүй зээл нь гол төлөв цалингийн зээл байна. Эдгээр зээлүүдэд Банк тусгайлан барьцаа хөрөнгө шаарддаггүй боловч зээлдэгчийн ирээдүйн цалингийн төлөлтүүдийг хянаж байдаг. Цалингийн зээл авах гол шаардлага нь цалинг Банкны дансаар дамжуулан авах явдал болно.

Голомт Банк Групп

11 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

2015 оны 12 дугаар сарын 31-нээр зээлийн үлдэгдлүүдийн эрсдэлийн чанарын шинжилгээг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Жижиг дунд бизнесийн зээл	Орон сууцны зээл	НИЙТ
<i>Хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралтад ороогүй</i>					
Маш сайн	751,381,007	180,913,163	308,756,493	233,688,558	1,474,739,221
Сайн	24,337,172	-	1,239,542	-	25,576,714
Зээлийн нөхцөлийг өөрчилсөн	209,934,879	30,601	17,352,153	397,705	227,715,338
Нийт хугацаа хэтрээгүй, үнэ цэнэ нь буураагүй	985,653,058	180,943,764	327,348,188	234,086,263	1,728,031,273
<i>Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтад ороогүй</i>					
- 30-аас цөөн хоногоор хэтэрсэн	4,640,265	2,235,297	21,377,136	2,826,375	31,079,073
- 30-аас 90 хоногоор хэтэрсэн	1,870,732	3,949,952	18,644,558	4,754,465	29,219,707
- 91-ээс 180 хоногоор хэтэрсэн	10,507,728	2,706,119	24,121,421	2,058,997	39,394,265
- 181-ээс 360 хоногоор хэтэрсэн	9,050,820	2,130,986	17,429,320	2,320,463	30,931,589
- 360-аас дээш хоногоор хэтэрсэн	47,667,463	2,058,704	19,057,338	1,637,501	70,421,006
Нийт хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнэ нь буураагүй	73,737,008	13,081,058	100,629,773	13,597,801	201,045,640
<i>Тусгайлан үнэ цэнэ нь буурсан зээл</i>					
- 30-аас цөөн хоногоор хэтэрсэн	25,257,864	-	2,477,420	-	27,735,284
- 30-аас 90 хоногоор хэтэрсэн	-	-	-	-	-
- 91-ээс 180 хоногоор хэтэрсэн	-	-	13,711,995	-	13,711,995
- 181-ээс 360 хоногоор хэтэрсэн	27,704,265	-	-	-	27,704,265
- 360-аас дээш хоногоор хэтэрсэн	93,085,342	-	17,391,442	-	110,476,784
Нийт тусгай үнэлгээгээр үнэ цэнэ нь буурсан зээл	146,047,471	-	33,580,857	-	179,628,328
Хасах нь: үнэ цэнийн бууралтын сан	(59,811,263)	(5,412,308)	(26,194,204)	(3,676,679)	(95,094,454)
Нийт харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	1,145,626,274	188,612,514	435,364,614	244,007,385	2,013,610,787

2014 оны 12 дугаар сарын 31-нээрх зээлийн үлдэгдлүүдийн эрсдлийн чанарын шинжилгээг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	Бизнесийн зээл	Хэрэглээний зээл	Жижиг дунд бизнесийн зээл	Орон сууцны зээл	НИЙТ
<i>Хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралтад ороогүй</i>					
Маш сайн	613,542,462	171,273,067	374,140,980	584,489,304	1,743,445,813
Сайн	59,608,632	808,648	16,207,237	7,208,618	83,833,135
Зээлийн нөхцлийг өөрчилсөн	224,807,819	80,612	44,716,233	140,366	269,745,030
Нийт хугацаа хэтрээгүй, үнэ цэнэ нь буураагүй	897,958,913	172,162,327	435,064,450	591,838,288	2,097,023,978
<i>Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтад ороогүй</i>					
- 30-аас цөөн хоногоор хэтэрсэн	63,914,236	14,093,643	14,599,900	22,698,939	115,306,718
- 30-аас 90 хоногоор хэтэрсэн	16,962,015	3,911,898	14,519,533	4,571,427	39,964,873
- 91-ээс 180 хоногоор хэтэрсэн	49,845,631	2,102,176	5,744,789	1,151,280	58,843,876
- 181-ээс 360 хоногоор хэтэрсэн	26,072,045	1,703,241	27,026,745	2,051,008	56,853,039
- 360-аас дээш хоногоор хэтэрсэн	-	3,203,836	16,884,471	663,495	20,751,802
Нийт хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнэ нь буураагүй	156,793,927	25,014,794	78,775,438	31,136,149	291,720,308
<i>Тусгайлан үнэ цэнэ нь буурсан зээл</i>					
- 30-аас цөөн хоногоор хэтэрсэн	998,796	-	-	-	998,796
- 30-аас 90 хоногоор хэтэрсэн	-	-	33,294	-	33,294
- 91-ээс 180 хоногоор хэтэрсэн	19,805,086	-	107,748	-	19,912,834
- 181-ээс 360 хоногоор хэтэрсэн	26,866,823	-	34,317,476	-	61,184,299
- 360-аас дээш хоногоор хэтэрсэн	61,768,330	-	6,259,859	-	68,028,189
Нийт тусгай үнэлгээгээр үнэ цэнэ нь буурсан зээл)	109,439,035	-	40,718,377	-	150,157,412
Хасах нь: үнэ цэнийн бууралтын сан	(49,180,880)	(2,871,780)	(23,690,355)	(1,238,645)	(76,981,660)
Нийт харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	1,115,010,995	194,305,341	530,867,910	621,735,792	2,461,920,038

Групп нь багц хөрөнгөд эрсдлийн сан байгуулах тухай НББОУС 39, Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт-т заасан аргачлалыг ашигласан боловч дан ганц зээлд тусгайлан оноох боломжгүй үнэ цэнэ бууралтын гарзыг тайлант хугацааны эцэст багцын хэмжээнд сан байгуулсан. Группийн бодлогын дагуу тухайн нэг зээлийн үнэ цэнэ буурсаныг тусгайлан харуулсан бодит нотолгоо илэртэл зээл бүрийг “хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй” гэж ангилдаг. Энэхүү бодлого буюу бүлгээр байгуулсан сангийн нөлөөгөөр нийт сангийн дүн нь тусгай үнэлгээгээр үнэ цэнэ буурсан зээлийн дүнгээс хэтэрч болно.

Группийн зээлийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлохдоо авч үздэг үндсэн хүчин зүйлс нь тэдгээрийн хугацаа хэтрэлтийн байдал, мөн аливаа холбогдох барьцаа хөрөнгийг борлуулах бололцоо юм. Үүний үр дүнд Групп нь үнэ цэнэ буурахаар тодорхойлогдсон зээлүүдийн насжилтын тайланг дээр толилуулсан.

Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнэ алдаагүй зээлүүд нь ихэвчлэн барьцаат зээлүүдээс бүрдэх бөгөөд барьцаа хөрөнгийнх нь бодит үнэ нь хугацаандаа төлөгдөөгүй хүү болон зээлийн үлдэгдлийг нөхөхөд хүрэлцээтэй байсан. Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнэ алдаагүй зээлийн дүн нь зээлийн зөвхөн хугацаа хэтэрсэн хуваарьт төлбөрийн дүнг бус зээлийн нийт үлдэгдэл дүнг харуулж байгаа.

Барьцаа хөрөнгийн санхүүгийн нөлөөг дараах байдлаар тусад нь толилуулсан (i) барьцаа хөрөнгө болон зээлийн сайжруулалт нь хөрөнгийн дансны үнээс илүү буюу тэнцүү байх санхүүгийн хөрөнгүүд (“илүү барьцаа бүхий хөрөнгө”) мөн (ii) барьцаа хөрөнгө болон зээлийн сайжруулалт нь хөрөнгийн дансны үнээс бага байх санхүүгийн хөрөнгүүд (“дутуу барьцаа бүхий хөрөнгө”).

Голомт Банк Групп

11 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн барьцаа хөрөнгийн нөлөөг дор харуулав:

Мянган төгрөгөөр	Илүү барьцаа бүхий хөрөнгө		Дутуу барьцаа бүхий хөрөнгө	
	Хөрөнгийн дансны үнэ	Барьцаа хөрөнгийн бодит үнэ	Хөрөнгийн дансны үнэ	Барьцаа хөрөнгийн бодит үнэ
Бизнесийн зээл	1,011,403,838	5,842,986,430	194,033,699	133,391,374
Хэрэглээний зээл	52,139,520	169,187,406	141,885,302	201,163
Жижиг дунд бизнесийн зээл	368,226,102	1,918,631,215	93,332,716	43,461,612
Орон сууцны зээл	247,271,672	645,385,686	412,392	334,571
НИЙТ	1,679,041,132	8,576,190,737	429,664,109	177,388,720

2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн барьцаа хөрөнгийн нөлөөг дор харуулав:

Мянган төгрөгөөр	Илүү барьцаа бүхий хөрөнгө		Дутуу барьцаа бүхий хөрөнгө	
	Хөрөнгийн дансны үнэ	Барьцаа хөрөнгийн бодит үнэ	Хөрөнгийн дансны үнэ	Барьцаа хөрөнгийн бодит үнэ
Бизнесийн зээл	1,108,202,014	2,760,385,624	55,989,861	27,795,552
Хэрэглээний зээл	39,755,737	103,028,437	157,421,384	1,929,790
Жижиг дунд бизнесийн зээл	466,272,050	1,474,836,065	88,286,215	62,348,400
Орон сууцны зээл	622,363,337	1,188,829,728	611,100	450,000
НИЙТ	2,236,593,138	5,527,079,854	302,308,560	92,523,742

Барьцаа хөрөнгийн дээр заасан үнэ нь тайлант үеийн зах зээлийн үнэ бөгөөд Банкны дотоодын үнэлгээний мэргэжилтнүүд доошлуулсан таамаглал дээр үндэслэж гаргасан.

Хугацаа хэтрээгүй, үнэ цэнээ алдаагүй боловч нөхцөл өөрчлөгдсөн зээлүүдэд анхны нөхцлүүдийг өөрчлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн эсвэл үнэ цэнээ алдсан гэж ангилагдах байсан зээлүүдийн дансны үнийг оруулсан. Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнээ алдаагүй зээлүүд нь ихэвчлэн барьцаат зээлүүдээс бүрдэх бөгөөд барьцаа хөрөнгийнх нь бодит үнэ нь хугацаандаа төлөгдөөгүй хүү болон зээлийн үлдэгдлийг нөхөхөд хүрэлцээтэй байсан.

Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнээ алдаагүй зээлийн дүн нь зээлийн зөвхөн хугацаа хэтэрсэн хуваарьт төлбөрийн дүнг бус зээлийн нийт үлдэгдэл дүнг харуулсан байна.

Банкны өмчлөх бусад хөрөнгийн талаар тодруулга 19-өөс үзнэ үү. Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны бодит үнэ цэнийн тооцооллыг Тодруулга 38-аас үзнэ үү. Холбоотой талуудын дүнг Тодруулга 40-д харуулсан. Тодруулга 34-д харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны валютын, хүүний болон эргэн төлөгдөх хугацааны эрсдлийн шинжилгээг толилуулсан.

12 Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас

Мянган төгрөгөөр	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Хөрөнгийн биржид бүртгэлгүй хувьцаа-бодит үнэ цэнээр	58,485,255	60,598,447
Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаа-бодит үнэ цэнээр	9,602,795	422,284
Нийт	68,088,050	61,020,731

2015 оны 12 дугаар сарын 31 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаасны өөрчлөлтийг дор үзүүлэв:

Мянган төгрөгөөр	2015	2014
01 сарын 01-ний өдрөөрх дансны үнэ	61,020,732	3,194,738
Бодит үнэ цэнийн тохируулга	6,539,214	(813,651)
Худалдаж авсан – Хөрөнгийн биржид бүртгэлтэй	213,572	-
Худалдаж авсан – Хөрөнгийн биржид бүртгэлгүй (Тодруулга 13)	437,832,600	164,712,665
Худалдсан - Хөрөнгийн биржид бүртгэлтэй	-	(12,336)
Худалдсан - Хөрөнгийн биржид бүртгэлгүй (Тодруулга 13)	(437,832,600)	(106,712,665)
Гадаад валютын ханшийн зөрүүгийн нөлөө	314,532	651,980
12 сарын 31-ний өдрөөрх дансны үнэ	68,088,050	61,020,731

Монгол Улсын засгийн газраас 2013 онд хөрөнгө оруулалтын сан байгуулах тухай хууль батлагдсанаар анхны хөрөнгө оруулалтын сан (ХОС) байгуулагдсан. Уг хөрөнгө оруулалтын сан нь Банкны удирдлага болоод эзэмшигчтэй холбоогүй, Монгол Улсад бүртгэлтэй менежментийн компаниар удирдуулдаг бөгөөд гол бизнесийн үйл ажиллагаа нь хөрөнгө оруулагчаас татсан эх үүсвэр ашиглан хөрөнгө оруулалт хийх юм. 2015 оны 12 дугаар сарын 31 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк нь тус сангийн хөрөнгө оруулалтын нэгжийн 10 хувийг худалдаж авсан бөгөөд 2015 оны эхээр ХОС-ийн менежментийн компани Банкны хөрөнгө оруулалтаар үл хөдлөх хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийсэн. Банк нийт 58 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд 2015 оны 12 дугаар сарын 31 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкны удирдлагын зүгээс хараат бус мэргэжлийн хөрөнгийн үнэлгээний байгууллагаар хийлгэсэн үнэлгээнд үндэслэн эдгээр хөрөнгө оруулалт хийгдсэн үл хөдлөх хөрөнгүүд нь бүрэн нөхөгдөх хөрөнгө гэж үзэж байгаа.

Удирдлагын зүгээс уг хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа болон мөн санхүүгийн шийдвэрийг хянах эсвэл төдийлөн нөлөөлөх эрхгүй гэж үзсэн. Иймээс НББОУС 39-ийн дагуу уг хөрөнгө оруулалтыг борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт гэж үзнэ (Тодруулга 3). Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө оруулалтын сангийн тусгай зөвшөөрлийг 2015 оны 10 дугаар сард олгосноос үүдэн уг хөрөнгө оруулалтын сан нь 2015 онд үйл ажиллагаа явуулаагүй болно. 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илрээгүй тул Удирдлагын зүгээс уг хөрөнгө оруулалтын дансны үнэ нь бодит үнэ цэнэтэй адил гэж үзсэн.

2015 оны 12 дугаар сарын сүүлээр Монголын Ипотекийн Корпорацийн (МИК) хувьцаа Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж эхэлсэн. Уг хувьцааг гаргахтай холбоотойгоор олон нийтэд нээлттэй болсон мэдээллийг ашиглан Банкны дотоодын үнэлгээний мэргэжилтнүүд 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх МИК-д оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг дахин үнэлсэн.

Банк МИК-д оруулсан борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн тохируулгын олз болох 6,539,214 мянган төгрөгийн бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэсэн. Удирдлагын зүгээс МИК-д оруулсан хөрөнгө оруулалтын зах зээлийн бодит үнэ цэнийг тооцоолох боломжгүй гэж үзсэн тул 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тухайн хөрөнгө оруулалтыг өртгөөр үнэлсэн.

Группийн болон Банкны дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

13 Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2015	2014	2015	2014
Монголбанкны үнэт цаас (а)	424,454,647	209,591,218	424,454,647	209,591,218
Засгийн Газрын бонд (б)	66,223,099	66,121,588	64,901,615	65,968,346
МИК бонд (в)	64,008,203	14,784,500	64,008,203	14,784,500
Худалдан авсан өрийн бичиг (г)	39,467,452	-	39,467,452	-
Байгууллагын бонд	17,419	-	-	-
Нийт дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас	594,170,820	290,497,306	592,831,917	290,344,064

Голомт Банк Групп

13 Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас (үргэлжлэл)

Дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаасны хэмжилтийг тодруулга 39-өөс харна уу.

(а) Монголбанкны үнэт цаас ("МБ")

Монголбанкны үнэт цаас нь хөнгөлөлттэй гаргасан хүү бүхий богино хугацаат үнэт цаас болно. 2015 оны 12 дугаар сарын 31 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн турш Монголбанкны үнэт цаасны багцад гарсан өөрчлөлт нь дараах байдалтай байна. Үүнд:

Мянган төгрөгөөр	2015	2014
01 сарын 01-ний өдрөөрх дансны үнэ	209,591,218	549,098,116
Нэмэгдсэн	2,305,701,429	15,041,993,102
Хасагдсан	(2,090,838,000)	(15,381,500,000)
12 сарын 31-ний өдрөөрх дансны үнэ	424,454,647	209,591,218

2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Монголбанкны хямдруулсан үнээр худалдаж авсан үнэт цаасууд нь 13 хувийн хүүтэй, анхны дуусах хугацаа нь 7 хоногийн хугацаатай (2014: 12 - 12.5 хувийн хүүтэй, 6 – 28 өдрийн анхны дуусах хугацаатай) байна. 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 174,204,274 мянган төгрөгний Монголбанкны үнэт цаас нь дотоодын банктай хийсэн РЕПО хэлцлийн барьцаа хөрөнгийг илэрхийлнэ (Тодруулга 23, 36).

(б) Засгийн Газрын бонд

Засгийн газрын бонд нь Сангийн яамнаас хямдруулалттай гаргасан анхны дуусах хугацаа нь 6 – 121 сарын (2014: 3 – 155 сар) хугацаатай бондыг илэрхийлнэ. Засгийн газрын бондийн дүнд анхны дуусах хугацаа нь 3 сараас бага Засгийн газрын үнэт цаас орсон бөгөөд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө гэж үзнэ. 2015 оны 12 сарын 31 болон 2014 оны 12 сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн жилд Засгийн Газрын Бондийн багцад гарсан өөрчлөлт хөдөлгөөнийг доорхи хүснэгтээс үзнэ үү:

Мянган төгрөгөөр	Групп		Банк	
	2015	2014	2015	2014
01 сарын 01-ний өдрөөрх дансны үнэ	66,121,588	154,939,387	65,968,346	154,939,387
Нэмэгдсэн	52,893,357	143,173,300	50,791,300	143,018,000
Хасагдсан	(52,280,700)	(235,333,037)	(51,365,400)	(235,333,037)
Хорогдуулаагүй урамшуулал/хямдруулалт	(1,398,888)	2,407,365	(1,380,372)	2,412,811
Хуримтлагдсан хүүгийн орлого	887,741	934,573	887,741	931,184
12 сарын 31-ний өдрөөрх хорогдуулсан өртөг	66,223,098	66,121,588	64,901,615	65,968,345

(в) МИК-н (Монголын Ипотекийн Корпораци) бонд

МИК-н (Монголын Ипотекийн Корпораци) бонд нь Банкны харилцагчдад олгосон орон сууцны зээлийн багцаар баталгаажсан үнэт цаас ("ОСЗБҮЦ") буюу тодруулга 3-т тусгагдсан Монголын Ипотекийн Корпорацийн (МИК) хийсэн ипотекийн зээлийг үнэт цаасжуулах гүйлгээний хүрээнд авсан орон сууцны зээлээр баталгаажсан энгийн үнэт цаас юм.

2015 оны 1-р улиралд Банк 4 дэх МИК-ийн үнэт цаасжуулах гүйлгээнд оролцож 161,853,300 мянган төгрөгийн 8 хувийн орон сууцны зээлийн багцаа зарж 145,668,000 мянган төгрөгийн 4.5 хувийн хүүтэй давуу эрхтэй орон сууцны зээлийн багцаар баталгаажсан үнэт цаас болон 16,185,300 мянган төгрөгийн 10.5 хувийн хүүтэй энгийн ОСЗБҮЦ-ыг авсан. Дэлгэрэнгүйг тодруулга 3-с үзнэ үү.

2015 оны 2-р улиралд Банк 5 дахь МИК-ийн үнэт цаасжуулах гүйлгээнд оролцож 169,944,900 мянган төгрөгийн 8 хувийн орон сууцны зээлийн багцаа зарж 152,950,400 мянган төгрөгийн 4.5 хувийн хүүтэй давуу эрхтэй орон сууцны зээлийн багцаар баталгаажсан үнэт цаас болон 16,994,500 мянган төгрөгийн 10.5 хувийн хүүтэй энгийн ОСЗБҮЦ-ыг авсан. Дэлгэрэнгүйг тодруулга 3-с үзнэ үү.

2015 оны 3 болон 4-р улиралд Банк 6 болон 7 дахь МИК-ийн үнэт цаасжуулах гүйлгээнд оролцож 83,105,900 болон 71,576,600 мянган төгрөгийн 8 хувийн орон сууцны зээлийн багцаа зарж 74,795,300 болон 64,418,900 мянган төгрөгийн 4.5 хувийн хүүтэй давуу эрхтэй орон сууцны зээлийн багцаар баталгаажсан үнэт цаас болон 8,310,600 болон 7,157,700 мянган төгрөгийн 10.5 хувийн хүүтэй энгийн ОСЗБҮЦ-ыг авсан. Дэлгэрэнгүйг тодруулга 3-с үзнэ үү.

Банкны удирдлагын зүгээс давуу эрхтэй ОСЗБҮЦ-ыг Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэт цаас, энгийн ОСЗБҮЦ-ыг дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үнэт цаас гэж тус тус бүртгэсэн. 2015 онд Банк нь уг хөтөлбөрийн журмын дагуу 437,832,600 мянган төгрөгийн давуу эрхтэй ОСЗБҮЦ-ыг Монголбанкинд зарж орон сууцны 8 хувийн зээлийн хөтөлбөрийн 4 хувийн эх үүсвэрийг төлсөн.

Тодруулга 3-т заасны дагуу давуу эрхтэй үнэт цаасны үндсэн төлбөр хийгдсэн тохиолдолд энгийн үнэт цаасны үндсэн төлбөрийг авах боломжтой ба давуу эрхтэй үнэт цаас эзэмшигчид нь төлбөрийн хувьд давуу эрхтэй. Түүнчлэн, МИК-ийн цэвэр хөрөнгө нь дутсан тохиолдолд үүнийг давуу болон энгийн үнэт цаас эзэмшигчид (төлбөрийн эрхийн дарааллын дагуу) хариуцна.

Дуусгавар хугацаа хүртэл эзэмшиж буй хөрөнгө оруулалтын үнэт цаасны зээлийн чанарын үнэлгээг 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доор харуулав:

Мянган төгрөгөөр	Монголбанкны үнэт цаас	Засгийн Газрын бонд	МИК бонд	Худалдан авсан өрийн бичиг	Нийт
Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй					
- В	424,454,647	64,901,615	-	39,467,452	528,823,714
- Зэрэглэл хийгдээгүй	-	-	64,008,203	-	64,008,203
Нийт хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй	424,454,647	64,901,615	64,008,203	39,467,452	592,831,917

Дуусгавар хугацаа хүртэл эзэмшиж буй хөрөнгө оруулалтын үнэт цаасны зээлийн чанарын үнэлгээг 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доор харуулав:

Мянган төгрөгөөр	Монголбанкны үнэт цаас	Засгийн Газрын бонд	МИК бонд	Худалдан авсан өрийн бичиг	Нийт
Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй					
- В	209,591,218	65,968,346	-	-	275,559,564
- Зэрэглэл хийгдээгүй	-	-	14,784,500	-	14,784,500
Нийт хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй	209,591,218	65,968,346	14,784,500	-	290,344,064

Банкны удирдлагын зүгээс 2015 оны 12 дугаар сарын 31 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дуусгавар хугацаа хүртэл эзэмшиж буй хөрөнгө оруулалтын үнэт цаасанд үнэ цэнийн бууралтын шинэ тэмдэг илрээгүй тул үнэ цэнэ бууралтын сан байгуулах шаардлагагүй гэж үзсэн.

(г) Худалдан авсан өрийн бичиг

2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк сангийн яамны гаргасан 39,467,452 мянган төгрөгийн 8 хувийн хүүтэй, анхны дуусгавар хугацаа нь 246-360 өдрийн хугацаатай өрийн бичгүүдийг худалдаж авсан байсан.

14 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь бодит үнэ цэнийн аргаар бүртгэгдсэн, Группийн үндсэн үйл ажиллагаанд ашиглагддаггүй зуслангийн цогцолборын дансны үнийг илэрхийлнэ. Уг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ойролцоо дүнгээр 1,209,050 мянган төгрөг (2014: 1,209,050 мянган төгрөг) байна.

Голомт Банк Групп

15 Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт

	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Мянган төгрөгөөр		
Хөрөнгийн биржид бүртгэлгүй хувьцаа-өртгөөр	1,200,000	200,000

Энэхүү дүн нь Монгол улсад үүсгэн байгуулагдаж, брокер, дилерийн үйл ажиллагаа явуулдаг Голомт Секюритиз ХХК-ийн 100 хувийн эзэмшлийн хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

Банк 2015 оны 01 дүгээр сард 1,000,000 мянган төгрөгийн нэмэлт хөрөнгө оруулалтыг өөрийн охин компани Голомт Секюритиз ХХК-д хийсэн.

16 Бусад хөрөнгө

	Групп		Банк	
	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Мянган төгрөгөөр				
Бусад санхүүгийн хөрөнгө:				
Мөнгөн хөрөнгө болон гүйлгээний авлага	1,056,063	1,366,894	1,056,063	1,351,020
Хувь хүмүүсээс авах авлага	260,314	596,627	260,314	596,627
Компаниудаас авах авлага	3,854,468	2,080,992	3,854,448	2,069,862
Бусад санхүүгийн хөрөнгө	6,414,964	3,395,378	6,384,275	3,395,378
Хасах нь: Үнэ цэнэ бууралтын сан	(2,895,607)	(1,876,088)	(2,895,607)	(1,876,088)
Нийт бусад санхүүгийн хөрөнгө	8,690,202	5,563,803	8,659,493	5,536,799
Бусад санхүүгийн бус хөрөнгө:				
Ажилтнуудад олгох хөнгөлөлтийн урьдчилсан төлбөр	8,524,141	5,343,386	8,524,141	5,343,386
Оффисийн хангамжийн материал	596,546	606,845	596,546	606,845
Барилгын засварын урьдчилгаа	45,510	162,080	45,510	162,080
Түрээсийн урьдчилгаа	1,587,499	723,418	1,569,925	722,768
Ажилтнуудад төлсөн урьдчилгаа	432	2,886	432	2,886
Бусад урьдчилгаа	2,899,061	1,358,387	2,898,417	1,358,387
Бусад санхүүгийн бус хөрөнгө	443,566	456,197	443,565	456,197
Нийт бусад санхүүгийн бус хөрөнгө	14,096,755	8,653,199	14,078,536	8,652,549
Нийт бусад хөрөнгө	22,786,957	14,217,002	22,738,029	14,189,348

Ажилтнуудад олгосон хөнгөлөлтийн урьдчилсан төлбөрт ажилтнуудад хөнгөлттэй нөхцөлөөр олгосон зээлтэй холбоотой олгосон урьдчилгаа төлбөр болох 8,524,141 мянган төгрөг (2014 оны 12 дугаар сарын 31: 4,843,448 мянган төгрөг) багтсан болно. СТОУС-ын дагуу ажилтнуудад олгосон хөнгөлөлттэй зээлийг анх олгоход тохируулах бодит үнэ цэнэ нь цалингийн урьдчилсан төлбөрт хамаарах ба санхүүгийн бусад хөрөнгөд хүлээн зөвшөөрдөг.

Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлтөд 2015 онд бүртгэгдсэн Монголбанкнаас авах 3,342,134 мянган төгрөгийн авлага багтсан болно.

Бусад санхүүгийн хөрөнгийн эрсдлийн чанарын үнэлгээг 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доор харуулав:

Мянган төгрөгөөр	Мөнгөн хөрөнгө болон гүйлгээний авлага	Хувь хүмүүсээс авах авлага	Компаниас авах авлага	Бусад санхүүгийн хөрөнгө	Нийт
Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй					
- Маш сайн	519,125	258,623	3,087,327	4,751,611	8,616,686
Нийт хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй	519,125	258,623	3,087,327	4,751,611	8,616,686
Үнэ цэнэ буурсан					
- 30-с бага хоногоор хугацаа хэтэрсэн	-	-	-	-	-
- 31 – 90 хоногоор хугацаа хэтэрсэн	60,782	1,691	-	-	62,473
- 91 -180 хоног хугацаа хэтэрсэн	-	-	-	-	-
- 181 – 360 хоног хугацаа хэтэрсэн	-	-	-	-	-
- 360-с дээш хоног хугацаа хэтэрсэн	476,156	-	767,121	1,632,664	2,875,941
Нийт үнэ цэнэ нь буурсан	536,938	1,691	767,121	1,632,664	2,938,414
Хасах нь үнэ цэнийн бууралтын сан	(313,912)	-	(816,815)	(1,764,880)	(2,895,607)
Нийт бусад санхүүгийн хөрөнгө	742,151	260,314	3,037,633	4,619,395	8,659,493

Бусад санхүүгийн хөрөнгийн эрсдлийн чанарын үнэлгээг 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доор харуулав:

Мянган төгрөгөөр	Мөнгөн хөрөнгө болон гүйлгээний авлага	Хувь хүмүүсээс авах авлага	Компаниас авах авлага	Бусад санхүүгийн хөрөнгө	Нийт
Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй					
- Маш сайн	748,644	596,627	2,069,862	1,777,808	5,192,941
Нийт хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй	748,644	596,627	2,069,862	1,777,808	5,192,941
Үнэ цэнэ буурсан					
- 30-с бага хоногоор хугацаа хэтэрсэн	527,148	-	-	286,747	813,895
- 31 – 90 хоногоор хугацаа хэтэрсэн	-	-	-	-	-
- 91 -180 хоног хугацаа хэтэрсэн	-	-	-	-	-
- 181 – 360 хоног хугацаа хэтэрсэн	-	-	-	-	-
- 360-с дээш хоног хугацаа хэтэрсэн	75,228	-	-	1,330,823	1,406,051
Нийт үнэ цэнэ нь буурсан	602,376	-	-	1,617,570	2,219,946
Хасах нь үнэ цэнийн бууралтын сан	(341,677)	-	-	(1,534,411)	(1,876,088)
Нийт бусад санхүүгийн хөрөнгө	1,009,343	596,627	2,069,862	1,860,967	5,536,799

Голомт Банк Групп

16 Бусад хөрөнгө (үргэлжлэл)

2015 онд бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын санд гарсан хөдөлгөөнийг доороос харна уу:

Мянган төгрөгөөр	Мөнгөн хөрөнгө болон гүйлгээний авлага	Хувь хүмүүсээс авах авлага	Компаниас авах авлага	Бусад санхүүгийн хөрөнгө	Нийт
2015 оны 01 сарын 01-нээрх үнэ цэнэ бууралтын сан	331,424	-	66,540	1,478,124	1,876,088
Тайлант жилд байгуулсан сан	208,790	-	750,275	286,756	1,245,821
Ханшийн өөрчлөлтийн нөлөө	38,774	-	-	-	38,774
Жилийн дундуур найдваргүй хэмээн данснаас хассан	(265,075)	-	-	-	(265,075)
2015 оны 12 сарын 31-нээрх үнэ цэнэ бууралтын сан	313,913	-	816,815	1,764,880	2,895,607

2014 онд бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын санд гарсан хөдөлгөөнийг доороос харна уу:

Мянган төгрөгөөр	Мөнгөн хөрөнгө болон гүйлгээний авлага	Хувь хүмүүсээс авах авлага	Компаниас авах авлага	Бусад санхүүгийн хөрөнгө	Нийт
2014 оны 01 сарын 01-нээрх үнэ цэнэ бууралтын сан	671,393	-	33,270	179,235	883,898
Тайлант жилд байгуулсан сан	291,426	-	33,270	1,356,716	1,681,412
Ханшийн өөрчлөлтийн нөлөө	11,575	-	-	-	11,575
Жилийн дундуур найдваргүй хэмээн данснаас хассан	(642,970)	-	-	(57,827)	(700,797)
2014 оны 12 сарын 31-нээрх үнэ цэнэ бууралтын сан	331,424	-	66,540	1,478,124	1,876,088

17 Биет бус хөрөнгө

Мянган төгрөгөөр	Групп			Банк		
	Компьютер программ хангамж, лиценз	Газар эзэмших эрх	Нийт	Компьютер программ хангамж, лиценз	Газар эзэмших эрх	Нийт
2014 оны 01 сарын 01-нээрх өртөг	9,008,038	673,313	9,681,351	9,004,523	673,313	9,677,836
Хуримтлагдсан хорогдуулалт	(5,043,000)	-	(5,043,000)	(5,040,534)	-	(5,040,534)
2014 оны 01 сарын 01-нээрх дансны үнэ	3,965,038	673,313	4,638,351	3,963,989	673,313	4,637,302
Нэмэгдсэн	11,146,410	-	11,146,410	11,146,410	-	11,146,410
Байгуулсан хорогдол (тод 30)	(1,975,004)	-	(1,975,004)	(1,974,395)	-	(1,974,395)
Өртгөөр нь данснаас хассан	(286,281)	-	-	(286,281)	-	(286,281)
Данснаас хассан хөрөнгийн хуримтлагдсан хорогдуулалт	286,281	-	-	286,281	-	286,281
2014 оны 12 сарын 31-нээрх дансны үнэ	13,136,444	673,313	13,809,757	13,136,004	-	13,809,317
2015 оны 01 сарын 01-нээрх өртөг	20,154,448	673,313	20,827,761	19,864,652	673,313	20,537,965
Хуримтлагдсан хорогдуулалт	(7,018,004)	-	(7,018,004)	(6,728,648)	-	(6,728,648)
2015 оны 01 сарын 01-нээрх дансны үнэ	13,136,444	673,313	13,809,757	13,136,004	673,313	13,809,317
Нэмэгдсэн	5,434,785	-	5,434,785	5,426,390	-	5,426,390
Байгуулсан хорогдол (тод 30)	(4,503,962)	-	(4,503,962)	(4,499,708)	-	(4,499,708)
2015 оны 12 сарын 31-нээрх дансны үнэ	14,067,267	673,313	14,740,580	14,062,686	673,313	14,735,999

18 Үндсэн хөрөнгө

/Групп/

Мянган төгрөгөөр	Барилга байшин	Тээврийн хэрэгсэл	Оффисын тоног төхөөрөмж, компьютер	Тавилга	Нөөц үндсэн хөрөнгө	Түрээсийн сайжруулалт	Дуусаагүй барилга	Нийт үндсэн хөрөнгө
2014 оны 01 сарын 01-нээрх өртөг	22,157,486	2,306,840	21,148,547	2,867,084	3,417,828	548,622	14,708,753	67,155,160
Хуримтлагдсан элэгдэл	18,011	(897,156)	(11,405,643)	(1,935,025)	-	(265,300)	-	(14,485,113)
2014 оны 01 сарын 01-нээрх дансны үнэ	22,175,497	1,409,684	9,742,904	932,059	3,417,828	283,322	14,708,753	52,670,047
Нэмэгдсэн	35,726,751	686,900	3,839,426	1,581,387	3,273,873	1,109,521	12,597,232	58,815,090
Дахин ангилсан	3,323,032	-	-	-	-	-	(3,323,032)	-
Шилжүүлсэн	-	-	1,353,029	-	(1,353,029)	-	-	-
Өртгөөр нь худалдсан	(619,556)	(340,758)	(158,582)	(2,347)	-	-	(11,675,160)	(12,796,403)
Данснаас хаассан	-	-	(451,259)	-	-	-	-	(451,259)
Байгуулсан элэгдэл (тод 30)	(956,818)	(321,827)	(5,489,794)	(299,523)	-	(219,965)	-	(7,287,927)
Худалдсан хөрөнгийн элэгдэл	280,091	189,090	146,156	1,302	-	-	-	616,639
Данснаас хаасан хөрөнгийн элэгдэл	-	-	433,722	-	-	-	-	433,722
2014 оны 12 сарын 31-нээрх дансны үнэ	59,928,997	1,623,089	9,415,602	2,212,878	5,338,672	1,172,878	12,307,793	91,999,909
2015 оны 01 сарын 01-нээрх өртөг	60,587,713	2,652,982	25,731,161	4,446,124	5,338,672	1,658,143	12,307,793	112,722,588
Хуримтлагдсан элэгдэл	(658,716)	(1,029,893)	(16,315,559)	(2,233,246)	-	(485,265)	-	(20,722,679)
2015 оны 01 сарын 01-нээрх дансны үнэ	59,928,997	1,623,089	9,415,602	2,212,878	5,338,672	1,172,878	12,307,793	91,999,909
Нэмэгдсэн	85,797,445	320,741	1,124,274	1,628,814	473,500	389,740	4,278,944	94,013,458
Дахин ангилсан	2,393,109	-	-	-	-	-	(2,393,109)	-
Шилжүүлсэн	785,497	-	4,324,855	1,948	(4,326,803)	(785,497)	-	-
Өртгөөр нь худалдсан	(214,979)	(105,094)	(106,155)	(27,311)	-	-	-	(453,539)
Данснаас хаассан	-	-	(274,221)	(41,289)	-	-	-	(315,510)
Байгуулсан элэгдэл (тод 30)	(2,618,550)	(289,501)	(5,660,675)	(331,220)	-	(353,045)	-	(9,252,991)
Худалдсан хөрөнгийн элэгдэл	118,230	104,348	104,958	14,425	-	-	-	341,961
Данснаас хаасан хөрөнгийн элэгдэл	-	-	269,361	30,997	-	-	-	300,358
2015 оны 12 сарын 31-нээрх дансны үнэ	145,418,730	1,654,467	9,196,902	4,260,473	1,485,370	424,076	14,193,628	176,633,646

Голомт Банк Групп

18 Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

/БАНК/

Мянган төгрөгөөр	Барилга байшин	Тээврийн хэрэгсэл	Оффисын тоног төхөөрөмж, компьютер	Тавилга	Нөөц үндсэн хөрөнгө	Түрээсийн сайжруулалт	Дуусаагүй барилга	Нийт үндсэн хөрөнгө
2014 оны 01 сарын 01-нээрх өртөг	22,157,486	2,306,840	21,126,113	2,852,938	3,417,828	548,622	14,708,753	67,118,580
Хуримтлагдсан элэгдэл	18,011	(897,156)	(11,393,032)	(1,932,549)	-	(265,300)	-	(14,470,026)
2014 оны 01 сарын 01-нээрх дансны үнэ	22,175,497	1,409,684	9,733,081	920,389	3,417,828	283,322	14,708,753	52,648,554
Нэмэгдсэн	35,726,751	686,900	3,839,230	1,581,387	3,273,873	1,109,521	12,597,232	58,814,894
Дахин ангилсан	3,323,032	-	-	-	-	-	(3,323,032)	-
Шилжүүлсэн	-	-	1,353,029	-	(1,353,029)	-	-	-
Өртгөөр нь худалдсан	(619,556)	(340,758)	(158,582)	(2,347)	-	-	(11,675,160)	(12,796,403)
Данснаас хаасан	-	-	(451,259)	-	-	-	-	(451,259)
Байгуулсан элэгдэл (тод 30)	(956,818)	(321,827)	(5,482,313)	(298,108)	-	(219,965)	-	(7,279,031)
Худалдсан хөрөнгийн элэгдэл	280,091	189,090	146,156	1,302	-	-	-	616,639
Данснаас хаасан хөрөнгийн элэгдэл	-	-	433,722	-	-	-	-	433,722
2014 оны 12 сарын 31-нээрх дансны үнэ	59,928,997	1,623,089	9,413,064	2,202,623	5,338,672	1,172,878	12,307,793	91,987,116
2015 оны 01 сарын 01-нээрх өртөг	60,416,811	2,652,983	25,708,529	4,679,524	5,338,673	1,658,144	12,307,793	112,762,457
Хуримтлагдсан элэгдэл	(1,258,833)	(1,029,893)	(16,295,467)	(1,705,882)	-	(485,266)	-	(20,775,341)
2015 оны 01 сарын 01-нээрх дансны үнэ	59,157,978	1,623,090	9,413,062	2,973,642	5,338,673	1,172,878	12,307,793	91,987,116
Нэмэгдсэн	85,797,445	317,200	1,123,561	1,615,664	473,501	389,740	4,278,944	93,996,055
Дахин ангилсан	2,393,109	-	-	-	-	-	(2,393,109)	-
Шилжүүлсэн	785,497	-	4,324,855	1,948	(4,326,803)	(785,497)	-	-
Өртгөөр нь худалдсан	(214,979)	(100,177)	(106,155)	(13,166)	-	-	-	(434,477)
Данснаас хаасан	-	-	(274,221)	(41,289)	-	-	-	(315,510)
Байгуулсан элэгдэл (тод 30)	(2,618,550)	(288,294)	(5,659,232)	(329,457)	-	(353,045)	-	(9,248,578)
Худалдсан хөрөнгийн элэгдэл	118,230	100,177	104,958	10,417	-	-	-	333,782
Данснаас хаасан хөрөнгийн элэгдэл	-	-	269,361	30,997	-	-	-	300,358
2015 оны 12 сарын 31-нээрх дансны үнэ	145,418,730	1,651,996	9,196,189	4,248,756	1,485,371	424,076	14,193,628	176,618,746

Барилга байшингийн нэмэгдсэн дүнд Банкны 61,095,216 мянган төгрөгөөр худалдаж авсан төв оффисын барилга болон бусад салбар нэгжүүдийн барилгууд багтсан. Банк төв оффисын барилгыг холбоотой тал болох Адис Майнинг ХХК-с шударга зах зээлийн шинжтэй буюу тухайн үеийн зах зээлийн үнээр 2015 оны 06 дугаар сард худалдаж авсан (Тодруулга 40).

Монгол Улсын Улаанбаатар хотод байршилтай Юүдэнтас аудит ХХК –аар ахлуулсан 9-н хараат бус үнэлгээний компаниас бүрдсэн консорциум 2013 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар барилга байгууламжийг дахин үнэлсэн. Консорциум нь зүй ёсны мэргэжлийн зэрэгтэй бөгөөд ойролцоо төрлийн хөрөнгийг үнэлж байсан туршлагатай. Улаанбаатар болон бусад хотод байршилтай барилга байгууламжийг үнэлэх гол суурь нь зах зээлийн үнэ цэнэ ба хөдөө орон нутагт орлуулах үнийг ашигладаг. Хөрөнгийн үнэлгээг хийх хямдруулсан мөнгөн гүйлгээний аргыг ашиглахад

шаардлагатай мэдээлэл хангалтгүй байдаг тул ойролцоо төрлийн хөрөнгийн зах зээлийн үнийг ашиглах нь зөв гэж үзсэн. 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр хөрөнгийн өртгөөс хуримтлагдсан элэгдлийг хассан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн бол 137,574,591 мянган төгрөгийн (2014: 51,716,819 мянган төгрөгийн) өртөгтэй байх байсан.

Барилга байшингийн дансны үнийн задаргааг дор харуулав:

	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Мянган төгрөгөөр		
Санхүүгийн байдлын тайланд барилга байшингийн дахин үнэлсэн дүн	145,418,730	59,928,997
Өөрийн хөрөнгөд тусгасан дахин үнэлгээний сан	(7,476,100)	(7,844,139)
Хуримтлагдсан ашиг руу шилжсэн дахин үнэлгээний сан	(368,039)	(368,039)
Хуримтлагдсан элэгдлийг хассан барилга байгууламжийн өртөг	137,574,591	51,716,819

19 Өмчлөх бусад хөрөнгө

	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Мянган төгрөгөөр		
Бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө	50,133,051	-
Өртгөөр бүртгэгдсэн санхүүгийн бус хөрөнгө	51,717,714	9,196,483
Хасах: Үнэ цэнийн бууралтын сан	(1,755,861)	(880,992)
Нийт өмчлөх бусад хөрөнгө	100,094,904	8,315,491

Бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө нь Банкны хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг барагдуулах явцад авсан Бурхан Дэл Алт ХХК болон Смарт Тренд ХХК-ийн хувьцааг илэрхийлэх ба түүний үнэ цэнэ нь эдгээр компаниудын хөрөнгийг зарж борлуулснаар эргэн нөхөгдөнө.

Мөн 2014 онд Хонг Конгийн Хөрөнгийн Бирж дээр арилжаалагдаж буй Монгол Улсад бүртгэлтэй компанийн хувьцааг зарснаар 3,257,517 мянган төгрөгийн олзыг ашиг алдагдлын тайланд борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтаас үүссэн цэвэр олз/гарзад хүлээн зөвшөөрсөн.

Өртгөөр бүртгэгдсэн санхүүгийн бус хөрөнгө нь хугацаа хэтэрсэн зээлийн үүргийг хангуулахаар хураан авсан буюу түүний борлуулалтаас зээлийг эргэн төлүүлэхээр зорилготой юм. Дээрх үнэ цэнэ бууралтын сан нь зөвхөн санхүүгийн бус хөрөнгөтэй холбоотой. Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар тодруулга 4.31-ээс үзнэ үү.

Санхүүгийн бус хураан авсан барьцаа хөрөнгийн үнэ цэнийн бууралтын санд 2015 болон 2014 онд гарсан өөрчлөлтүүдийг дор үзүүлэв:

	2015	2014
Мянган төгрөгөөр		
1 сарын 01-нээрх өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан	880,992	523,310
Тухайн жилд байгуулсан үнэ цэнэ бууралтын сан	950,575	440,287
Төлөгдөхгүй гэж үзээд данснаас хассан	(75,706)	(82,605)
12 сарын 31-нээрх өмчлөх бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан	1,755,861	880,992

Өмчлөх бусад хөрөнгө нь хугацаа хэтэрсэн зээлийн оронд хураагдсан барьцаа хөрөнгө болох үл хөдлөх хөрөнгийг илэрхийлнэ. Банкны зүгээс эдгээр хөрөнгийг ойрын хугацаанд зарж борлуулах төлөвлөгөөтэй байгаа. Эдгээр хөрөнгө нь худалдахад бэлэн эргэлтийн бус хөрөнгийн шаардлагыг хангаагүй бөгөөд НББОУС 2 “Бараа материал”-ын дагуу бараа материалд ангилагдсан. Эдгээр хөрөнгийг анх хураахад бодит үнээр хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх дүн нь Группийн болон Банкны дүнг илэрхийлж буй тул тусдаа тодруулга шаардлагагүй.

Голомт Банк Групп

20 Бусад банкуудын байршуулсан хөрөнгө

	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Мянган төгрөгөөр		
Бусад Банкуудын байршуулсан богино хугацаат хөрөнгө	82,002,849	27,038,904
Бусад Банкуудын байршуулсан урт хугацаат хөрөнгө	7,997,821	106,307,760
Нийт бусад банкуудын байршуулсан хөрөнгө	90,000,670	133,346,664

Бусад банк санхүүгийн байгууллагуудын харилцах, хадгаламж нь дотоодын болон гадаадын банкуудын Банкинд гадаад болон дотоод валютаар үүсгэсэн харилцах данс болон хугацаатай хадгаламжуудаас бүрдэнэ. 2014 оны 12 дугаар сарын 31-тэй харьцуулбал бусад банкуудын байршуулсан хөрөнгө буурсан ба үүнд 2015 оны 01 дүгээр сард хугацаа нь дууссан дотоодын Банкны 40 сая ам.долларын хугацаатай хадгаламж нөлөөлсөн.

2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр богино хугацаат харилцах, хадгаламжид дотоодын болон гадаадын банкуудаас байршуулсан жилийн 1.2-7.5 хувийн хүүтэй (2014: 2.0-5.8 хувийн хүүтэй) 7-91 хоногийн анхны дуусах хугацаатай (2014: 6-77 хоногийн хугацаатай) харилцах, хадгаламжууд орно.

Бусад банкуудаас байршуулсан хөрөнгийн ангилал бүрийн бодит үнэ цэнийн задаргааг Тодруулга 38-с үзнэ үү. Тодруулга 34-т валютын, хүүний болон төлөгдөх хугацааны шинжилгээг харуулсан.

Группийн болон Банкны дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

21 Харилцагчийн харилцах, хадгаламж

	Групп		Банк	
	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Мянган төгрөгөөр				
Төрийн болон хувьцаат компани	168,050,748	109,226,946	168,050,748	109,226,946
- Харилцах данс	67,034,331	76,135,907	67,034,331	76,135,907
- Хугацаагүй хадгаламж	42,350,036	22,293,241	42,350,036	22,293,241
- Хугацаатай хадгаламж	58,666,381	10,797,798	58,666,381	10,797,798
Аж ахуйн нэгж	523,711,238	847,847,785	523,711,258	848,034,086
- Харилцах данс	354,736,333	529,804,588	354,736,353	529,980,889
- Хугацаагүй хадгаламж	25,944,869	28,329,097	25,944,869	28,339,097
- Хугацаатай хадгаламж	143,030,036	289,714,100	143,030,036	289,714,100
Хувь хүмүүс	1,366,537,181	1,251,639,366	1,366,508,836	1,251,639,366
- Харилцах данс	77,949,726	93,938,972	77,921,381	93,938,972
- Хугацаагүй хадгаламж	290,801,245	352,483,744	290,801,245	352,483,744
- Хугацаатай хадгаламж	997,786,210	805,216,650	997,786,210	805,216,650
Бусад	21,529,752	23,369,188	21,529,752	23,369,188
- Харилцах данс	10,500,043	14,317,714	10,500,043	14,317,714
- Хугацаагүй хадгаламж	1,145,985	2,994,696	1,145,985	2,994,696
- Хугацаатай хадгаламж	9,883,724	6,056,778	9,883,724	6,056,778
Нийт харилцагчийн харилцах, хадгаламж	2,079,828,919	2,232,083,285	2,079,800,594	2,232,269,586

Монгол Улсын Иргэний хуулийн дагуу Банк нь харилцах, хадгаламж эзэмшигч иргэдэд хадгалуулагчийн мөнгийг шаардсан үед нь эргүүлэн төлөх үүрэг хүлээсэн байдаг. Хэрэв хугацаатай хадгаламжийг хугацааны өмнө буцаан татсан тохиолдолд гэрээнд өөрөөр заагаагүй бол Банк хүүг хугацаагүй хадгаламжийн хүүгийн түвшнээр тооцож олгоно.

Одоогийн байдлаар удирдлага харилцагчдын харилцах, хадгаламжийг эдийн засгийн салбарын төвлөрөлтөөр нь хянадаггүй. Иймээс үүнтэй холбоотой мэдээллийг эдгээр санхүүгийн тайлангуудад тусгаагүй. 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 30 том харилцагчаас байршуулсан хөрөнгийн нийт дүн 482,149,570 мянган төгрөг (2014 оны 12 дугаар сарын 31: 635,381,863 мянган төгрөг) бөгөөд нийт харилцах хадгаламжийн 23 хувь (2014 оны 12 дугаар сарын 31: 29 хувь)-ийг бүрдүүлж байсан.

Охин компаниас байршуулсан 34,977 мянган төгрөг (2014: 186,299 мянган төгрөг) нь Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд устгагдсан.

2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр буцаах эрхгүй Банкны баталгаа болгон 10,041,027 мянган төгрөг (2014 оны 12 дугаар сарын 31: 14,112,014 мянган төгрөг) харилцагчдаас байршуулсан байсан. Дэлгэрэнгүйг тодруулга 36-аас харна уу.

22 Зээлийн бусад эх үүсвэр

Мянган төгрөгөөр	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
(а)		
Төслийн зээлийн эх үүсвэр /Төгрөг/	475,890,342	959,036,160
Төслийн зээлийн эх үүсвэр /Доллар/	1,706,171	6,070,000
Төслийн зээлийн эх үүсвэр /Евро/	1,158,211	857,925
Нийт төслийн зээлийн эх үүсвэр	478,754,724	965,964,085
(б)		
Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр		
Гадаадын Банкнаас авсан эх үүсвэр /Доллар/	199,659,254	-
Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан худалдааны эх үүсвэр		
Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр /Доллар/	88,668,903	42,317,394
Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр /Евро/	299,685	944,876
Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр /Юань/	2,458,416	2,272,673
Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр	291,086,258	45,534,943
(г)		
Монголбанкнаас авсан эх үүсвэр /Төгрөг/	245,093,973	-
Нийт (а+б+г)	1,014,934,955	1,011,499,028

Голомт Банк Групп

22 Зээлийн бусад эх үүсвэр (үргэлжлэл)

(а) Төслийн зээлийн эх үүсвэрүүд

	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Мянган төгрөгөөр		
Төслүүд		
Орон сууцны санхүүжилтийн төслийн эх үүсвэр	693,885	1,152,887
Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах төслийн эх үүсвэр	22,108,616	23,323,236
Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих сангийн эх үүсвэр	36,671,384	32,812,235
Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих сангийн эх үүсвэр	4,333,089	7,408,683
40,000 айлын орон сууц хөтөлбөрийн эх үүсвэр	52,114	76,934
Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн зээлийн эх үүсвэр	-	26,686,936
Хөдөө Аж Ахуйн Хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	793,915	4,239,088
Хувийн хэвшлийг хөгжүүлэх төсөл-2, төгрөг, доллар	628,742	1,073,412
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих төслийн эх үүсвэр	41,204,480	39,011,738
Хүлэмжийн аж ахуйг дэмжих төсөл	26,360,050	27,688,111
Ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл	48,022,000	54,434,877
Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл	3,610,600	11,355,830
Ноолууран бүтээгдэхүүний технологийг шинэчлэх төсөл	102,264,240	109,760,864
КФВ Банкны төслийн эх үүсвэр	5,557,120	4,830,150
Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах төслийн эх үүсвэр	-	46,038
Нөөцийн мах бүрдүүлэх төслийн эх үүсвэр	1,028	14,043,484
Эрчимжүүлсэн мал аж ахуйн үйлдвэрийг дэмжих, зоорь агуулахыг нэмэгдүүлэх төслийн эх үүсвэр	18,502,700	28,528,826
Орон сууцны үнэ тогтворжуулах төслийн эх үүсвэр	3,567,865	11,086,604
Орон сууц, барилгын салбарыг дэмжих төсөл	-	30,000,000
Цемент, арматурын нөөц бий болгох төсөл	-	535
Орон сууцны зээлийн эх үүсвэр	102,504,132	469,024,994
Нүүрсний нөөц бүрдүүлэх төслийн эх үүсвэр	-	12,770,356
Барилгын салбарыг дэмжих	1,503,288	2,004,658
Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төслийн эх үүсвэр	33,478,823	27,376,936
ҮХААЯам-арьс шир боловсруулах төслийн эх үүсвэр	23,697,726	17,257,211
Өргөн хэрэглээний импортын бараа бүтээгдэхүүний өртөгийг бууруулах төслийн эх үүсвэр	-	9,238,987
Бусад төслийн зээлийн эх үүсвэр	3,198,927	730,475
Нийт	478,754,724	965,964,085

Монгол Улсын Засгийн газар, Төв Банк болон гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэрийн гол нөхцөлүүдийг дор дурьдав:

Тодруулга 3-д үзүүлсний дагуу эдгээр зээлийн эх үүсвэрийн дийлэнх нь Монгол Улсын Засгийн Газрын эсвэл зээл олгогчийн тодорхойлсон тусгай зориулалттай (хөнгөлттэй нөхцөлтэй зээлийг зорилтод харилцагчдад олгох) зээлүүд байдаг. Иймээс эдгээр эх үүсвэрийн хүүний хувь нь бага буюу Банк нь өөр зээлдэгчээс энгийн нөхцөлөөр эх үүсвэр татах хүүнээс доогуур байдаг. Эдгээр зээлсэн бусад эх үүсвэрүүдийн ихэнх нь жилийн 0.9-өөс 6 хүртэлх хувийн хүүтэй, харин эдгээр эх үүсвэрээс олгож буй зээлүүдийн ихэнх нь жилийн 3.8-аас 9 хүртэлх хүүтэй байдаг. Удирдлагын зүгээс эдгээр зээлсэн эх үүсвэрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн олзгыг хүлээн зөвшөөрөх эсэхийг бодож үзсэн ба тусгай зах зээлийн шинжийг хангаж байгаа учраас эдгээр эх үүсвэр болон харилцагчид олгосон зээлээс ямар нэгэн анхны хүлээн зөвшөөрөлтийн олз гарз бүртгэгдэхгүй гэж үзсэн. Удирдлагын үнэлэмжийн талаар тодруулга 3-аас үзнэ үү. Томоохон хөтөлбөрүүдэд Монголбанкны санхүүжилттэй Стратегийн импортын санхүүжилтийн схем (СИСС), Хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах (ХБҮТ) болон Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах ба орон сууцны зээлийн хөтөлбөрүүд, мөн Монгол улсын эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө бүхий салбарт (эдийн засгийг тэлэх) зориулсан Монгол Улсын хөгжлийн Банкны санхүүжилт зэрэг багтана. Эдгээр хөтөлбөрүүдийг дор товчхон дурьдвал:

Гол нэрийн бараа бүтээгдэхүүн болон хүнсний нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хамтарсан санамж бичигт Монгол улсын засгийн газар болон Монголбанк 2012 оны 10 дугаар сарын 22-нд гарын үсэг зурсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Банк нь 2012 оны 12 дугаар сарын 10-нд Түлшний үнийг тогтворжуулах, 2012 оны 12 дугаар сарын 24-нд хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, 2013 оны 05 дугаар сарын 07-нд Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах тухай гэрээг Монголбанктай тус тус байгуулав. Түлшний үнийг тогтворжуулах болон хүнсний бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах зээлийн хүү жилийн 0.89 хувь бөгөөд

Банк хөтөлбөрт хамрагдсан талуудад зээлийн эх үүсвэрийг жилийн 3.8 хувиар дамжуулан олгох юм. Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах зээлийн хүү нь жилийн 2.5-4 хувь бөгөөд Банк хөтөлбөрт хамрагдсан талуудад жилийн 5.5-7 хувийн хүүтэйгээр дамжуулан зээлдүүлнэ. Гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу Банк эх үүсвэрээ заасан хугацаанд Монголбанкинд төлж чадахгүй бол Монголбанк өөрт байршиж буй Банкны данснаас шууд суутгах эрхтэй.

Орон сууцны зээлийг санхүүжүүлэх засгийн газрын хөтөлбөрийн дагуу Банк 2015 болон 2014 онд хүрээнд 4%-ийн хүүтэй эх үүсвэрийг Монголбанкнаас хүлээн авсан. Энэ хөтөлбөрт тусгай шаардлага хангасан (80 квадрат метрээс бага хэмжээтэй байр, худалдан авах үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх урьдчилгаа, тухайн Банк болон бусад Банкн дахь зээлийн түүх сайн гэх мэт) шинэ болон хуучин олгогдсон зээлүүд хамрагдах боломжтой. Ийнхүү Банк нь зээлдүүлэгчийн шаардлагыг хангасан зээлдэгч нарт 8 хувийн хөнгөлөлттэй зээлийг олгох боломжтой болсон ба энэхүү хүүний түвшнийг Монголбанкнаас тогтоож өгсөн тул олгож буй зээлийн хүүг Банк тодорхойлох эрхгүй гэсэн үг. Хөтөлбөрийн дагуу олгогдох зээлийн саналыг болон 8 хувиас доош олгосон дахин санхүүжилтийг Банкнаас хэлэлцэж батлах ба эрсдлийг мөн үүрэх юм.

Дээрх хөтөлбөрүүдээс гадна 2013 онд Банк нь барилгын салбарыг санхүүжүүлэх засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд Монголбанкнаас санхүүжилт авсан. Эдгээр нь Монголын зах зээл дээрх зээлдэгч нараас авах эх үүсвэрээс бага хүүтэй буюу жилийн 7 хувийн хүүтэй төгрөгийн эх үүсвэр байсан. Хэдийгээр эдгээр эх үүсвэрийг тодорхой шаардлага хангасан (орон сууцны барилга барьж буй Монголбанкны харьцааны шаардлагыг хангасан компаниуд) орон сууцны барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниудад олгох шаардлагатай ч энэ хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн хүүг Банк дангаараа тогтоох эрхтэй. Тиймээс энэ хөтөлбөртэй холбоотой зээлийн хүү нь зах зээлийн хүүгээс хол ялгаагүй буюу Банкны бусад эх үүсвэр ашиглан олгосон зээлийн хүүтэй ойролцоо юм. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн хүүг Банк тогтоох эрхтэй бөгөөд холбогдох зээлийн хүү нь барилгын зээлийн зах зээлийн хүүгээс их зөрүүгүй. Өөрөөр хэлбэл Банк өөр эх үүсвэр ашиглан олгосон бусад зээлийн хүүтэй ойролцоо байна.

Тиймээс тусгай нөхцөл, болзолтой тул (зээл олгох тусгай урьтал нөхцөл, буцаан төлөх болон ашиглаагүй эх үүсвэрт хамгийн өндөр хүү төлөх шаардлага, Засгийн газрын зуучлагчийн үүргийг Монголбанк гүйцэтгэж буй гэх мэт) НББОУС 20-ын дагуу энэхүү зээл нь засгийн газрын хөнгөлөлтийн нөхцөлийг хангаж байна. Засгийн газрын хөнгөлөлттэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүйг тодруулга 4-өөс харна уу. 2015 онд Засгийн газрын хөнгөлөлтийн үлдэгдэл төлөгдөж дууссан (2014 оны 12 дугаар сарын 31: 943,253 мянган төгрөг).

Удирдлагын зүгээс эдгээр дүнгийн материаллаг байдлыг уг тайлангийн хэрэглэгчдийн өнцгөөс хараад тусдаа байдлаар Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын тайлант тусгах шаардлагагүй гэж үзсэн.

Банк Монгол Улсын Хөгжлийн Банкнаас (МУХБ) хэрэгжүүлж буй засгийн газраас санхүүжүүлж байгаа хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хөтөлбөрт оролцож байгаа. 2013 оны 08 дугаар сарын 15-нд хүлэмжийн аж ахуйн, сүү сүүн бүтээгдэхүүний, оёдлын, ноолууран бүтээгдэхүүн болон ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг жижиг дунд бизнесийг санхүүжүүлэх зорилготой хөтөлбөрийн хүрээнд Банк нь МУХБ-тай хамт гэрээнд гарын үсэг зурсан. Энэ гэрээний дагуу Банк жилийн 5.13-аас 5.7 хүртэл хувийн хүүтэй эх үүсвэр авч Монгол улсын Хөгжлийн Банкны гэрээнд заасан жилийн 8% хувийн хүүтэй зээлийг харилцагчдад олгосон. Банк нь энэхүү зээлийн эрсдлийг үүрдэг.

2014 оны 7 дугаар сараас хойш Банк нь Монгол Улсын Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй "Арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих" зорилготой засгийн газрын өөр нэг төсөлд оролцож байна. Энэхүү хөтөлбөрийн нөхцлийн дагуу Банк нь уг эх үүсвэрийг МУХБ-наас жилийн 5 хувиар авж, харилцагчдад жилийн 7 хувиар олгодог. Бүх зээлдэгчдийг Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас батал ба Банк нь энэхүү зээлийн эрсдлийг үүрдэг.

Түүнчлэн Банк Монгол улсын Хөгжлийн Банк болон арилжааны Банкуудаар дамжуулан "Монгол улсын экспортыг дэмжих, импортыг орлох зорилготой 888 хөтөлбөр"-ийг санхүүжүүлэх Засгийн газрын төсөлд оролцож байгаа. Энэ гэрээний дагуу Банк нь 5 жилийн хугацаатай жилийн 3-аас 5 хүртэлх хувийн хүүтэй эх үүсвэр авч жилийн 7-оос 9 хувийн таатай хүүтэйгээр зээл олгож байна. Банк тогтоосон босго хүрээнд зээлийн хүүг тодорхойлох эрхтэй бөгөөд холбогдох зээлийн эрсдлийг хариуцна.

Банк 2015 онд Засгийн газрын Монгол Улсын Хөгжлийн Банкаар дамжуулан хэрэгжүүлж буй ноолуурын салбарыг санхүүжүүлэх хөтөлбөрт хамтран ажилласан. Уг хөтөлбөрийн хүрээнд Банк 3 хүртэлх жилийн хугацаатай 6 хувийн хүүтэй эх үүсвэрийг авч, зорилтод харилцагчдад 9 хувийн хүүтэйгээр зээл олгох эрхтэй.

Мөн засгийн газрын хэрэгжүүлж буй Монгол улсын экспортыг дэмжих, импортыг орлох зорилготой хөтөлбөрийн хүрээнд Банк Монгол улсын Хөгжлийн Банктай жижиг дунд бизнесийн төслүүдийг дэмжих гэрээнд гарын үсэг зурсан. Уг хөтөлбөрийн хүрээнд Банк жилийн 6 хувийн хүүтэй, 2019 оны 03 дугаар сарын 05 хүртэлх хугацаатай эх үүсвэрийг авсан. Банк зорилтод харилцагчдад зээл олгохдоо жилийн 9 хувь хүртэлх хүүг тогтоох эрхтэй.

АХБ-аас авсан эх үүсвэрт биелүүлэх шаардлагатай гэрээгээр хүлээсэн үүрэг байсан ба 2015 оны 12 дугаар сарын 31 болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар эдгээр биелүүлэх шаардлагатай гэрээгээр хүлээсэн үүрэг зөрчигдөөгүй байсан.

Голомт Банк Групп

22 Зээлийн бусад эх үүсвэр (үргэлжлэл)

(а) Төслийн зээлийн эх үүсвэр (үргэлжлэл)

категори	Зээл олгогч	Төслийн нэр	Валют	Олгосон огноо	Дуусах огноо	2015.12.31 – нээрх зээлийн дүн /тухайн валютаар/	2015.12.31 – нээрх зээлийн дүн /мянган төгрөгөөр/
/төгрөгөөр/	Монголбанк	Бусад төслийн зээлийн эх үүсвэр (АХБ - Ажлын байр нэмэгдүүлэх)	MNT	5/7/2001	5/7/2018	2,747,900	2,747,900
	Монголбанк	КФВ Банкны төслийн эх үүсвэр	EUR	12/11/2012	12/11/2017	531	1,157,930
	Монголбанк	КФВ Банкны төслийн эх үүсвэр	MNT	5/16/2013	5/16/2018	4,390,611	4,390,611
	Монголбанк	Эрчимжүүлсэн мал аж ахуйн үйлдвэрийг дэмжих төсөл	MNT	12/19/2013	12/19/2017	6,448,333	6,448,333
	Монголбанк	Барилгын салбарыг дэмжих, чулуунцар, клинкер төсөл	MNT	11/1/2014	11/1/2016	1,500,000	1,500,000
	Монголбанк	Орон сууцны үнэ тогтворжуулах төсөл	MNT	5/3/2013	7/30/2016	3,558,606	3,558,606
	Монголбанк	Зоорь агуулахыг нэмэгдүүлэх төсөл	MNT	12/19/2013	12/19/2017	12,039,238	12,039,238
	Монголбанк	Орон сууцны зээлийн эх үүсвэр	MNT	6/14/2013	12/15/2016	102,492,900	102,492,900
Монгол Улсын Хөгжлийн Банкны төслүүд	Монгол Улсын Хөгжлийн Банк	Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төслийн эх үүсвэр /2 тэрбум-с доош/	MNT	8/28/2014	8/28/2019	6,855,700	6,855,700
	Монгол Улсын Хөгжлийн Банк	Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төслийн эх үүсвэр /2 тэрбум-с дээш/	MNT	9/1/2014	8/28/2019	22,605,755	22,605,755
	Монгол Улсын Хөгжлийн Банк	Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл	MNT	8/12/2013	12/1/2017	3,610,600	3,610,600
	Монгол Улсын Хөгжлийн Банк	Хүлэмжийн аж ахуйг дэмжих төсөл	MNT	8/12/2013	12/1/2017	26,360,050	26,360,050
	Монгол Улсын Хөгжлийн Банк	Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих төсөл	MNT	8/12/2013	12/1/2017	38,447,864	38,447,864
	Монгол Улсын Хөгжлийн Банк	Ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл	MNT	8/12/2013	12/1/2017	48,022,000	48,022,000
	Монгол Улсын Хөгжлийн Банк	Ноолууран бүтээгдэхүүний технологийг шинэчлэх төсөл	MNT	8/12/2013	12/1/2017	102,264,240	102,264,240
	Монгол Улсын Хөгжлийн Банк	ҮХААЯам-арьс шир боловсруулах төслийн эх үүсвэр	MNT	8/22/2014	8/22/2019	23,674,709	23,674,709
	Монгол Улсын Хөгжлийн Банк	Ноолуурын салбарыг дэмжих төсөл	MNT	6/15/2015	12/15/2016	2,000,000	2,000,000
	Монгол Улсын Хөгжлийн Банк	Экспортыг дэмжих, импортыг орлох /300 тэрбум хүртэлх/	MNT	9/28/2015	9/28/2020	2,000,000	2,000,000

категори	Зээл олгогч	Төслийн нэр	Валют	Олгосон огноо	Дуусах огноо	2015.12.31 – нээрх зээлийн дүн /тухайн валютаар/	2015.12.31 – нээрх зээлийн дүн /мянган төгрөгөөр/
Монгол Улсын Засгийн газар болон ЖАЙКА-н хамтарсан төсөл	ЖАЙКА	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	USD	9/29/2006	12/31/2019	463	924,801
	ЖАЙКА	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	MNT	6/12/2009	12/31/2017	21,122,879	21,122,879
	Дэлхийн Банк	Хувийн хэвшилийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр-2 /төгрөг/	MNT	10/18/2007	12/20/2017	280,000	280,000
	Дэлхийн Банк	Хувийн хэвшилийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр-2 /доллар/	USD	12/20/2012	9/20/2016	161	321,353
Бусад Засгийн газрын төслүүд	Засгийн Газар	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	MNT	9/29/2006	12/31/2019	17,851,789	17,851,789
	Засгийн Газар	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	MNT	7/10/2012	12/31/2017	10,611,200	10,611,200
	Засгийн Газар	Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжих сангийн эх үүсвэр	MNT	1/4/2012	12/4/2018	4,325,901	4,325,901
	Засгийн Газар	40,000 айлын орон сууц хөтөлбөрийн эх үүсвэр	MNT	2/27/2008	3/15/2019	46,886	46,886
	Засгийн Газар	АХБ - Орон сууцны санхүүжилтийн төслийн эх үүсвэр	MNT	11/1/2008	11/1/2017	649,017	649,017
	Засгийн Газар	Хөдөө Аж Ахуйн Хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн эх үүсвэр	MNT	6/13/2011	12/13/2019	793,915	793,915
	Засгийн Газар	Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийн эх үүсвэр	MNT	6/12/2015	3/5/2019	8,108,349	8,108,349
	Засгийн Газар	Гадаадын Банкнаас авсан сургалтын зээлийн төслийн эх үүсвэр	USD	11/12/2009	5/1/2027	225	449,519

(б) Гадаадын Банк санхүүгийн байгууллагаас авсан эх үүсвэр

2015 оны 12 дугаар сарын 31-нээрх гадаадын Банкнаас авсан 199,659,254 мянган төгрөгийн эх үүсвэр нь 2015 оны 12 дугаар сарын 21-нд гадаадын Банкнаас авсан 18 сарын хугацаатай 100,000 мянган ам.долларын зээлийг илэрхийлнэ. Уг зээл нь Банкны тухайн Банкин дахь харилцах дансаар баталгаажсан. Дэлгэрэнгүйг тодруулга 10-с үзнэ үү.

Банк нь өөрийн харилцагчдын худалдааны зээлийг санхүүжүүлэх зорилгоор гадаадын Банк болон санхүүгийн байгууллагаас худалдааны зээлийн эрх авсан. 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 91,427,003 мянган төгрөгийн (2014 оны 12 дугаар сарын 31: 45,534,943 мянган төгрөг) зээлийн шугамыг ашиглаж мөн тэр хэмжээний зээлийг харилцагчдын импортын үйл ажиллагаанд зориулан олгосон байна. Ийм төрлийн эх үүсвэрийн хугацаа нь 3 хүртэлх жил байдаг бөгөөд харилцагчдын мөнгөн урсгал хийгээд гадаадын Банк санхүүгийн байгууллагад хийх эргэн төлөлтийн хугацаа нь таарч байна. Харилцагч зээлээ төлж чадахгүй тохиолдолд Банк зээлийн эрсдлийг хариуцдаг.

Бусад зээлийн эх үүсвэрийн задаргааг Тодруулга 38-с харна уу. Холбоотой талуудын гүйлгээг Тодруулга 40-д тусгасан. Бусад зээлийн эх үүсвэрийн валютын, зээлийн хүүний болон эргэн төлөгдөх хугацааны шинжилгээг Тодруулга 34-с харна уу.

Эдгээр эх үүсвэрүүд нь зээлийн хугацаанд ямар нэгэн биелүүлэх шаардлагатай санхүүгийн болон санхүүгийн бус хүлэсэн үүрэг байхгүй.

(в) Монголбанкнаас авсан эх үүсвэр

2015 оны 12 дугаар сарын 25-нд жилийн 14 хувийн хүүтэй, 3 хүртэлх сарын хугацаатай 245 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Монголбанкнаас авсан.

Группийн болон Банкны дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

23 РЕПО хэлцэл

2015 оны 12 дугаар сарын 31-ний дотоодын Банкуудаас авсан жилийн РЕПО хэлцэлд 13-15 хувийн хүүтэй (2014: 12-14 хувийн хүүтэй), 4-7 хоногийн хугацаатай (2014: 5-28 хоногийн хугацаатай) РЕПО хэлцлүүд орно. Эдгээр РЕПО хэлцлүүд нь Монголбанкны үнэт цаасаар бүрэн баталгаажсан. Дэлгэрэнгүйг тодруулга 13 болон 36-аас үзнэ үү.

Голомт Банк Групп

24 Бусад өр төлбөр

Бусад өр төлбөрийг дэлгэрэнгүй байдлаар дор үзүүлэв:

	Групп		Банк	
	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31	2015 оны 12 сарын 31	2014 оны 12 сарын 31
Мянган төгрөгөөр				
Бусад санхүүгийн өр төлбөр	8,808,463	23,439,867	8,787,403	23,356,806
Дансны өглөг	585,070	818,966	580,828	818,966
Гүйлгээний төлбөр	3,363,447	18,904,073	3,363,447	18,904,073
Бусад	4,859,945	3,716,828	4,843,128	3,633,767
Бусад санхүүгийн бус өр төлбөр	3,568,111	3,956,514	3,568,111	3,953,584
Ажилтнуудад өгөх өглөг	1,957,680	3,364,430	1,957,680	3,364,430
Орлогын албан татвараас бусад татварын өглөг	1,610,431	592,084	1,610,431	589,154
Нийт бусад өр төлбөр	12,376,574	27,396,381	12,355,514	27,310,390

Гүйлгээтэй холбоотой төлбөр нь 2015 оны 12 дугаар сарын сүүлчийн өдрүүдэд харилцагчийн хүсэлтийн дагуу хийгдсэн шилжүүлгийн гүйлгээ ба тэдгээр нь 2016 оны 01 дүгээр сард бусад Банкуудад шилжүүлэгдэнэ. Иймээс харилцагчийн данснаас гүйлгээний дүн нь хасагдаж бусад өр төлбөрийн хэсэг болох "Гүйлгээний төлбөр" тусгай дансанд 2015 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар орсон ба 2016 оны 01 дүгээр сард энэхүү гүйлгээ нь Банк хоорондын тооцоогоор хийгдэж дууссан.

2014 оны 12 дугаар сарын 31-тэй харьцуулахад бусад өглөг буурсан нь 2014 оны 12 дугаар сарын 31-ний дүнд том дүнтэй байнга хийгддэггүй гүйлгээний дүн багтсан байсантай холбоотой.

Бусад санхүүгийн өр төлбөрийн дийлэнх нь тайлант хугацаанаас хойш арван хоёр сарын дотор төлөгддөг ба бүх санхүүгийн бус өр төлбөр нь шинж чанарын хувьд богино хугацаатай байдаг.

25 Хоёрдогч өглөг

Мянган төгрөгөөр	2015	2014
Голомт Файнэншил Группээс авсан хоёрдогч өглөг	70,060,229	66,248,404
Нийт	70,060,229	66,248,404

Группийн болон Банкны дүн дээрх дүнтэй адил учир тусдаа тодруулга шаардлагагүй.

2015 оны 12 дугаар сарын 31-нээрх хоёрдогч өглөг:

	Дуусах огноо	Валют	Хуримтлагдсан Хүү хүү /ам.доллар/	Үлдэгдэл / ам.доллар/
Голомт Файнэншил Групп (I)	31/12/2018	Ам.доллар	6.0%	40,000
Голомт Файнэншил Групп (II)	08/12/2020	Ам.доллар	5.1%	60,667
Нийт				100,667
				35,000,000

Голомт Файнэншил Групп ХХК-с авсан хоёрдогч өглөг (I)

2007 онд Голомт Банк нь Кредит Свисс-ийн Сингапур улс дахь салбараас 5 жилийн хугацаатай, 10 сая ам.долларын хоёрдогч өглөгийг авсан. Зээлийн хугацаа 2012 оны 12 дугаар сарын 19-ны өдөр дууссан бөгөөд энэ өдрөөр зээл нь хувьцаанд хөрвөөгүй эсвэл эргэн төлөгдөөгүй байсан.

2013 оны 12 дугаар сарын 31-ны өдөр Кредит Свисс-н хоёрдогч өглөгийг Бодь Интернэшнл ХХК-д шилжүүлэх гэрээний нэмэлт өөрчлөлт дээр компаний гол хувьцаа эзэмшигч болох Бодь Интернэшнл ХХК болон Голомт Банк ХХК гарын үсэг зурсан. Шилжүүлэх гэрчилгээн дээр 2014 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Голомт Банк, Бодь Интернэшнл ХХК, Кредит Свисс Ай Жи буюу Сингапур улс дахь салбар гарын үсэг зурснаар Бодь Интернэшнл ХХК буюу Банкны гол хувьцаа эзэмшигч нь 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Шилжүүлэх тохиролцлын гэрээний дагуу Кредит Свисс-с авсан хоёрдогч өглөгийг худалдаж авсан.

Кредит Свисс-н хоёрдогч өглөгийн зээлийн гэрээнд зээлдэгч нь хүссэн үедээ урьдчилан тохирсон худалдаж авах үнээр зээлийг энгийн хувьцаа руу хөрвүүлж болох нөхцөл болон санхүүгийн заавал биелүүлэх гэрээний нөхцөлүүдтэй байсан ба Бодь Интернэшнл ХХК-тай хийсэн хоёрдогч өглөгийн гэрээний хувьд энгийн хувьцаа руу хөрвүүлэх болон гэрээний заавал биелүүлэх нөхцөлүүдийг гэрээний өөрчлөлтөөр хассан.

Гэрээний гол нөхцөлүүд:

- (а) Зээлийн хүү нь жилийн 6%.
- (б) Зээл нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр үндсэн дүн болон хуримтлагдсан хүүний хамт төлөгдөнө.

2014 оны 07 дугаар сарын 07-нд Банкны эзэмшлийг Голомт Файнэншил Групп ХХК-руу шилжүүлсний дагуу уг хоёрдогч өглөгийг мөн Банкны шинэ толгой компани болох Голомт Файнэншил Групп ХХК-руу шилжүүлсэн.

Голомт Файнэншил Групп ХХК-с авсан хоёрдогч өглөг (II)

2010 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Банк нь Абу Даби Инвестментс Консулын 100% эзэмшлийн Стэнхөп Инвестментсээс 5 жилийн хугацаатай 25 сая ам.долларын хөрвөх зээлийг дараах нөхцөлтэйгээр авсан.Үүнд:

- Зээлийн хүү нь ЛИБОР дээр 4.5%-ийг нэмсэнтэй тэнцэх хүүтэй байх ба улирал бүр төлөгдөнө.
- Стэнхөп Инвестментс нь зээлийн гэрээний хугацаанд хүссэн үедээ уг зээлийг урьдчилан тохирсон худалдах, худалдан авах үнээр Банкны энгийн хувьцааруу хөрвүүлэх эрхтэй.
- Хэрэв гэрээнд тусгасан санхүүгийн болон санхүүгийн бус шаардлагуудыг биелүүлээгүй тохиолдолд Стэнхөп Инвестментс нь Банкнаас зээлийг эргүүлэн төлөхийг шаардах эрхтэй.

Гэрээний нөхцөл дээр үндэслэн 2013 оны 12 дугаар сарын 31-нд Банк нь агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглэлийн бодит үнэ цэнийг 962,305 мянган төгрөг гэж санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн.

2014 оны 04 дүгээр сарын 30-нд шилжүүлэх гэрчилгээн дээр Бодь Интернэшнл ХХК, Голомт Банк ХХК болон Стэнхөп Инвестментс гарын үсэг зурснаар Банкны толгой компани Бодь Интернэшнл ХХК уг зээлийг Стэнхөп Инвестментсээс худалдаж авсан. Бодь Интернэшнл ХХК-тай хийсэн хоёрдогч өглөгийн гэрээний хувьд энгийн хувьцааруу хөрвүүлэх болон биелүүлэх ёстой шаардлагуудыг гэрээний өөрчлөлтөөр хассан. Гэрээний нөхцөл дээр үндэслэн Банк нь агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглэлийн бодит үнэ цэнийн олз болох 962,305 мянган төгрөгийг 2014 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн.

2014 оны 07 дугаар сарын 07-нд Банкны эзэмшлийг Голомт Файнэншил Групп ХХК -руу шилжүүлсний дагуу уг хоёрдогч өглөгийг мөн Банкны шинэ толгой компани болох Голомт Файнэншил Групп ХХК-руу шилжүүлсэн.

Уг хоёрдогч өглөгийн хугацаа 2015 оны 06 дугаар сарын 08-нд дууссан ба Банк болон Голомт Файнэншил Групп гэрээний өөрчлөлтөд гарын үсэг зурснаар уг зээлийн дуусах хугацааг 2020 оны 12 дугаар сарын 08 болгож сунгасан.

Эдгээр хоёрдогч өглөгүүдэд биелүүлэх шаардлагатай санхүүгийн болон санхүүгийн бус хүлээсэн үүрэг байхгүй.

Хувьцааны тоо ширхэгээс бусад дүн нь Мянган төгрөгөөр	Нийт гаргасан хувьцаа	Энгийн хувьцаа	Нэмэгдэж төлөгдсөн капитал	Давуу эрхтэй хувьцаа	Нийт
2014 оны 01 сарын 01-нээр	25,907,593	25,907,593	42,322,298	16,388,100	84,617,991
Тайлант жилд гаргасан	309,500	309,500	877,123	9,390,800	10,577,423
Хувьцаанд суурилсан төлбөрийн нөөцөөс шилжүүлсэн	-	-	1,500,000	-	1,500,000
2014 оны 12 сарын 31-нээр	26,217,093	26,217,093	44,699,421	25,778,900	96,695,414
Тайлант жилд гаргасан	150,500	150,500	707,650	-	858,150
Хувьцаанд суурилсан төлбөрийн нөөцөөс шилжүүлсэн	-	-	1,176,486	-	1,176,486
2015 оны 12 сарын 31-нээр	26,367,593	26,367,593	46,583,557	25,778,900	98,730,050

Банкны гаргасан хувьцаат капиталын нэрлэсэн үнээр бүртгэгдсэн дүн нь 26,367,593 мянган төгрөг (2014: 26,217,093 мянган төгрөг) байсан.

Хувьцааны нэмэгдэл нь шинээр гаргасан хувьцааг борлуулахад нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн төлбөр юм.

Энгийн хувьцаа

2015 оны 12 дугаар сарын 31 байдлаар Банк нь нийт 26,367,593 ширхэг (2014 оны 12 дугаар сарын 31: 26,217,093) нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй (2014: 1000 төгрөг) энгийн хувьцаа гаргасан байсан. Гаргасан бүх энгийн хувьцаа нь бүрэн төлөгдсөн байсан.

2015 онд нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 150,500 хувьцааг ажилчдад олгосон ба нэг бүрийг нь 5,702 төгрөгөөр худалдан авах опционы хэрэгжилтээр гаргасан. Энгийн хувьцаа гаргахтай холбогдуулан 707,650 мянган төгрөгийг нэмэгдэж төлсөн капитал дансанд бүртгэсэн.

2015 оны 12 дугаар сарын 31 болон 2014 оны 12 дугаар сарын 31-нээрх хувьцаа эзэмшигчдийн хувийг доорх байдлаар харуулав:

Хувьцаа эзэмшигч	2015	2014
	Хувиар	Хувиар
Голомт Файнэншил Групп ХХК	83.76%	83.66%
СВИС МО Инвестмент Эй жи	9.98%	10.04%
Трафигура Бэхээр Би.ви	4.93%	4.96%
Ажилчдын хувьцаа	1.33%	1.34%
Нийт	100%	100%

Давуу эрхтэй хувьцаа

2013 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн давуу эрхийн хувьцаа гаргах хувьцаа эзэмшигчдийн шийдвэрийн дагуу 2013 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Голомт Банк болон Ноён Зоригт (Ноён Баясгалангийн бизнес хамтрагч) нарын хооронд давуу эрхтэй хувьцаа худалдах, худалдан авах гэрээ байгуулагдсан

Гэрээний дагуу Банкны давуу эрхтэй хувьцаанд олгож буй нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нь 15,000,000 ам.доллар бөгөөд хоёр үе шаттай хэсэгчилсэн төлбөр байна. (2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 10 сая ам.доллар мөн 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 5 сая ам.доллар). 2015 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар давуу эрхтэй хувьцааны нийт дүн 15,000,000 ам.доллар буюу 25,788,900 мянган төгрөгтэй тэнцэх 25,788,900 ширхэг давуу эрхтэй хувьцаа байна.

